



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-16
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	17-126
1.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудал	18-20 80-81
2.Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай асуудал	21-79 82-83
3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	83-84
4.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	84-85
5.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	85-91
6.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	91-94 125-126
7.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай /Монгол Улсын Ерөнхийлөгч 2025.12.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/	94-125

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 54.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, А.Ганбаатар, С.Лүндэг, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Тулга, Г.Хосбаяр;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ч.Анар, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, Г.Тэмүүлэн, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр;

Тасалсан: Х.Баттулга, Э.Болормаа, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: О.Алтангэрэл-06 минут, С.Амарсайхан-05 минут, Ц.Баатархүү-06 минут, М.Бадамсүрэн-03 минут, Б.Батбаатар-05 минут, Ж.Баярмаа-11 минут, Ж.Галбадрах-07 минут, Г.Ганбаатар-07 минут, С.Ганбаатар-08 минут, Х.Ганхуяг-14 минут, Ц.Даваасүрэн-15 минут, Т.Доржханд-20 минут, Б.Жаргалан-1 цаг 26 минут, Д.Жаргалсайхан-1 цаг 37 минут, Ч.Лодойсамбуу-04 минут, Г.Лувсанжамц-13 минут, Ц.Мөнхтуяа-06 минут, З.Мэндсайхан-18 минут, Ч.Номин-02 минут, С.Одонтуяа-02 минут, Б.Пунсалмаа-12 минут, Б.Түвшин-02 минут, А.Ундраа-22 минут, Г.Уянгахишиг-05 минут, Б.Энхбаяр-02 минут, Д.Энхтуяа-20 минут, М.Энхцэцэг-04 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүнээс 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүнээс 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 22 гишүүнээс 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингөөс 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /10:16/

Хоёр.Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигч С.Наранцогт оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нар танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Мөнхсоёл, Ц.Идэрбат, А.Ариунзаяа, Ц.Мөнхбат, Д.Бум-Очир, Л.Мөнхбаясгалан, О.Цогтгэрэл, П.Сайнзориг, Э.Бат-Амгалан, М.Ганхүлэг, Д.Пүрэвдаваа, С.Эрдэнэбат, С.Замира, Ж.Бат-Эрдэнэ,

Д.Ганбат, Б.Түвшин, Ч.Лодойсамбуу, Г.Ганбаатар, О.Номинчимэг, Б.Бейсен нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигч С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Мөнхсоёл, Ц.Идэрбат, А.Ариунзаяа, Ж.Батжаргал, Да.Цогтбаатар, Ж.Батсуурь, Б.Найдалаа, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, М.Ганхүлэг, Д.Пүрэвдаваа, С.Эрдэнэбат, Л.Соронзонболд, С.Замира, Ж.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан, Б.Заяабал, Лодойсамбуу, О.Алтангэрэл, О.Номинчимэг, Б.Бейсен, Т.Доржханд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 13 цаг 13 минутаас 13 цаг 41 минутад хуралдааныг даргалав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 38 минут үргэлжилж, 13 цаг 41 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 13 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 14 цаг 13 минутаас 14 цаг 42 минутад хуралдааныг даргалав.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэв.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх саналыг нууц санал хураалтаар явуулав.

Н.Учрал: Пүрэвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 29
Бүгд: 103
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:27/

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэв.

Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх саналыг нууц санал хураалтаар явуулав.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 21
Бүгд: 104
79.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

“Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:33/

Уг асуудлыг 14 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 47
Бүгд: 105
55.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх нар байлцав.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал ажлын 5 хоног завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дарга Н.Учрал ажлын 5 хоногийн завсарлага өгөв./14:37/

Тав. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх А.Болортуяа нар байлцав.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 31

Бүгд: 105

70.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр “хуралдааны тэмдэглэлд” тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 105 гишүүнээс 76 гишүүн дэмжиж, 72.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн

төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 29

Бүгд: 105

72.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79

Татгалзсан: 26

Бүгд: 105

75.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14 цаг 42 минутаас 16 цаг 16 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Б.Түвшин нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, О.Саранчулуун, С.Бямбацогт нар үг хэлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг

эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /15:08/

Найм.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ Хянан шалгах түр хорооны хуралдаан дуусаагүй байгааг мэдэгдэж, уг асуудлыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулав./15:09/

Ес.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай /Монгол Улсын Ерөнхийлөгч 2025.12.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын дэд захирал Б.Нямдаваг, Бодлогын газрын Дипломат сургалт, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Б.Мөнхбаяр, Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Г.Тэнгэр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Мөнхтөр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч

Г.Байгалмаа, Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч А.Баттөр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Г.Хулан, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Ж.Оюунбаатар, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Бямбадорж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Булган, Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Б.Мөнхжин, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Г.Батжаргал, Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Тэгшжаргал, Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Даваа, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Г.Уянга, Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч О.Лхагвасүрэн, Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Н.Энхтайван, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Ц.Мөнх-Оргил, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Б.Болормаа, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдад нэр дэвшигч А.Ананд, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Л.Өлзийт, Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч В.Оюу, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Баттөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон **Байнгын хорооны санал**, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, А.Ариунзаяа, П.Сайнзориг нарын тавьсан асуултад нэр дэвшигч Г.Тэнгэр, Д.Мөнхтөр, Г.Байгалмаа, А.Баттөр, Г.Хулан, Ж.Оюунбаатар, Д.Бямбадорж, Д.Булган, Б.Мөнхжин, Г.Батжаргал, Д.Тэгшжаргал, Д.Даваа, Г.Уянга, О.Лхагвасүрэн, Н.Энхтайван, Ц.Мөнх-Оргил, Б.Болормаа, А.Ананд, Л.Өлзийт, В.Оюу, Д.Баттөр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, М.Мандхай, Д.Бум-Очир, Р.Эрдэнэбүрэн, П.Сайнзориг, Л.Энх-Амгалан, С.Эрдэнэбат, Д.Ганмаа, С.Одонтуяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 16 цаг 16 минутаас 17 цаг 01 минутад хуралдааныг даргалав.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэн, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мижиддоржийн Цэнгэг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайхан, Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхагвасүрэнгийн Саянаа, Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жигжээгийн Сэрээжав, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бирваагийн Мандахбилэг, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Энхтүвшингийн Булган, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Нарантунгалаг, Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баттөмөрийн Энхсүх, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржийн Баярхүү, Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Ганхуяг, Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өлзийсайханы Энхтүвшин, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сосорбарамын Энхбаяр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гомбосүрэнгийн Мөнхбаяр, Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сайннямбуугийн Баатаржав, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Уламбаярын Нямхүү, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдины Гансүх, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатар, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Дамбажавын Ганболд, Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэн нарыг тус тус эгүүлэн татахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Учрал: 1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 28
Бүгд: 98
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Энхбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр “хуралдааны тэмдэглэлд” тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 98 гишүүнээс 72 гишүүн дэмжиж, 73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 26
Бүгд: 98
73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 24
Бүгд: 98
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хуланг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатарыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 24
Бүгд: 98
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчимбуугийн Бямбадоржийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 24
Бүгд: 98
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булганыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 27
Бүгд: 98
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжинг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 31
Бүгд: 98
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 24
Бүгд: 98
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 26
Бүгд: 98
73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянгыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 24
Бүгд: 98
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэнг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 28
Бүгд: 98
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Монгол Улсаас Унгар улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайванг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 27
Бүгд: 98
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 26
Бүгд: 98
73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Монгол улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Амгалангийн Анандыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийтийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 28
Бүгд: 98
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюуг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэхээр тогтов.

Уг асуудлыг 16 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон нар байлцав.

Н.Учрал: Байнгын хорооноос гаргасан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 48
Бүгд: 98
51.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул тогтоолын төслийг батлах санал хураалт явуулав.

Н.Учрал: “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 36
Бүгд: 98
63.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын урилгаар Дорнод аймгийн Баян-Уул сумын Өвөр эрээн багийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар нийслэлийн ЕБС-ын 184 дүгээр сургуулийн 12^а, 12^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн урилгаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захиргааны ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн Цаг уурын өртөөний ажилчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны урилгаар Төв аймгийн Зуунмод сумын ЕБС-ийн 11^а ангийн багш, сурагчид, нийслэлийн ЕБС-ын 13 дугаар сургуулийн гадаад хэлний багш нар Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 26 минут үргэлжилж, 126 гишүүнээс 105 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 03 минут**

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж мэндчилье. Гишүүдийн ирцийг танилцуулъя. 68 гишүүн буюу 54 хувиар ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 9 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

2 дугаарт, Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

3 дугаарт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

4 дүгээрт, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

5 дугаарт, Шинжлэх ухаан технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

6 дугаарт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

8 дугаарт, Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

9 дүгээрт, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанаар мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун нарын 24 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин нарын 22 гишүүн өргөн мэдүүлснийг 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсан болно.

Хэлэлцэх асуудалд оръё. Хэлэлцэх асуудалд орохоос өмнө мэндчилгээ танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбатын урилгаар Дорнод аймгийн Баян-Уул сумын Өвөр Эрээн багийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Дорнод аймгийнхаа Баян-Уул сумын иргэд та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урья.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооны Пүрэвээгийн Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөгдөх тухай хүсэлтээ Сонгуулийн төв

байгууллагын тухай хуульд заасны дагуу 2025 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсэн болно.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны Пүрэвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны дарга, гишүүнээс чөлөөлөхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байхыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Нарийн бичгийн дарга Даваанямын Даваа-Очирт даалгахаар тогтсон болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд. Баярлалаа.

Н.Учрал: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Нэрийг тасаллаа. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр өнгөрсөн 7 хоногт хагас сайн өдөр Говьсүмбэр аймгийн Баянтал, Шивээговь сумын иргэдтэй уулзалт хийсэн. Тэгээд энэ дээр Говьсүмбэр аймгийн Баянтал багийн 1 дүгээр багийн Гончигийн Алтан-Очир гэдэг хүн ер нь хоршоо цаасан дээр л байна. Банк л нэг юм хянаж байна. Өөр тэнд анхаарч байгаа нэг ширхэг ч хүн алга. Тэгээд хоршооны зээл авсан гишүүн болж баянаа дагаж ядуу нь авсан зээл авсан хүмүүс баларч дуусаж байна. Хоршооны зээл өрөнд оруулж дуусаж байна гэдэг ийм л зүйл хэлж байна. Хоршоо сайн байгаад байгаа юм бол энэ малчдын энэ суман дээр зараад байгаа тэр сүү нь сайжрахгүй хаана яваад байгаа юм бэ гэдэг ийм л зүйлийг тэр ахмад настан Алтан-Очир гуай ярьж байна.

Хоёрт нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1 дүгээр багийн иргэн Ламжавын Пүрэвээ гэдэг хүн, Чинбүрэн сайд танд бас зориулж үг хэлж байна. Тэр сахрын өвчтэй хүн заавал Чойр явж аймгийн төв орж байж тэгээд тэр нэг хямдралтай эмээ авдаг ийм юм чинь сайдын тушаалаар хэрэгжээд л байгаад байх юм. Тэрийгээ уул нь Их Хурал дээр ярихаар болгочихсон гэж яриад байдаг. Гэтэл амьдрал дээр энэ хүмүүсийг чирэгдүүлдэг, хөгшин ахмад настай хүмүүсийг сар болгон аймгийн төв оруулж мөнгө төгрөгийн зардал гаргадаг хэвээрээ л байгаа юм байна шүү дээ.

Жишээ нь Баян-Өлгийн Булганаас аймгийн төв орно гэдэг чинь аюулын л асуудал шүү дээ настай хүнд. Тэгээд ийм юмнуудаа шийдээч гэж хэлмээр байна.

Ер нь энэ сүүлийн үед ингээд дарга нар томилдог, чөлөөлдөг л ийм, эрх баригчтай боллоо. Хаа сайгүй л даргыг нэмэгдүүлсэн ийм л зүйлийг хийх юм. Ард түмний амьдрал хэцүү байж байхад дарга нарын тоог нэмээд л даажигнаад байгаа юм уу яагаад байгаа юм энэ чинь дэд сайд тавиад л, энэ чинь хүмүүсийн амьдрал хэцүү байна шүү дээ. Би энэ дараагийнх дээр нь үг хэлэх дээрээ хэлнэ. Энэ чинь 20 мянган аж ахуйн нэгж дампуурчихсан байна. 28 мянган аж ахуйн нэгж дансаа хаалгачихсан байж байна. Тэгээд дээрээс нь өнгөрсөн жил асар их өндөр төсөв батлагдсан энэ жил. Тэрнийхээ зардлыг гаргачхаад тэрний өрийг нь өгөхийн тулд яаж байна гэхээр 2.2 их наяд төгрөгийн гадаад бонд, 500 тэрбумын дотоод бонд, дээрээс нь 700 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ингээд нийтдээ 3.4 тэрбум төгрөгөөр бүх энэ өнгөрсөн хугацаанд энэ татвар төлөгчдийн төлөөгүй 3.5.../минут дуусав./

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, айн Пүрэвдорж гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Б.Пүрэвдорж: 3.4 их наяд төгрөгийн гадаад болон дотоод бонд гадаад зээл авч энэ мөнгөөрөө тэр татвар төлөгчдийн төлөөгүй байгаа тэр 3.5 их наяд төгрөгийн өрийг төлж байна шүү дээ. Өрөөр өрийг өрөөр ингээд төлөөд яваад байх юм уу? Энэ өр чинь 1 хүнд ноогдох нь бараг 50 тэрбум, 50 сая төгрөг хүрлээ шүү дээ. Ингэж хойч үедээ энэ баахан өр үлдээх юм уу? Тэгээд энэ дарга нар дарга нар томилж даажигнадгаа болиоч дээ. Энэ хүмүүсийн аж ахуйн нэгжүүд чинь ажил төрөл нь хэцүү, бизнес нь явахгүй. Энэ бүх зүйл чинь ирэх онд дахиад л үргэлжлээд явна шүү дээ. Зэс өндөр үнэтэй байгаа тулдаа л нэг та нар тэсэж байх шиг байна. Чилийн нэг үйлдвэр нурснаас болоод зэсийн үнэ өсөж байгаа, ирэх жил дахиад л өснө. Ийм байдлаар ерөөсөө энэ эдийн засгийг сайжруулах дээр ажил хийхгүй нэг хэдэн уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дээрээ л нэг жоохон дэнжгэнэсэн болоод тогтчихно шүү та нар.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалтыг явуулна. Гишүүдийг танхимд урья. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе.

Сонгуулийн ерөнхий хорооны Пүрэвээгийн Дэлгэрнаран өөрөө хүсэлт гаргасан. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Санал хураалтыг явуулна. Нууцаар санал хураана. Гишүүд бэлэн байдлыг хангая. Пүрэвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 9 цагаас хойш бас хуралдаад байгаа юм байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бас хуралдаж байна Энхтүвшин гишүүн ахлаад. Ингээд дараагийн асуудалдаа нэгтгээд саналыг хураагаад явъя даа. Ингээд дараагийн 2 дахь асуудалдаа нэгтгээд санал хураалтыг явуулъя. 2 дугаар асуудал руугаа шууд оръё. Хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлье.

10.16 цаг

Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хяналт шалгалтын хуулийн дагуу 14 хоногийн өмнө маягтыг батлаад Байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо Сэддорж дарга олон нийтийн оролцоог хангасан нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан. Сонсголд цахимаар иргэдийн ирүүлсэн санал, хүсэлтүүд, мөн сонсголд оролцогч нар бас хүсэлтээ гаргаад оролцогч нар асуултыг асуусан. Эдийн засгийн байнгын хороо хуулийнхаа дагуу бас өндөр түвшинд сонсгол зохион байгуулсанд Сэддорж даргад талархал илэрхийлье. Ингээд Эдийн засгийн байнгын хороон дээр сонсголын тайланг танилцуулсан. Энэ тайлангийн талаар Эдийн засгийн байнгын хороон дээр мэдээллийг хийсэн. Үүнтэй холбогдуулаад өнөөдөр Их Хурлын нэгдсэн чуулганаар Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох саналыг танилцуулна. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг мөн танилцуулахад бэлтгэе Сэддорж дарга.

Эхлээд Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох саналыг хуулийнхаа дагуу Улсын Их Хурлын дарга танилцуулдаг. Үүний дагуу та бүхэнд танилцуулгыг хийе.

Монголбанкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно гэж заасныг үндэслэн Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд томилуулахаар нэрийг нь дэвшүүлж байна.

Санжаагийн Наранцогт нь 1973 онд Дундговь аймагт төрсөн. МУИС-ийн Физик, математикийн сургуулийг 1990-94 онд бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн. 1999-2001 онд тус сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 2005-2008 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүлийн Үндэсний их сургуульд докторын зэрэг хамгаалсан. 1993-1997 онд Шинжлэх ухааны академийн Математикийн хүрээлэнд туслах, эрдэм шинжилгээний ажилтан. 1994-1997 онд Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн төвд инженер, ахлах инженер. 1997-2000 онд Монголын Нээлттэй нийгэм хүрээлэнд хөтөлбөрийн зохицуулагч, 2000-2003 онд “Ай Си” ХХК-д Ерөнхий менежер. 2003-2005 онд Санхүү, эдийн засгийн яаманд мэргэжилтэн хэлтсийн дарга. 2005-2008 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүлийн Үндэсний их сургуульд докторант. 2008-2012 онд БСШУЯ-нд газрын дарга. 2012-2015 онд Хөдөлмөрийн яаманд газрын дарга. 2015-2017 онд Сангийн яаманд газрын дарга. 2017-2021 онд Сангийн яаманд Төрийн нарийн бичгийн дарга. 2021-2022 онд Эдийн засаг, хөгжлийн дэд сайд. 2022 оноос одоог хүртэл “Эрдэнэс Монгол” ХХК-д гүйцэтгэх захирлын албан тушаалыг тус тус хашиж байна.

Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт нь төрийн захиргааны төв байгууллагад болон төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компанийг удирдан ажиллаж байх хугацаандаа Төрийн сангийн төлбөр тооцооны нэгдсэн цахим систем, төрийн

албаны нэгдсэн цахим систем, НӨАТ-ын И-баримт систем, гаалийн ухаалаг гарцын системийг нэвтрүүлж нутагшуулсан. Татварын багц хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Төсвийн тухай хуулиудыг боловсруулж батлуулах ажлыг удирдан зохион байгуулсан. Төсвийн сахилга батыг сайжруулж, өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж ажилласнаар Монгол Улсыг хар, саарал жагсаалтаас гаргах, улсын зээлжих зэрэглэлийг ахиулах суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Макро эдийн засгийн бодлого, хөгжлийн төлөвлөлтийг хариуцаж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж экспортыг нэмэгдүүлэх, тээвэр логистикийг сайжруулах ажлыг удирдан зохион байгуулсан. Ашигт малтмал борлуулах бүх шат дамжлагыг цахимжуулж, гааль татварын системтэй холбосноор далд эдийн засгийг бууруулж, татварын орлогыг нэмэгдүүлсэн. Францын “Орана Майнинг” компанитай хийх хөрөнгө оруулалтын гэрээний техникийн ажлын хэсгийг ахалж, төслийн санхүүгийн загварчлалыг боловсруулан хэлэлцээрийг амжилттай хийсэн. “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд санхүүгийн сахилга батыг тогтоож, толгой хуримтлагдсан 514 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулж, Иргэний хуримтлалын санд 500 тэрбум төгрөг төвлөрүүлэн, 10 мянган өрхийн ипотекийн санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг улс орны хөгжилд чухал нөлөөтэй олон хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд голлох болон туслах үүрэгтэйгээр оролцсон санхүүгийн салбарын мэргэжилтэн юм.

Улсын Их Хурал нь Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Монголбанкны удирдлагыг томилох, чөлөөлөх байдлаар өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажилладаг. Энэ ч утгаараа Монголбанк нь Улсын Их Хурлын шууд харьяаны хамгийн том институт юм.

Хэдийгээр Улсын Их Хурлаас жил бүрийн мөнгөний бодлогын баримт бичгийг батлах замаар төрөөс баримтлах үндсэн чиглэлийг тогтоож өгдөг боловч, мөнгөний бодлого төсвийн бодлогын уялдаа холбоог хангаж ажиллах, банкны салбарт шударга зохицуулалтыг мөрдүүлэх, үйл ажиллагааны алдагдлыг хамгийн бага байлгах, хүний нөөцийн зохистой, үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа нь Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаардаг бөгөөд тухайн томилогдсон хүний манлайллаас энэ асуудал хамааралтай асуудал хэмээн үзэж байна.

Монголбанкны үйл ажиллагааны тайлангаас үзэхэд сүүлийн жилүүдэд тус байгууллагад хариуцлага, сахилга бат, хараат бус байдал алдагдаж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах банкны салбарт шударга зохицуулалтын үйл ажиллагаа явуулах зэрэг үндсэн үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжүүлсэн гэж дүгнэхээр байна.

Тухайлбал, Монголбанкны хуримтлагдсан алдагдал 2024 оны байдлаар 7.4 их наяд төгрөгт хүрч, сүүлийн 5 жилийн хугацаанд 5 орчим их наядаар нэмэгдсэн, боловсон хүчний бодлого алдагдаж, нийт ажиллагсдын тоо 700 хүрч 3 дахин нэмэгдсэн. Банкны харилцагч иргэн хувийн болон төрийн байгууллагын зүй ёсны эрхийг хамгаалах чиглэлээр дорвитой ажил хийгдэхгүй байгаа зэргээс харж болохоор байна.

Улсын Их Хурлын шууд харьяаны байгууллагын хувьд Монголбанкны үйл ажиллагааг нээлттэй, зарчимтай, макро эдийн засгийн тэнцвэрийг ханган ажиллах гол бодлогын институт байлгах нь та бидний үүрэг.

Иймд төрийн албаны дадлага туршлага, хувь хүний зарчим, боловсрол, мэдлэг, ур чадварыг нь үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчөөр Санжаагийн Наранцогтыг хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд томилуулах саналыг Улсын Их Хуралд танилцуулж байна. Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга Ренчинбямбын Сэддорж танилцуулна. Индэрт урья.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалт, Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын дарга Учрал өөрийн бүрэн эрхийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчөөр Санжаагийн Наранцогтыг томилуулахаар нэрийг нь дэвшүүлсэн бөгөөд нэр дэвшигч Наранцогт Эдийн засгийн байнгын хорооны “Нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” 2024 оны 3 дугаар тогтоолын дагуу өөрийн танилцуулга, холбогдох бусад баримт бичгээ бүрдүүлж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулах, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяаг томилсон “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны 18 дугаар тогтоолыг баталсан.

Эдийн засгийн байнгын хорооноос 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан Нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Анар, Баатархүү, Батболд, Батнайрамдал, Батчимэг, Бат-Эрдэнэ, Заяабал, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Найдалаа, Одбаяр, Пунсалмаа, Соронзонболд, Сэддорж, Ундраа, Уянга, Үүрийнтуяа, Цэнгүүн, Эрдэнэбат, Шижир нарын гишүүд оролцлоо.

Мөн оролцогч, ажиглагчаар нийт 35 иргэн бүртгүүлж, иргэн Нанжидсамбуу, Банзрагч, Баярцог, Сонинтамир, Мөнхбаяр, Бямбахорлоо, Гэрэлмаа, Цэрэнжав, Цэвэгмэд, Зоригтбаяр, Дөлгөөн, Сумъяа, Одбаяр, Уламбадрах, Амар, Дөлгөөн нар нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд хаалттай хуралдаж Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан гаргасан байна.

Байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх сонсголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан ипотекийн зээлийн хүртээмж, зориулалт, орон сууцын эрэлт, нийлүүлэлтийг уялдуулж зээл олгох талаар, Төв банкны бие даасан байдлаа Засгийн газрын өмнө хэрхэн хамгаалах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай орон сууцын үнийг тогтворжуулах арга хэмжээг хэзээнээс эхлүүлэх, ипотекийн зээлийн хүртээмж хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тодорхой төлөвлөгөө гаргах эсэх, ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны талаар, Улсын Их Хурлын гишүүн Анар валютын нөөцийг хэрхэн бүрдүүлэх, Төв банкны цахим төлбөрийн хэрэгслийн талаар Монголбанкны гадаад геополитикийн нөхцөл байдалд ямар бодлого баримтлан ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж Монгол төгрөгийн чадавхыг үнэгүйдүүлэхгүй улсын мөнгөн хөрөнгө санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Жавхлан ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлсэн болно.

Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчид томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ. Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа тэдгээрийг томилсон өдрөөс эхэлж, Улсын Их Хурлаас дараагийн Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилсноор дуусгавар болно гэж заасны дагуу Бядрангийн Лхагвасүрэнг Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөхөөр тогтсон.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсгол, тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Сэддорж даргад баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Санжаагийн Наранцогт хүрэлцэн ирсэн байна. Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг авъя. Ирцээр эрэмбэлнэ. Тасаллаа. Хэн дээр байна энэ чинь. Сүүлийн гишүүн. Ирцээр эрэмбэлэх хэрэгтэй байна. Доржханд гишүүнээр тасалж байна. Үг, санал хамтдаа. Асуулт асууж, үг хэлэх нэрс хамтдаа шүү. 36 гишүүн нэрээ өгсөн. Тогмидын Доржханд гишүүнээр нэрийг тасаллаа. Алтангэрэл гишүүн, Ганзориг гишүүний нэрийг нэмлээ. Ингээд тасалж байна. Ирцээр эрэмбэлье. Энэ Пүрэвдорж гишүүн ирцээр ер нь эрэмбэлэгдвэл нэгд байгаад байна л даа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Манай өнөөдрийн Монгол Ардын нам бол данс хааж ард түмнээ даапаалдаг нам болсон. Дарга томилж ард түмнээ дарладаг ийм нам болж байна. Өчигдөр баахан дэд сайд томилсон. Өнөөдрийн энэ төсвийн бодлого маш асуудалтай нөхцөл байдалд орсон. 20 мянган аж ахуйн нэгж дампуурсан. 28 мянган аж ахуйн нэгжүүдийн данс хаасан. Энд татварын өр бол 3.5 их наяд төгрөг болсон байгаа. Татварын өр юунаас болж байна вэ гэх дээр 2016 оноос хойш тувт

ингээд татварын дарамт өссөн. Өөрөөр хэлбэл 2021-ээс 22 онд асар их огцом өсөж, энэ татварын дарамт энэ аж ахуйн нэгжүүдийг ерөөсөө бүрэн сүйрэлд аваачиж байгаа. Энэ өнгөрсөн хугацаанд энэ төсвийн бодлого буруу явж энэ ард ард иргэдийг өрөнд оруулах, хамаг хөрөнгийг нь хувхайлах ийм л ажлуудыг хийсэн гэсэн үг. Тийм учраас өнөөдрийн ийм нөхцөл байдалд орж байгаа.

Чилид, Аргентинд байна уу 2 зэсийн уурхай нурснаас болж зэсийн үнэ өссөн өссөн болохоос биш бусдаар бүх юм хасах руу орж байна. Нэг зэсийн үнэ өсөж байж л нэг та нар нэг амь зогоож байх шиг байна. Гэтэл энэ ийм амьдрал хүнд байж байхад дахиад л дэд сайд нарыг томилж, энэ ард түмнээр даажигнаж. Та нарын мөнгийг чинь дарга нартаа л зарцуулна гэдэг ийм бодлого явуулна гэдэг чинь арай хэрээс хэтэрч байна. Тэгээд энд төсөв мөнгөний бодлого дээр тодорхой арга хэмжээг авах зайлшгүй шаардлага байна. Ялангуяа төсөв мөнгөний бодлогоор дамжуулж хувийн хэвшлээ илүү сайн дэмжсэн тэр улс орон л хамгийн сайн хөгжилтэй байгаа.

Тэгэхээр энэ дээр мөнгөний бодлого дээр найдахаас өөр арга байхгүй байгаа. Тийм учраас энэ Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдож байгаа хүн ялангуяа зээлийн хүүг бууруулах, хадгаламжийн дээд хүүд хязгаарлалт тогтоох энэ ажлуудыг тодорхой хийсний үр дүнд бас тодорхой хэмжээгээр энэ эдийн засагт эерэг үр дүн авчрах ийм боломжийг нээх ёстой. Засгийн газрынхаа халаасанд орж болохгүй. Ингэж ажиллах юм бол бас тодорхой хэмжээгээр энэ эдийн засгийг эрүүлжүүлэх ийм боломж бий болж байна. Ирэх онд зэсийн үнэ 14 мянган доллар дээр очоод нэлээн явах юм шиг байна. Цаашдаа ч ер нь энэ уул уурхайн бүтээгдэхүүнээс хамгийн их өсөлттэй байх нь, эрэлттэй байх нь зэс байгаа. Тийм учраас энэ зөвхөн энэ зэсийн үнэ дээр биш эдийн засгийн олон төрөлт тэр .../минут дуусав./

Н.Учрал: Нэр дэвшигч хариулна. Индрээс үү? Индрийн 4 дүгээр микрофон. Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт хариулна.

С.Наранцогт: Сайн байцгаана уу? Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Таны энэ дэвшүүлж байгаа саналтай санал нэг байгаа. Ер нь өнгөрсөн бид нар 10 жилийн хугацаанд төсвийн төсвөө 3 дахин тэлсэн, мөнгөө 3 дахин тэлсэн. Бодит эдийн засгийн өсөлт маань 5-6 хувьтай явж ирсэн. Тэгээд энэ үүсэж байгаа зөрүү өнөөдрийн энэ инфляц, үнийн хөөргөдөл, энэ хөөсрөлтийг би болгосон. Тийм учраас өнөөдөр бид нар нэлээдгүй энэ хөөс маань хагарах түвшинд хүрч ирээд байгаа. Тэгэхээр энэ дээр мөнгөний бодлого, төсвийн бодлого аль аль нь агшиж энэ хөөсийг хагалахгүй энийг тогтвортой яг макро эдийн засгийнхаа суурь үзүүлэлттэй уялдсан түвшинд аваачих ёстой. гэж ингэж бодож байгаа.

Та зээлийн хүүгийн талаар хүнд хөндсөн. Чилийн талаар хөндсөн. Чилийн бас төв банкнаас явуулдаг мөнгөний бодлого ер нь их оновчтой явдаг. Бид нар ер нь тэр загвар руу явахад бас зөв гэж ингэж би хувь хүнийхээ хувьд боддог.

2 дугаарт зээлийн хүүгийн үндсэн шалтгаан бол энэ инфляц, энэ бас л эрэлт нийлүүлэлтийн хууль хэрэгжиж байгаа. Яг мөнгө хүүлэлтийн хувь дээр л хэтэрхий өндөр мөнгө хүүлэлтийн хэмжээнд хүрсэн зээлийн хүүг л хязгаарлахаас биш яг одоогийн зах зээлийн зарчмаараа явж байгаа энэ банкин дээр явж байгаа

хүүг бид нар захиргааны аргаар тогтоох нь энэ салбар болоод зах зээлээ эвдлэх их буруу жишиг рүү явуулах юм.

Тийм учраас яах вэ гэхээр төсөв мөнгөний бодлого сайн уялдаад 1 дүгээрт мөнгөний бодлогоо Төв банк тодорхойлоод тэрийгээ хэрэгжүүлдэг байх ёстой. Хэрэгжилт дээр алдаа гараад энэнээс болоод би энэ байдлууд үүсээд байна гэж бодож байгаа. Тийм учраас энэ намайг бас энэ төсвийн санхүү дээр нэлээд ажилласан учраас энэ төсөв мөнгөний бодлогыг ойлголцож ажиллахад нэлээн ахиц гарах болов уу гэж ингэж нэр дэвшүүлсэн гэж ойлгож байгаа. Тэгээд энэ дээр би нэлээдгүй төвлөрч асуу ажиллана. Асуудлыг суурь нөхцөлтэйгөө уялдуулсан судалгаа, шинжилгээ дээр үндэслэж хийгээд тэрнийхээ хэрэгжилтийг бодитой хангаж, үнэн, зөв мэдээллийг өгөх замаар зах зээлийг бас зөв хүлээлтээр удирдах замаар бид үр дүн гаргах боломжтой гэж ингэж үзэж байна.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн хугацаанд энэ эсрэг талд байгаа нөхдүүд нүүрсний хулгайгаар эдний хамаарал бүхий харьяаны компани аж ахуйн нэгжүүд, иргэд баяжицгаасан. Тэгэхээр нийт хадгаламж эзэмшигчдийн 5-хан хувь нь нийт хадгаламжийн 95 хувийг эзэмшдэг юм. Тийм учраас ард иргэд, жирийн иргэд нэг тийм хадгаламждаа мөнгөтэй байгаад байгаа юм бараг байхгүй. Хөдөө малчид энэ тэр ерөөсөө бараг л хэцүүдэж дуусаж байна. Тийм учраас зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох тухай энэ асуудлыг бас тодорхой хэмжээгээр шийдэж энэ аж ахуйн нэгжүүдээ сайн өндөр хүүтэй зээл аваад тэрний нэг хэдхэн хадгаламж эзэмшигч нарыг, нүүрсний хулгайчуудыг баяжуулдаг ийм зүйлээсээ татгалзах хэрэгтэй байна. Энэ дээр бас тодорхой хэмжээний арга хэмжээ авах ёстой. Манай зөвлөх Даваадоржийн зээлийн дээд хэмжээнд.../минут дуусав./

Н.Учрал: Нэр дэвшигч хариулна. 4 дүгээр микрофон.

С.Наранцогт: Тэгэхээр Хадгаламжийн бүтцийг ингээд нэлээн ярьж байгаа. Манай эх үүсвэрийн 44, манай банкнуудын зээл олголт 24 хувиар өссөн. Энэний эх үүсвэрийн 44 хувь нь хадгаламж эзэмшигчдийн мөнгө байгаа. Эрэлт бас их байгаа. Эрэлт, нийлүүлэлтийн хууль бас үйлчилж байгаа. Эрэлт их байгаа учраас энэ зээлийн өсөлт өнгөрсөн жилээс 24 хувиар нэмэгдсэн. Тэр дундаа хэрэглэгчдийн хэрэглээний зээл илүү өсөлттэй байгаад байгаа юм. Бүүр нарийвчлах юм бол тэтгэврийн зээлийн өсөлт 44.2 хувь.

Тэгэхээр эндээс юу харагдаж байна вэ гэхээр бас нөгөө талдаа зээлийн хэрэгцээ яваад байдаг, дотоод хадгаламж маань инфляцтай уялдаж тогтож байгаа. Инфляцаас доош түвшинд бид нар энэ хадгаламжийн хүүг хүчээр оруулах тухай, энэ банкны өөрийн үйл ажиллагаа, эрсдэлийн зардал, ашиг гээд ийм зүйлүүд харж байгаа. Энэ дээр бас тодорхой хэмжээний би.../минут дуусав./

Н.Учрал: Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хэрэглээний зээл их нэмэгдэж байна гэдэг чинь цалин, тэтгэвэр дээр маш их зээл олгогдож байна гэсэн үг. Энэ бол маш тийм эрсдэл багатай зээл байдаг. Тийм учраас банкнууд яаж байна вэ гэх дээр танай үнэт цаасыг чинь маш их ихээр худалдаж авч байгаа. Бодлогын хүү өндөр байгаа

учраас үнэт цаасыг чинь худалдаж аваад амраар нь тэр тэрний хүүгээр амьдарч байгаа. Тийм учраас та гол нь Монголбанк заавал ашигтай ажиллах шаардлага байхгүй. Тийм учраас тэр үнэт цаасаа бага гаргаад зах зээл рүү илүү компаниудад бага хүүтэй зээл олгуулах талаар ажиллаарай гэж танд хэлмээр байна. Баярлалаа. Амжилт хүсье.

Н.Учрал: Санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн энэ чинь Золжаргал гишүүний урилга байсан биз дээ? Энэ Золжаргал гишүүний урилгаар орж ирсэн хүүхдүүд биз дээ? Улсын Их Хурлын гишүүн Золжаргалын урилгаар БГД-ийн сурагчид Төрийн ордны үйл ажиллагаатай танилцаж байна. Сурагч дүү нартаа сурлагын өндөр амжилтыг хүсье.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Энэ хүүхдүүдийг харсан чинь ингэж бодогдлоо. Энэ дээрх шилэн хургыг нь ингээд авчхаж болдог уу? Нээлттэй олгочихвол бусад улсуудад энэ хаалт байдаггүй юм байна лээ шүү дээ.

Гол асуултдаа орьё. Энэ яг мөнгө цаас болохгүй байх ёстой. энэ маш чухал үүрэгтэй, өндөр хариуцлагатай албан дээр очих гэж байгаа юм байна Наранцогт эдийн засагч. Тэгэхээр хүн болгон Эдийн засгийн байнгын хороон дээр ч тэр, өнөөдөр чуулган дээр ч гэсэн олон гишүүд асуух юм байна, асуучихсан юм байна. Ипотекийн зээлийн талаар, бодлогын хүүгийн талаар, инфляцын түвшин, макро эдийн засгийг хэрхэн тогтвортой байлгах вэ энэ тэр гээд. Тэгэхээр хамгийн гол бас хөндөгддөг асуудал ялангуяа бид нар энэ жил ирэх оны мөнгөний бодлогыг тухтай сайн ярилцаж бас чадаагүй. Тэр утгаараа мөнгөний бодлого, төсвийн бодлогын уялдаа холбоог хэрхэн хангах вэ хэрхэн анхааралтай ажиллах вэ гэдэг дээр асуулт асууя. Ер нь энэ ажилд томилогдоод яг юун түрүүнд хийх 5 гол бодлогын асуудлаа багцалж тодорхой яриач гэж хүсэж байна.

2 дугаарт нь бас нийгэмд шуугдаж байгаа нэг асуудал юу вэ гэхээр насаараа дарга хийсэн юм байна гээд. Тэгэхдээ насаараа бас дарга хийхгүй байх ёстой. гэсэн тийм хууль, дүрэм байхгүй. Тэгэхээр энэ талаараа өөрийгөө онцлогийг бас хэлэх нь зүйтэй юм болов уу. Төрийн алба маш нэр хүндтэй, ард иргэдийн дунд бас итгэлцэл үүсгэсэн ийм чухал алба байх ёстой. Тэгээд энэ дээр төрийн албыг чадавхжуулах, хүний сайн нөөцөөр хангах тал дээр бас санаа зовж явдаг гишүүн хүн байгаа юм. Тэгэхээр энэ 2 тодорхой асуултыг асуучихъя.

Н.Учрал: Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт 4 дүгээр микрофонд хариулна.

С.Наранцогт: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Төсөв, мөнгөний бодлогын уялдаа зайлшгүй байх ёстой. Шаардлагатай бол бид нар энэ дээр эрх зүйн өөрчлөлтийн тухай бас ярих нь зүйтэй болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд энэ төсөв мөнгөний уялдаа хангагдахгүй явж ирсний горьг бид нар өнөөдөр ингээд өнөөдрийн хүндрэл харуулж байгаа юм. Маш бодитой харуулж байгаа. Би ер нь манай Их Хурлын гишүүд энийг их бодитойгоор мэдэрч, ойлгож байна гэж ингэж байгаа. Тийм учраас мөнгөний бодлогоо яг төсөв хэлэлцдэг шиг нарийн хэлэлцээд

тэгээд яг энэнтэйгээ уялдуулж энэ төсвөө хэлэлцэж тэр хязгаартаа батлагдаж явах юм бол бид нар яг бодитой төсөв энэ инфляц бодитой нам доор түвшинд суурь асуудлуудаа шийдсэн ийм маягаар явах ийм учиртай.

2 талаасаа хөөсрөөд ингээд явах явж байгаагаас болоод энэ өнөөдрийн энэ байдал үүссэн. Хөөсөрсөн эдийн засаг үүссэн, инфляц үүссэн. Энгийг дагаад ингээд асуудлууд үүсээд байгаа юм. 2 дугаар асуудал нь та стратеги ярьж байна. Бид нарын өнөөдрийн зах зээлийн нөхцөл, эдийн засгийн нөхцөл байдал тийм сайнгүй байгаа учраас очоод хэрэгжүүлэх асуудал богино хугацаанд энэ өнөөдрийн хэрэгжүүлж байгаа төв банкнаас явуулж байгаа мөнгөний хатуу бодлогыг тодорхой хэмжээнд үргэлжлүүлж явуулахаас өөр аргагүй. Тэгэхдээ энэ хооронд энэ бодлогын хүү их өндөр явснаас болоод бид энэ компани, аж ахуйн нэгжүүдээ ер нь нэлээн хүнд байдалд оруулж байгаа юм. Тэгэхээр нөгөө талдаа энэ түрүүн Пүрэвдорж гишүүний хэлсэн зээл баталгаат, цалингийн зээлийнх нь өр найдваргүй зээлийн хэмжээ 158 хувиар өссөн. Өөрөөр хэлбэл бас баталгаатай биш иргэдийн амьдрал бас давхар хүнд байдалд орж, зээлийн дарамтад орж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ асуудал дээр захиргаадалтын биш яг макро тэнцвэртэй бодлогын хүрээнд ажиллах ёстой гэж ингэж үзэж байгаа. Тэгээд хэд хэдэн нарийвчилсан судалгаа хийж богино хугацаанд Улсын Их Хуралд Эдийн засгийн байнгын хороонд танилцуулга хийж бас, Засгийн газарт танилцуулга хийж тодорхой арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй гэж бодож байгаа.

Банкны хувьд бас сайжруулах үйл ажиллагааг нь бас эрчимжүүлэх, бүтээмж нэмэгдүүлэх гэдэг ажлууд давхар хийгдээд явна. Ингэснээрээ бас тодорхой бид нарын хийх судалгааны үр дүн сайжрах зэрэг ажлууд байгаа.

Банкны сектор дээр бид нар бас анхаарал тавих ёстой. Юу вэ гэхээр өнгөрсөн онд банкны гадаад пассив маань 62 хувиар нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл гадаад өрийн дарамт нэлээн нэмэгдэж байна гэсэн үг. Бид нар энэ жилийн хувьд экспорт багассан, урсгал төлбөрийн тэнцэл 1.9 тэрбум доллароор хасах явж байгаа. Тэгээд энэ үед банкнууд маань бас пассив маань ингэж нэмэгдэж байгаа нь өөрөө бас энэ гадаад өрийн дарамтыг ирэх жилүүдэд нэмэгдүүлэх ийм бас эмзэг байдал үүсгэж байна. Тэгэхээр энэ дээр бас анхаарал тавьж бодит шалтгааныг тогтоож ажиллана гэж.

Тэр сүүлийн таны бас нэг хэлсэн даргын тухай асуудал дээр би бас би ер нь томилогдсон ажил болгон дээрээ үр дүн гаргаж байсан. Элдэв би асуудалд орооцолдож яваагүй. Тийм учраас ер нь очсон ажил болгон дээрээ 1 дүгээрт энэ улсдаа хариуцсан ажлын чиглэл дээрээ би гавьяа байгуулна, мөн ажиллаж байгаа байгууллагадаа бас гавьяа байгуулж өөд нь татна гэсэн үзэл бодлоор өдий болтол хоёргүй сэтгэлээр би төр, олон нийтийнхээ төлөө ажиллаж ирсэн. Тийм учраас бас энэ надтай ажилласан сайд, удирдлагууд маань бас миний ажлын үр дүнг үнэлдэг. Тэгээд надад итгэж ингэж энэ хариуцлагатай албан тушаалд нэр дэвшүүлж байгаа болов уу гэж ингэж бодож байгаа. Би энэ ажлыг ч гэсэн ийм сэтгэл, ёс зүйтэй ажиллаж, ажлыг томилогдвол хийж гүйцэтгэнэ гэж ингэж бодож.../минут дуусав./

Н.Учрал: Мөнхсоёл гишүүн тодруулна.

Б.Мөнхсоёл: Монголбанкны хараат бус байдал, бие даасан байдал маш их яригддаг. Тэгэхээр улс төрөөс хамаарал багатай бие даасан бодлогуудыг саяын хэлсэн ёсоор хэрэгжүүлэх байх гэж итгэж найдахыг хүсэж байна.

2 дугаарт нь макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд бас нааштай байгаа. Саяхан бас валютын албан нөөцийг нэлээн өндөр 6 руу дөхлөө, тэрбум доллар руу дөхлөө гэж энэ тэр зарласан. Гэтэл нөгөө талдаа төсөв 2.2 их наяд төгрөгөөр дутчихсан байгаад байдаг. Тэгээд энэ дээр маш их бас түрүүний хэлсэнчлэн 2 бодлогын хувьд бас уялдаа холбоотой, анхааралтай ажиллах байх. Тэрнээс мөнгө хэвлэх маягаар асуудлыг бас шийдэхгүй байх гэж ойлголоо. Амжилт хүсье хэрвээ сонгогдсон тохиолдолд.

Н.Учрал: Санал хэллээ.

Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяагийн урилгаар уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захиргааны ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ахмадууд та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай гишүүд шинэ соёл тогтоож бас зочдоо ингэж хөтөлж оруулж ирж Төрийн ордныг танилцуулдаг жишиг тогтсон байна. Тэгээд Үүрийнтуяа гишүүн бас ахмадуудыгаа өөрөө хүндэтгэж хүлээж авч байна. Баярлалаа.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Наранцогт нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Сая ч хэлж байна. Ер нь хүн аливаа албан тушаалд томилогдоод нөгөө байх ёстой газраа нэг байсан шиг байдаг гэдэг энэ үг бас их зөв, зүйтэй үг. Бас өнгөрсөн намтар түүхийг нь харахад ч гэсэн нээрээ бас нэг их айхтар элдэв юманд холбогдоогүй ийм хүн гэж бас би боддог. Ер нь дарга хүн бол нөгөө асуудлыг шийдэх ёстой. Асуудлыг яриад байх биш шийдэх ёстой гэдэг ийм зарчмыг барих юм байна гэж би таны Байнгын хороо болон чуулганы хуралдаан, бусад газар хэлсэн үгнээс бас ойлголоо. Тэгэхээр бас хүлээлт тэр хэрээрээ өндөр байх нь гэж та ойлгох хэрэгтэй байх. Энэ макро эдийн засагтай холбоотой асуудлыг гишүүд ярьсан учраас би Монголбанкны давхардахгүй үүднээс Монголбанкны бодлоготой холбоотой ганц нэг асуултууд байна.

1 дүгээрт, энэ зээл тэтгэврийн зээлийн асуудал. Хамгийн эрсдэлгүй гэдэг ийм зээл. Тэтгэврийн зээлийн энэ бодлого жоохон тийм нэг тогтвортой баймаар байна. Тэгэхгүй ингээд л хаваржин л энийг ярилаа. Эрдэнэбат гишүүн байнга ярьж байгаа юм. Ахмадууд энд жагсаад байдаг. Тэгээд энэ чинь 500 мянган хүний ажил, амьдралтай холбоотой асуудлыг ингээд бужигнуулаад байж болохгүй байгаа юм. Хамгийн сүүлд манайх чинь ийм нэг дарга төвтэй улс болчихсон. Их Хурлын дарга хэлж байж 10, 36-н сар эд нар гэдэг юм руугаа орж эхэлж байх шиг байна. Тэгээд энд сөрөг болон эерэг талууд байгаа байх.

Ер нь цаашдаа тэтгэврийн зээлийн бодлого ингэж явах юм гэдгийг хаана хаана тодорхой болгоод зээл авах гэж байгаа тэр тэтгэврийнх нь ч тэр, зээл олгож байгаа банкных нь ч, тэрэндээ төлөвлөж байгаа орлого, зарлагаа төлөвлөж байгаа ахмадуудад ч гэсэн тийм нэг тогтвортой байгаасай гэж ингэж би бодож байгаа. Аль аль талаа бодож. Тэр дотор чинь олон янз. Бас бизнес эрхлэх гэж

байна. Сургалтын төлбөр ч явж л байна, эмчилгээний зардал ч явж л байна, хэрэглээнийх ч явж л байна. Энэ болгонд нь таарсан ийм уялдаа холбоотой ийм тогтолцоо юмнуудыг гаргаад ирээсэй гэж би бодож байгаа гэдгээ танд 1 дүгээрт хэлье.

2 дугаарт таны яриан дээрээс энэ гаднын банкныг оруулж ирэхийг дэмжинэ гэдэг ийм зүйл ярьж байна лээ. Тэгээд энэ дээр яг манай мөнгөний энэ банкны салбарт ямар эерэг үр дүн гарч эхлэх вэ? Нөгөө хүсэн хүлээдэг хүү буурах ийм бололцоонууд гарч ирэх үү гэдэг дээр би бас тодруулъя гэж ингэж бодож байна.

3 дахь нэг асуудал бол ялангуяа энэ ипотекийн зээл яригдаж байгаа энэ цаг үед энэ ногоон зээл гэдэг юмыг энэ аймаг, орон нутгийн төв, сумуудад төвийн хотуудад гэсэн үг шүү дээ олгох бол нөгөө хашаандаа сайхан амьдрах бололцоо бүрдэх юм. Энэ бол ипотекийн зээл олгогдсон тэр эх үүсвэрээр тэрнээс хэд дахин илүү айлын асуудлыг шийдчих ийм бололцоо байгаа гэж ингэж би хардаг. Тэгэхээр энэ дээр ер нь ногоон зээлийг нэмэгдүүлэх энэ тал дээр ер нь таны ажлын төлөвлөгөөнд юу байгаа вэ гэж бас.

Н.Учрал: Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт хариулна.

С.Наранцогт: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Та тэтгэврийн зээлийн асуудал дээр ингээд Төв банкны оролцоо байгаад байна ,олон өөрчлөгдлөө гээд ингээд ярьж байна. Ер нь анхнаасаа бас энэ асуудалд нэлээн оролцоод явсан нь бас тийм сайн зүйл биш. Ер нь хэдүүлээ яг нэг ийм зүйлийг л бодох ёстой. Үндсэндээ тэтгэврийн энэ бодлого, тэтгэвэр олгож байгаа тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр тогтоож байгаа энэ асуудал үндсэндээ Засгийн газраас хэрэгжүүлэх ёстой суурь тэтгэврийн үндсэн реформыг хийж байж бид нар яг үндсэндээ энэ ахмадуудынхаа олон жил тогтвортой ажилласан ахмадуудын тэтгэвэр, өнөөгийн үндсэн дээр зөв тогтож бас амьжиргаанд нь хүрэх ийм шийдэлтэй. Банк бол эндээс ингээд асуудлыг бид нар бүтнээр нь харж ярих ёстой. Банк талаасаа энэ чинь би бид нар үйлчилгээ л үзүүлж байгаа байгууллага. Энэ зээл өөрөө энэ банканд, банк арилжааны банкны хувьд үйлчилгээ үзүүлж байгаа газар бид нар ямар нэгэн энэ дээр нөгөө үүрэг хүлээх нь бас зөв үү, буруу юу гэдэг асуудал бас яригдаж байна лээ. Төв банкны хувьд зохицуулалтын үүрэгтэй бас оролцож байгаа яг нөгөө тэтгэвэр олгогч институц өөрөө биш.

Тийм учраас энэ ингээд өнгөрсөн жилийн датаг харахаар ингээд 44.2 хувиар өсчихсөн маш их өсөлттэй байгаа. Тэгээд энэний шалтгааныг бид нар бас мэдээж хэрэг энэ үнийн уналт, инфляцтай холбогдож байгаа. Зарим тохиолдолд нөгөө үр хүүхдүүд нь шал өөр зорилгоор бас эцэг эхийн зээлийг авчихдаг ийм нөгөө буруу ашиглаж байгаа тохиолдлууд бас давхар яваад байгаа.

Тэгэхээр сая ийм байдлаас болоод нөгөө зээл, орлогын харьцаа нь өндөрсөөд тэтгэвэрт байгаа тэтгэврийн ахмадуудын маань гарт сардаа амьдрах мөнгө маш бага болоод ихэнх 84 хувь хүртэлх тэр мөнгөө буцааж авсан тэтгэврийн мөнгө нь зээлд тооцогдоод байгаа учраас Улсын Их Хурлын даргаас энэ тэр амьжиргааг нь нэмэгдүүлэх тал руу л анзаарах ийм бодлогын хүрээнд банк, төв банкнаас тэр эх үүсвэрийг нь зохицуулалтынхаа хүрээнд бас банканд боломж олгох журмаар энэ 36 сарын асуудлыг шийдсэн байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ захиргааны арга бас хэрэглэх туйлын зохимжгүй. Өөрөөр хэлбэл энэ өөрөө энэ 3 сая 600 мянган иргэдийнхээ энэ санхүүгийн салбарт гажилт үүсгэх ийм байгаа. Тэгээд төв банк, банк 2 хоорондоо яг энэ зохицуулалтынхаа хүрээнд энэ дээр ямар арга хэмжээг тултал нь ашиглаж болох боломжтой вэ гэдэг дээр ажиллаж болж байгаа. Нөгөө талдаа бас тэтгэвэр баталгаатай ч бас биш. Тоо үзүүлэлт харахаар энэ тэтгэврийн зээлийн, найдваргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оноос 5.8 хувиар өссөн байна лээ. Энэ бас тодорхой хэмжээнд эрсдэлийн зардлыг нэмнэ гэж үзэж байгаа.

Тэгэхээр ер нь тэтгэвэр дээр нэлээн Засгийн газар, Их Хурлаас том цогц арга хэмжээг зоригтой хийвэл ер нь байх. Тэрнээс нөгөө нэг ийм энэ инструментууд бол тодорхой хэмжээнд очоод тулна. Тэгээд энэнээс цааш ингээд нөгөө гуравдагч этгээдэд энийг үүрүүлэх бололцоогүй ийм нөхцөл байдал үүсэх юм.

Гаднын банкны хувьд асууж байна. Би гаднын банк ялангуяа хувийн хөрөнгө оруулалттай яг арилжааны, ашгийн зорилготой арилжааны ийм зах зээлийн зарчмаар ажиллах зорилгоор орж байгаа банкнуудыг бүрэн дэмжинэ. Энэ бол бид нарт манай энэ зээлийн хүүгийн өндөр байгаагийн чинь гол зардал нь эх үүсвэрийн зардал байгаа юм. Тэгэхээр эх үүсвэр, хямд эх үүсвэр гаднаар гаднаас бид нар хөрөнгө орж ирнэ гэдэг бол манай эдийн засагт, манай салбарт сайн. Тийм учраас ийм зорилгоор орж ирж байгаа банкныг бид нар бараг урьж оруулж ирэх ёстой. Түүнээс бишээр нөгөө өөр стратегийн зорилттой төрийн өмчит ч юм уу эд нар дээр болгоомжтой хандах ёстой гэж.../минут дуусав./

Н.Учрал: Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирын урилгаар Багануур дүүргийн Цаг уурын өртөөний ажилтан, албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Цагаахүүгийн Идэрбат гишүүн тодруулна.

Ц.Идэрбат: Зээлийн хүү, тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал мэдээж банкны дүрэм журмаараа явна. Тэгэхдээ зээлийн ахмадуудын хүсээд байгаа зүйл бол зээлийн хүүгийн асуудал байгаа. Энэ дээр бас би анхаараасай гэж ингэж хүсэх гэж байгаа юм. Нөгөө талдаа энэ өр, орлогын харьцааг зохистой бариад явчихвал хугацаа нэг их тийм сонин биш болох болов уу гэж ингэж бас боддог. Тэгэхээр энэ дээр ч гэсэн та маань бас яагаарай гэж би танд бас хэлье.

2 дугаарт, энэ би ногоон зээлтэй холбоотой асуудал дээр бас танаас тодруулгаа авъя гэж ингэж бодож байна. Яагаад гэвэл би энийг, Улаанбаатарт орон сууц бариад байх нь зөв байх. Аймаг, орон нутагт тэр хашаандаа байгаа тэр айл өрхүүд хашаандаа сайхан амьдрахад ипотекийн зээлийн дэмжлэг туйлын чухал байгаа юм. Тэгэхээр орон сууц авснаас хашаандаа сайхан амьдрахын төлөө байшин барих 2-ын хоорондох зардлын харьцаа чинь бараг 50 хувь бага байхгүй юу. Дээрээс нь газартай, байшинтай, өмчтэй.../минут дуусав./

Н.Учрал: Санжаагийн Наранцогт нэр дэвшигч хариулна.

С.Наранцогт: Ногоон зээлийн асуудлаар байр суурь сонсьё. Идэрбат гишүүний асуултад тодруулж хариулъя. Ер нь танд ногоон зээлийн таны бодолтой би санал нэг байна. Ер нь бид нар энэ хямд эх үүсвэртэй, урт хугацаатай ногоон зээлийг Монгол руу оруулж ирэх, тэгээд яг зорилтот бүлэг рүү хандуулж ашиглах нь бас маш зөв байгаа. Тийм учраас би 2 чиглэлээр энэ ажиллая гэж. Төв банк бас энэ дээр нэлээн идэвхтэй байр сууриас шууд оролцохгүй ч гэсэн энэ ногоон зээр орж ирэх зохицуулалтын нөхцөл дээр нэлээдгүй анхаарч ажиллах ёстой. Бас Байнгын хороон дээр бас зарим гишүүд маань энэ дээр Төв банк энийг хариуцсан нэгжтэй болох ёстой гэдэг асуудлыг тавьж байсан. Энийг бас би очоод судалъя гэж бодож байгаа.

2 дугаарт бас энэ нөгөө хэрэгжилт дээр анхаарал тавина гэж үзэж байна. Ер нь бид нар ингээд тодорхой зорилтын зээлүүд, хөтөлбөрүүд гаргадаг. Яг хэрэгжилт дээрээ очихоороо хэт ерөнхий яваад яг зорилтот бүлгээ.../минут дуусав./

Н.Учрал: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Би таныг бас ингээд энэ дээр тийм мэдрэмжтэй хандаж байгаад их бас их таатай байна. Яагаад гэвэл одоо энэ чинь аймгуудаас Хэнтий, Увс, Хөвсгөл, Ховд гээд ингээд аймгууд инженерийн дэд бүтцүүд хийчихсэн. Тийшээ айлууд ингээд холбоод одоо байгаа байшингаа засах, эсвэл шинээр барих эх үүсвэрүүд ногоон зээлийн эх үүсвэр хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр Монголбанк энэ дээр би бараг санал хэлчих байх. Та ногоон зээлийн эх үүсвэр гаргах тал дээр Улсын Их Хурлаас ямар дэмжлэг хэрэгтэй байх вэ? Энэ тал дээр бас тодорхой саналуудаа хэлээрэй. Энэ дээр бас Монгол Улсын Их Хурал бас анхаарах нь зүйтэй болов уу гэж ингэж бас би боддог. Яагаад гэвэл дахиад хэлэхэд 40м2 байрыг ипотекийн зээлээр 100 гаран саяар авч байхаар 60 саяар, 50 саяар хашаандаа байшин бариад инженерийн шугамдаа холбоод авчихна эдийн засгийн хувьд маш үр ашигтай, өмчтэй, газартай дээрээс нь тэгээд нөгөө хүнсний хувьсгал олон зүйлүүдийг хийх боломжтой болох юм гэж.../минут дуусав./

Н.Учрал: Санал хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Наранцогт даргыг дэмжиж байгаа. Би олон жил ч хамтарч ажилласан. Томилогдсон ажил бүрдээ ажилдаа эзэн байж, менежерийнхээ түвшинд баг хамт олноо, байгууллагынхаа соёл ч тэр зөвхөн эдийн засаг гэлтгүй бас инженер, техникийн сэтгэлгээ сайтай учраас тухайн байгууллагын үйл ажиллагааг ч гэсэн жигдрүүлдэг гэрээ бас сайн учраас өдий ийм итгэлийг хүлээж байгаа болов уу гэж бодож байна.

Томилогдоно. Томилогдсоныхоо маргааш аашаа өөрчлөөрэй. Намс намс дуугараад сайхан ажиллаад байвал бүтэхгүй шүү дээ Наранцогт даргаа. Монголбанкны Ерөнхийлөгч ер нь муухай ааштай яг жинхэнэ тухайн байгууллагынхаа эрх ашгийг л боддог байж байж сая төсвийн болон мөнгөний бодлого чинь хоорондоо тусдаа байж чадна. Баяртсайхан Ерөнхийлөгч сайн Ерөнхийлөгч байсан шүү. Тухайн үед Хүрэлбаатар сайд ч гэсэн бас ааштай сайд учраас тэр 2-ын яг төсөв, мөнгөний энэ бодлого нь хоорондоо салж чадаж байсан. Одоо бол би салдаг гэдэгт нэг их тийм итгэлтэй байдаггүй.

Ийм учраас мөнгөний бодлогоо та төсвийн мөнгө бодлогоос маш ялгамжтай авч яваарай. Энэ Учрал дарга ч гэсэн хэлээд байгаа шүү дээ. Үгүй гэж хэлж чаддаг, хаалгаа савж чаддаг ийм л төрийн түшээд, төрийн албан хаагчид хэрэгтэй байна шүү гэж. Бид нар попролтоос ангид байх ёстой. Юм гэдэг тэгээд хяслантай ч юм уу тоглоомтой ч юм уу. Таныг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байхад тэтгэврийн зээлийг тэглэх шийдвэр гарч байсныг та санаж байна уу? Өнөөдөр таны очих гэж байгаа Монголбанкны өрийн дийлэнх хэсэг нь яг энэ Салхитын мөнгөний ордтой холбоотой зээлийн, зээлийн гэдэг юм уу энэ өрийн гэдэг юм уу өр байгаа.

Тэтгэврийн зээлийг тэглэсэн явдал өөрөө эдийн засгийн алуур шийдвэр байсан. Энд би ахмадуудыг бид нар бодох ёсгүй гэдэг үгийг огт хэлээгүй. Байгалийн баялгийг иргэддээ тэгш хүртээх ёстой. Зөв. Байгалийн баялгийн сангаараа дамжуулаад адил, тэгш хүртээх ёстой болохоос биш хэн нэгэнд давуу байдал үүсгэж хэн нэгний мэдээлэлд илүү ойрхон байсан, байгаагүй гэдэг юм уу ялгавартай хүртээж огтоосоо болохгүй. Бид нар өмнө нь өмнөх Улсын Их Хурлын гишүүд гэдэг юм уу маш их ийм хэн нэгэн давуу байдал үүсгэсэн Өршөөлийн Эдийн засгийн өршөөлийн хуулиудыг гаргаж байсан. Энэ бол буруу юм. Тэгэхээр бүгд адил, тэгш, зөв зарчимтай л байх ёстой. Онолынхоо хувьд зөв байх ёстой.

Хүмүүс өнөөдөр тэтгэврийн энэ хэмжээ болоод бусад энэ асуудлуудыг яриад байна л даа. Тэгээд энэ дээр би таны бодлогыг бас асуух гэсэн юм. Энэ тэтгэвэр өөрөө төсвөөс хамааралтай юм уу, эс үгүй Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдалтай хамааралтай юм уу?

Н.Учрал: Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт хариулна.

С.Наранцогт: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Би бас түрүүний асуултад хэлж байгаа. Тэтгэврийн бодлого бол энэ төрийн бодлого. Засгийн газар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд бас таны ажиллаж байх үед ч гэсэн бид нар нэлээн ярьж байсан. Сангийн яам гээд Засгийн газар дээр энэ цогц үндсэн асуудлаа олж харж үндсэн реформоо хийхгүй бол энэ асуудал засрахгүй. Тэгэхгүй болохоор энэ дээр ингээд үе үе л ийм жижиг сажиг 1 тэглэх, хүүг нь хүчээр бууруулах ч гэдэг юм уу ийм асуудал байнга орж, гарч ирж байгаа нь өөрөө бас асуудалтай.

Тэгэхээр энэ энийг ер нь хувь хүний хувьд энэ. Би ч өөрөө Сангийн яамны Төрийн нарийн байх үедээ энэ реформоо нэг мөр хийчихье, үндсэн реформоо шударга тогтолцоог нь бий болгочихье. Тэгээд энэ нь цаашдаа ингээд. Тэгэх юм бол Нийгмийн даатгалын сан өөрөө бие даагаад явчихна. Өөрөө бид энэ бусад этгээдийг оролцуулахгүйгээр асуудал шийдэгдээд явдаг ийм боломжтой болох ийм боломжтой гэж ингэж үзэж байгаа.

Тийм учраас тэр ингээд тэтгэврийн, ташрамд дурдахад тэр тэтгэврийн зээлийг тэглэх дээр би эсрэг байр суурьтай байсан. Ил илэрхийлж байсан тэрийг. Тэгэхээр цаашдаа бид нар яг энэ өөрсдийнхөө явж байгаа эдийн засгийн суурь макро түвшинд тохирсон зах зээлийн ийм аж ахуйн нэгж зөв бодлогуудыг хэрэглэж явах ёстой гэж ингэж бодож байна.

Төсвийн хувьд би танд хэлэхэд төсөв мөнгөний бодлогын хувьд бид Төв банк бие даасан хараат бусаар ажиллах ёстой гэдэг зөв. Тэгэхдээ яг энэ халхавчийн доор нөгөө хаалгаа хаачхаад суугаад байна гэсэн үг биш. Тийм учраас би мөрийн хөтөлбөртөө стратегийн түнш байна гэдэг нь асуудлыг Засгийн газартай ярьдаг, шийдэл бас ярилцдаг, тооцоо юмаа өгдөг, үнэн зөв тооцоо, учир шалтгааныг гаргахад нь, олоход нь, онош тавихад нь тусалдаг ийм байгууллага байх ёстой. Тэрнээс биш хаалгаа хаачхаад эсвэл нөгөө төсвийн болоод хагас төсвийн үйл ажиллагаа явуулаад мөнгө хэвлээд ингээд хөөсрүүлээд байдаг байж болохгүй гэж ингэж бодож байгаа.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Нийгмийн даатгалын сангийн тогтолцоо бол уг нь өөрөө бие даасан тогтолцоо. 95 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүсийн тэтгэврийг л, уг нь мөн цэргийн тэтгэврийг л төрөөс дааж уг нь явж байгаа. Энд төсвийн харилцаа байна. Нөгөө талдаа Нийгмийн даатгалын санд өнөөдөр шимтгэл төлж байгаа иргэдийн орлогоос өнөөдөр Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авч байгаа хүмүүсийн тэтгэвэр, тэтгэмжийг өгдөг уг нь бие даасан тогтолцоо байхгүй юу. Тэгээд энэ дээр улс төрчид дундаас нь ороод л элдэв янзын шийдвэр гаргаад орлогыг нь бууруулаад, зарлагыг нь нэмэгдүүлээд байх нь өөрөө энэ Нийгмийн даатгалын сангийн тогтолцоог нь бүүр огт буруу болгож байгаа. Энэ Нийгмийн даатгалын сангийн орж байгаа орлогын чөлөөт үлдэгдлийг арвижуулах үүргийг Нийгмийн даатгалын сан, засаг хариуцаж байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг арвижуулах 3-хан боломж хуулиар байдгийн нэг нь Монголбанкны бонд үнэт цаасыг авах боломж байдаг. Гэтэл би 1 минутаа авчихъя тэгэх үү дарга аа?

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

А.Ариунзаяа: Гэтэл би тухайн үед сайдаар ажиллаж байхад та Төрийн нарийн бичгийн дарга байхад уучлаарай Ариунзаяа банкнуудад бас байршуулахгүй ээ эрсдэлтэй байна, бонд үнэт цаас бүүр болохгүй Төрийн сан дээр байршуулна гэдэг ийм саналыг та болон таны яам, сайд гаргаж байсан. Гэтэл энэ нь өөрөө эргээд бидний төр засаг арвижуулах үүргээ огт хүлээгээгүйн нэг жишээ байхгүй юу. Тэгэхээр уг нь энэ чөлөөт үлдэгдлийг арвижуулж байж сая бид нар түүгээрээ дамжуулж тэтгэвэр, тэтгэмжээ нэмэгдүүлэх үүргийг хүлээж байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр та 1 дүгээрт анхаарах ёстой шүү.

2 дахь нь болохлоор Байгалийн баялгийн санг зөвхөн орон сууц, эрүүл мэнд, боловсролд гаргахаасаа гадна бусад улс орнууд яадаг вэ гэхлээр тэтгэвэрт нь бас зарцуулдаг юм. Энэ 3-даа зарцуулаагүй хүмүүс өндөр насны тэтгэвэртээ гарахдаа байгалийн сангаасаа тэтгэвэр, нэмэлт тэтгэвэр авдаг ийм бололцоо гардаг. Ийм учраас үүнийг ч гэсэн бид нар бас өөрчилж, байгалийн баялгаасаа бас тэгш хүртэх, ахмадууддаа тэгш хүртээх энэ боломж нь тэтгэвэр хэлбэрээрээ дамжуулах юм гэдгийг бас онцлон хэлмээр байна Монголбанкны хувьд.

Н.Учрал: Санал хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монголбанкны Ерөнхийлөгч нэр дэвшигч Наранцогтыг дэмжиж байгаа. Дэмжих учир шалтгаан байгаад байгаа. Манай улсын энэ төсөв, санхүү, аж ахуйн томоохон

менежер. Тийм учраас энэ хүн Монголбанк талд энэ мөнгөний бодлого талд очвол мөнгөний бодлого8 төсвийн бодлого 2-ын харилцан уялдаа үүн дээр тулгуурлаж мөнгөн урсгалын эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдал хангагдах, үүгээрээ дамжиж инфляцыг зорилтот түвшинд нь барих, улмаар бодлогын хүүгийн зохистой түвшин хадгалагдах ингэж байж энэ баялаг бүтээгчдийг дэмжих нөхцөл бүрдэх болов уу л гэж ингэж л харж их том хүлээлт танаас хүсэж байгаа л гэж зориуд хэлмээр байна. Тийм учраас дэмжмээр байна гэж.

Дээр нь манай гишүүд бас нэлээдгүй юм ярьж байна. Энэ томилгоо тойрсон асуудлууд. Тэгэхээр Монгол Улс өөрөө эрх зүйт төр төлөвшүүлж байгаа улсууд. Тухайлсан салбарууд дээр эрх зүйн зохицуулалтуудаараа удирдах албан тушаалтнуудыг тодорхой болзол, журмын дагуу хугацаатай томилдог, томилгооны хугацаанууд буюу бүрэн эрх дууссан бол бид энэ асуудлаа хуулийнхаа хүрээнд авч хэлэлцэж, томилгооны сонсголоо ил тод хийж томилгоонуудаа хийдэг журамтай, жамтай. Энэ дагуугаа энэ асуудлууд явж байгаа гэдгийг зориуд би хэлчихмээр байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн энэ асуудал ч гэсэн яг энэ хуулийнхаа дагуу явж байгаа үйл явц.

Тийм учраас иргэдэд буруу, зөрүүтэй ойлголт өгөх гэж оролдоод хэрэггүй гэдгийг хэлмээр байна. Том төрийн тухай, үрэлгэн төсвийн тухай хэдүүлээ их олон жил ярьцгаасан. Харин энэ Засгийн газрыг би энэ тал руугаа бас жоохон алхмуудаа ахиулж байгаа юм уу гэж ойлгоод байгаа шүү дээ. Энэ төрд байж байгаа илүү бүтэц, орон тоонуудаа цэгцлэх, дагуулаад энэ төсөв юмнуудаа бууруулах, нэгэнт Монгол Улсын эдийн засаг, төсвийн өмнө тулаад ирчихсэн хүндрэлийг урьдчилж хараад хүлээх эрсдэл гэдэг юм уу хохирлоо бууруулах үүднээс төсөвтөө зоригтойнхон шиг тодотгол хийсэн. 2.2 их наядын тодотгол хийсэн шүү дээ. Энэ Монголын эдийн засаг төсвийг өнөөдөр энэнээс хүнд байдал руу чирээд унагачих нөхцөл байдал бий болохыг урьдчилан хамгаалж чадсан. 26 оны төсөв батлахдаа ч.../минут дуусав./

Н.Учрал: Жигжидийн Батжаргал гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ж.Батжаргал: Өмнөх оноосоо тодорхой түвшнээр бууруулж чадсан. Энэ бол бид энэ хөөсөө зөв задалж, нэг бодит байдлаа зөв үнэлж энэ рүүгээ чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явсан гэдгийг хэлмээр байна. Дээр нь энэ баялаг бүтээгчдийг дэмжих, татварын орчныг таатай болгох, төрийн өмчийн бодлого, засаглал, өгөөжийг нэмэгдүүлэх, энэ Баялгийн сангийн хуваарилалт өгөөжийг эдийн засгаа тэтгэж чаддаг, иргэдийнхээ амьдралыг чанарыг ахиулж чаддаг ийм үзэл баримтлалтай бодлогын чиглэлийг авч хэрэгжүүлэх ёстой.

Ийм учраас энэ Засгийн газраас, энэ Их Хурлаас энэ чиглэл рүү багц бодлого, эрх зүйн шинэтгэл хийхээр асуудал руугаа орсон. Монгол Ардын намын бүлэг дээр энэ чиглэлээр тодорхой хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг.../минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут авах уу? Тодруулсны дараа нэмэлт 1 минут байна. Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт. Санал хэлсэн үү та? Ерөнхийдөө санал хэллээ дээ. Батжаргал гишүүнд баярлалаа. Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Орон сууцын ипотекийн ипотекийн санхүүжилтийн журмыг Монголбанкнаас баталдаг. Тэгээд энэ бараг хүсэлт гэх үү та анхаараач гэж би бас тусгайлан хүсэх гэж байгаа юм. Та мэдэж байгаа багш, эмч нар маань энэ журмын заалт шалгуурыг давж чаддаггүй. Нөгөө 30 хувь байдаг. Урьдчилгааныхаа 30 хувийг өгөхөд хэцүү, хүндрэлтэй. Цалин нь бага байдаг. Тэгэхээр энэ Монголбанкны өөрийнх нь эрх хэмжээ нь журмаараа зохицуулж болдог асуудал л даа. Тэгэхээр би олон мянган багш нараа, бас эмч нараа төлөөлөөд ялангуяа залуу эмч, багш нар орон сууцтай болж чадахгүй байгаад байгаа. Энийг бид нар Их Хурал дээр, засаг дээр маш олон удаа ярьсан.

Тэгэхээр ялангуяа бид нар энэ хүн төвтэй бодлого хэрэгжүүлж байгаа энэ цаг үед энэ хүн төвтэй бодлого гэдгийн тулгуур багана нь эрүүл мэнд, боловсролын салбар болчихсон, эмч, багш нар маань болчихсон энэ цаг үед энэ хүмүүсээ бодоод энэ орон сууцын ипотекийн санхүүжилтийн журамдаа өөрчлөлт оруулаад олон мянган эмч, багш нараа хөнгөлөлттэй арай шалгуур багатайгаар орон сууцжуулах боломж юу байна вэ? Энэ дээр та ямар бодолтой байна, ямар санал, санаачилга гаргаж ажиллах вэ гэдгийг би багш, эмч нараар төлөөлөөд танаас 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаар зүйл юу вэ гэхээр Монголбанкны энэ хараат бус байдлыг хэрхэн хангаж ажиллах вэ? Төв банкны тухай хуульд Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, Засгийн газрын үнэт цаас худалдан авах, арилжааны банкнуудад зээл олгох зэрэг эрхүүд Монгол банканд байж байдаг. Энэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хараат бус бие даасан байдлаа яаж хангаж, яаж хараат бус нөлөөлөлд орохгүйгээр шийдвэр гаргаж ажиллах вэ. Та ямар зарчмыг баримталж ажиллах вэ гэдэг энэ 2 асуултыг асуумаар байна.

Н.Учрал: Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Таны асуултад 2 асуулт байсан. Ипотекийн журам дээр энэ дээр бид нар би онцгой анхаарч ажиллана. Яагаад вэ гэхээр бид хэд өнгөрсөн хугацаанд Монголбанкнаас мөнгө хэвлэх журмаар энэ ипотекийн хөнгөлөлттэй хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн. Өнгөрсөн жилээс яг бодитой хуримтлалын сангийн мөнгийг ашигласан. Тэгэхдээ энэ дээр нөгөө бид зарим хүмүүсийн бодь зорилтот гэж нэрлэж байдаг энэ бүлгийн 40-хөн хувь нь л энд хамрагдсан байна. Одоо ингээд 30 гаран мянган хүний очер үүсчихсэн.

Тэгэхээр 2 чиглэлээр явах ёстой. Ингээд бас энэ дээр Засгийн газар өөрөө анхаарал тавиад эхэлсэн. Хамтарсан ажлын хэсэг гаргаад ингээд ажиллаад явж байгаа. Тэгэхээр энэ ажил болно. Энэний цаад санаа юу вэ гэхээр энэ бүх хүмүүс чинь бүгдээрээ адилхан биш ингээд орлогын нөхцөл байдлууд өөр учраас бид нар заавал нөгөө ийм 6 хувьд, угаасаа багтахгүй байгаа юмыг ингээд очерлуулах биш энэ зах зээлийн яг олон улсад байдаг туршлагыг нэвтрүүлсэн энэ бүтээгдэхүүн зах зээлийг яг тэр үндсэн зарчмаар нь хөөцөлдөж тэр түрүүн ярьж байгаа энэ ногоон зээл урт хугацаат эх үүсвэрийг олж ирэх энийг энэ нөхцөлийг нь Төв Банкнаас бас зохицуулалтын хүрээнд бий болгох зэрэг гээд ингээд ажлууд байна гэж харж байгаа. Энэ дээр ингээд ажиллаад энэ зорилтот бүлэг рүү нь чиглүүлээд маш нарийн чиглүүлэхгүй ингээд ерөнхий яваад байгаа учраас ийм 2, 3 дахь орон сууцдаа ипотек авдаг ийм юунууд үүсчхээд байгаа. Тэгэхээр энийг таны хэлсэн зүйлийг анхаарч ажиллана. Тэгээд энэ дээр зөв л бодлого хэрэгжих ёстой.

2 дугаарт, Төв банкны бие даасан байдлыг хангах, тэр банкнуудад тэгш, шударга хангах хандахыг би өөрийнхөө тэр мөрийн хөтөлбөр дээр бас бичсэн. Ер нь асуудлууд нээлттэй, энэ олгогдож байгаа санхүүжилт энэ тэр нь яг шаардлагатай дүрэм, журам, хууль эрхийнхээ хүрээнд шударга журмыг барьж, нээлттэй явж байж л юм зөв болно. Тэгэхгүй болохоор далд яагаад хийсэн нь мэдэгдэхгүй энэ валютын арилжаан дээр ч тэр. Энэ байдал нь өөрөө хардлага, сэрдлэг, асуудал зөв хийгдсэн ч байсан үүсдэг. Тэгэхээр энийг аль болох нээлттэй, тэгш шударга энэ бодлогынхоо хэрэгжилтийг энэ банкнууд дээр бас яг тэгш, шударга хэрэгжүүлдэг энэ ийм болж байж л бид нарын бодлого зөв болоод явна л гэдэг зүйлийг хэлье.

Н.Учрал: Бум-Очир гишүүн тодруулна.

Д.Бум-Очир.: Баярлалаа. Иргэд бол магадгүй шууд тийм, үгүй гээд бас сонсчихыг хүсэж байгаа байх. Багш, эмч нар маань ялангуяа. Жишээ нь ипотекийн урьдчилгаа 30 хувь хувиас доошоо байх, буулгах боломж байдаг юм уу? 20 руу буулгах юм уу, бүүр 15 руу ч юм уу? Энэ бол яг иргэдэд бодитой тулгамддаг асуудал. Ийм тооцоолол хийж үзвэл бодит боломж юм байдаг юм уу 30 хувь дээр жишээ нь? Түүнчлэн 6 хувийг дахиж бууруулах тийм боломж байдаг юм уу? Эд нарыг их олон жил ярьж байгаа. Энэ яг иргэдийн өөрсдийн хүсдэг, бас бодитой амьдралд нь тулгараад байгаа асуудлууд учраас та энэ 2 дээр боломж байх эсэхийг санхүүч хүн, эдийн засагч хүн, Монголбанкны Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа хүний хувьд та өөрийнхөө нэг байр суурийг илэрхийлээд өгөөч.

Н.Учрал: Нэр дэвшигч хариулна.

С.Наранцогт: Тэгэхээр би танд шулуухан хэлэхэд энэ тооцооллыг яг хэдэн багш, эмч нар хүсэлт гаргачихсан байна, ямар материал ирүүлсэн байна эд нар дээр бид нар нарийвчилсан шинжилгээ хийж үзэж байгаад яг тооцоо судалгаа тэгээд банкнууд өөрсдөө бас тооцоо судалгаа хийж байгаа. Тэгээд энэ зүйлийг үндэслэж, тооцооллын үндсэн дээр хийхгүй болохоос биш захиргааны аргаар механикаар хийх 1 дүгээрт бололцоо байхгүй.

Тэгэхээр тэр оношоо тавьж байгаад тэр оношоо зөв эмчилж байж бид нар энийгээ яаж хүртээмжээ нэмэгдүүлэх вэ? Мэдээж зорилго ойлгомжтой аль болох тэр багш, эмч нар зорилтот бүлэгт хүртээмжийг нэмэгдүүлэх ёстой. Хүртээмж нэмэгдүүлэх ёстой. гэдэг дээр анхаарч ажиллана. Энэ дээр яг ийм мөнгө хэвлэхгүй бодитой мөнгөөр хэрэгжүүлэх ийм арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж үзэж байна. Яг өнөөгийн бид нарын макро эдийн засгийн нөхцөл байдал дээр 6 хувиас доош буух боломж байхгүй. Тийм учраас бид нар энийгээ хадгалаад явах нь зөв. Яагаад гэхээр.../минут дуусав./

Н.Учрал: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхбат: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох асуудал яригдаж байна. Манай энэ удаагийн Засгийн газар, манай Монгол Ардын намынхан сүүлийн үед маш олон томилгоо хийгдэж байгаа. Хийхээс ч бас аргагүй нөхцөл байдалтай байгаа гэж ингэж ойлгож байгаа. Гэхдээ харин өнөөдрийн томилгоо бол их зөв, ганц зөв

томилгоо боллоо гэж би их баяртай байгаа юм энэ Монголбанкны Ерөнхийлөгчид. Энэ Наранцогт даргыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байхаас нь мэдэхийн хувьд энэ төрийн албанд, тэр дундаа энэ төрийн захиргааны төв байгууллагуудын дандаа төсөв, санхүүтэй холбоотой энэ удирдах ажлуудыг хийсэн. Монгол Улсын энэ санхүү төсвийн бодлогыг нэлээн сайн гадарладаг хүн. Одоо манай мөнгөний бодлого руу орж байгаа юм, байна орох юм байна. Бас харьцангуй зарчимтай, хариуцлагатай ажилладаг ийм хүн гэж боддог.

Тийм болохлоор энэ удаагийн Монголбанкин дээр томилогдож очоод өнөөдрийн энэ яваад байгаа мөнгөний энэ гажуудал, мөнгөний ханшны уналт, энэ валютын нөөцийн тогтвортой байдал гэх мэтчилэн нийгэмд бодитой биш яваад байгаа энэ асуудлуудыг нэг бүрэн дүүрэн цэгцэлж чадах болов уу гэсэн ийм итгэл үнэмшилтэй байгаа учраас би дэмжиж байгаа юм. Яг өнөөдөр манай Монгол Улсад инфляц хэдэн оронтой тоонд байгаа вэ? 9.9 гэл үү нэг тийм 2 орон арай хүрэхгүй байгаа юм шиг ойлгуулж байгаа. Гэтэл яг амьдрал дээр мөнгөний ханшны уналт чинь өөрөө тийм юм байхгүй байгаа гэдгийг хүн болгон мэдэж байгаа бараг. Энэ санхүү, төсөв гадарладаг, мөнгөний ханш гадарладаг улсууд ер нь бүгд мэдэж байгаа байх. Тийм болохоор зэрэг энэ ажлууд дээр хариуцлагатай бас чин шударгаар сэтгэлээсээ ажиллана гэж итгэж байгаа учраас би энэ Наранцогт даргыг дэмжиж байгаа юм.

2 дугаарт ер нь энэ манай Монгол Ардын намынхан маань энэ Засгийн газар маань өөрөө ингээд хэдий болтол энэ томилгоонуудаа үргэлжлүүлэх вий. Өчигдөр тэр дэд сайд нар гээд л нэг баахан улсууд оруулаад ирлээ. Одоо манай Монгол Улс чинь 30 хэдэн сайдтай боллоо. 40 шахуу сайдтай боллоо. Өнөөдөр дэд сайд нарыг томилох цаг үе мөн үү ер нь энэ Монгол Улсад? Энэ эдийн засаг ямар байна? Бид нар энэ иргэдээ, аж ахуйн нэгжүүдээ бүсээ чангал гээд байдаг. Өөрснөө болохоор дарга нарынхаа тоог нэмээд байдаг. Энэ чинь та бүгдийн нөгөө ярьж хэлж байгаа шударга ёстой чинь нийцэж байна уу, нөгөө мөрийн хөтөлбөртэй чинь нийцэж байна уу гэдэг энэ асуудлыг бас бид нар бас бодох ёстой гэсэн ийм бодлоор үг хэлж байгаа юм.

Н.Учрал: Тээр жил Зөвшөөрлийн хууль дээр 360 зөвшөөрөл бичсэн чинь. Тэрнээс хойш зөвшөөрөл гэдэг нэрийг бүртгэл, хориглолт, лиценз, гэрчилгээ гээд нэрлээд тэр нь эргээд харсан чинь мянга гаруй нөгөө зөвшөөрөл гэж нэргүй мөртөө зөвшөөрлүүдтэй болчихсон байсан шиг. Нөгөө дэд сайд, дэд захирал нөгөө нэрсийг нь өөрчлөөд Бүтээмжийн менежер, Хяналтын менежер гээд нэрлэчихсэн. Яг очсон чинь дэд захирлын рангтай л байгаа юм л даа. Тэгэхээр 1 үндэсний хороо бараг 20, 30 хүний бүрэлдэхүүнтэй энэ чинь замаа алдсан. 28 хороо ямар ч байсан буусан.

Ер нь энэ хэмнэлтийн асуудлыг сайн ярих цаг ирсэн. Тэгэхээр энэ асуудал дээр сахилга баттай хариуцлагатай хандах хэрэгтэй. Монголбанк бол бүтэц, орон тоогоо нэмэгдүүлээд байна гэдэг мэдээллүүд ирээд байна. 700 хүнтэй болчихсон. Ингэж замбараагүй байж болохгүй шүү дээ. Тэр дэд сайдын асуудал наадах чинь бараг нэг үндэсний хорооноос 14, 5 дэд сайд чинь нийлээд бага байгаа байхгүй юу. Нэр нь тийм нэртэй. Тэрнээс бүтээмжийн менежер, яамны бүтээмжийн менежер гээд хяналтын менежер гээд нэрлэчихвэл нийгэм яах ч үгүй юм шиг байгаа юм.

Тэгээд ингэж бие биеэ хуурахаа болих хэрэгтэй. Одоо энэ Их Хурлын ажил явахаа болилоо. Одоо энэ Аюулгүй байдлын байнгын хороо хуралдаж байна. Ажлын хэсэг суудаг хүнгүй болсон. Сайд нь биеэ 5, 6 хуваахаа мэдэхээ больсон. Гадаадын зөвлөл комисс хүрч ирэхээр очих хүнгүй болсон. Сайд нь гадаад дотоод яваад өгдөг Монголд нь байдаг хүн байдаггүй. Энэ бүүр арай хэтэрлээ. Ер нь бүгдээрээ хаа хаанаа хариуцлагатай байя. Хуулийн хугацааны томилгоонуудыг шийдэж аваад энэ ажлыг нь шахаад явъя гэж л ингэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигч Санжаагийн Наранцогт, Мөнхбат гишүүний асуултад хариулна. Энэ сахилга бат хариуцлага, энэ ад орон тоо, бүтэц энэ асуудлууд дээрээ бас хариуцлагатай ажиллах ёстой гэдэг санааг хэлж байна.

С.Наранцогт: Мөнхбат гишүүнд дэмжиж үг хэлсэнд баярлалаа. Тэгээд таны асуултад би хариулъя. Би өмнөх ажлууд дээр барьж байсан хатуу зарчмыг үргэлжлүүлж энэ байгууллага дээр томилогдвол хэрэг хэрэгжүүлж ажиллана. Үндсэндээ бид энэ төрийн төв институт бол төрийн хуулийг ягштал биелүүлдэг төр, ард түмэн улс орныхоо эрх ашгийг 1 номерт тавьдаг хоёргүй сэтгэлээр ажилладаг, ашиг сонирхлоос ангид явах ёстой гэдэг зарчмыг хатуу барьж ажиллаж ирсэн. Яг энэ зарчмыг энэ байгууллагад ажиллаж байгаа хүн бүрд хатуу тавьж ажиллана. Энэ шаардлагыг биелүүлэхгүй цалингийн цэс бөглөөд ингээд ажлаа хийдэггүй, ашиг сонирхлын зөрчил гаргадаг ёс зүйгүй хүмүүстэй хариуцлага тооцож ажиллана гэдэг зүйлийг би хэлье.

Н.Учрал: Нанзадын Наранбаатар гишүүн? Алга байна. Сархадын Зулпхар гишүүн? Алга байна. Байхгүй гишүүдийг дахиж нэр өгөхгүй шүү. Найзан дундаа юм гэж байхгүй шүү. Одонгийн Цогтгэрэл гишүүн байхгүй. Пүрэвжавын Сайнзориг гишүүн байхгүй. Одоо би хаанаас олж ирэх юм. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн. Тэгээд найзан дундаа дуртай үедээ орж ирж үг хэлнэ, дуртай үедээ нэрээ өгнө. Юм яримаар байдаг юм бол орж ирж ярь л даа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Маш хүнд хэцүү үед Монголбанкны Ерөнхийлөгчийг бид томилох гэж байгаа. Инфляц 2 оронтой тоонд аль хэдийн хүрчихсэн, экспорт багасчихсан, төсвийн орлого тасарчихсан, төгрөгийн ханш 20 дахин суларчихсан ийм цаг үед, ЭМД-ын сан хоосорсон, иргэддээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж чадахаа больчихсон, төрийн албан хаагчдын цалин тасарсан. 22 мянган аж ахуйн нэгж дансаа хаалгасан ийм үед бид Монголбанкны Ерөнхийлөгчийн асуудлыг хэлэлцэж байгаа юм. Монголбанкны Ерөнхийлөгчийг томилно оо дэмжинэ ээ.

Гэхдээ энд Монголбанкны Ерөнхийлөгчөөр өнөөдөр ёс зүйтэй, боловсролтой, шаардлага нийцсэн хүн орж ирсэн. Гэхдээ энэ хүнийг ажлыг нь хийлгэхгүй байх хамгийн том саад, чөдөр тушаа бол Монгол Улсын Засгийн газар өөрөө юм. Ямар ч ажил хийсэнгүй яг бодит чанартаа, мөн чанартаа огцорчихсон Засгийн газар хүчээр орж ирж энд сууж байгаа, ажлаа хийж байгаа, Улсын Их Хурлыг бойкотолсон. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг улс төрд хутган оруулж ирсэн. Макро эдийн засаг яагаад орчин яагаад муудаад байгаа юм. Энэ чинь улс төрийн бодлоготой холбоотой шүү дээ. Тогтворгүй байдалтай, тогтворгүй бодлоготой, хоосон популизмтай шууд холбоотой байхгүй юу.

Тэгэхээр Наранцогт дарга та томилогдоод Монгол Улсын энэ Засгийн газрын заасан чиглэлээр явах юм бол бүтэхгүй та бол та бол хамгийн муу

Монголбанкны Ерөнхийлөгч байх болно. Тэгэхээр Засгийн газрын үгийг битгий сонсоорой. Монголбанк бол Засгийн газрын халаасны банк байх ёсгүй юм. Амьдрал ийм хүнд, хэцүү үед өнөөдөр баахан дэд сайд томилчихлоо. Бүтээмжийн менежерүүдийг халсан. Зөв.

Тэгэхдээ тэд нар компаниасаа цалинждаг байсан юм шүү. Энэ дэд сайдууд чинь одоо төсвөөс цалинжина. Төрийн хэмнэлтийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Анх энэ Засгийн газар томилогдохдоо бид хэмнэлттэй явна, цөөхөн цомхон байдлаар ажиллана гээд баахан төрийн албан хаагчдыг цомхотгосон. Өөрснөө болохоор албан тушаалуудаа нэмж байгаа, ард түмэн ингээд албан тушаалаа нэмээд өөрсдийгөө томруулаад байгаа энэ Засгийн газрыг нэг их удаан харж суухгүй байх.

Тэгэхээр Монголбанкны Ерөнхийлөгч болох гэж байгаа Наранцогт даргаас би нэг юм асууя. Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар ипотекийн банк байгуулах нэг юм ярьсан. Энийг та дэмжиж байгаа юу? Энэ яах ёстой юм оо гэж бодож байна. Та Засгийн газрын хий гэснийг хийгээд байвал хэн ч биш болно. 2027 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болно. Ерөнхийлөгчийн сонгуулийг он гараад л 26 он гараад л таныг зовоох болно. Энэ мэт улс төрийн хавчилт, шахалтад битгий ороорой.

Н.Учрал: Маш чухал асуудлыг хэлж байна. Улс төрийн шахалтад битгий ороорой хариуцлагатай ажиллаарай гэж. Тэр саяын тэр дэд сайд нарын нэрийг нь Бүтээмжийн менежер гээд нэрлэхивэл ямар ч ялгаагүй юм болчих гээд. Ингээд бие биеэ хэдүүлээ нэг ийм хуурсан юм яриад байхгүй. Одоо энэ Монголбанкин дээр ч гэсэн та очоод наад 700 хүн амьтантай болчихсон энэ том орон тоо бий болгочихсон байгаа дээр хариуцлагатай байхгүй бол Монголбанкны Ерөнхийлөгч сонсгол хийгдэж байх үед хугацаа нь дуусчихсан Ерөнхийлөгч яахаараа бүтэц өөрөө шинээр зураад хүн томилоод байгаа юм бэ? Би энийг чинь ерөөсөө ойлгохгүй байна шүү дээ. Энэ ер нь юу болоод байгаа юм бэ?

Санжаагийн Наранцогт нэр дэвшигч.

С.Наранцогт: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Таны энэ Монгол Улсын эдийн засгийн, төсөв, эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаатай санал нэг байгаа. Та бас тодорхой тоо баримтуудыг дурдлаа. Тэгээд энийг мөнгөний бодлого, төсвийн бодлоготой уялдаж засах дээр хичээж ажиллана. Богино хугацаа ер нь нэлээн шуурхай ажиллах цаг үе бид нарт ирчихсэн байна. Тэгээд дан мөнгөний бодлогоор ч бас шийдвэрлэгдэхгүй. Тэгэхээр мэдээж хэрэг Засгийн газар Төв банк 2 энэ ард иргэдийн эдийн засгийн тогтвортой байдал, өсөлтийн төлөө бас байх үүрэг хүлээсэн байгууллагууд.

Тийм учраас нөгөө би түрүүн хэлээд байгаа нь яг хий гэснийг хийж, мөн Төв банк бол Засгийн газрын кассын машин болж төсвийн болоод хагас төсвийн үйл ажиллагааг явуулах ёсгүй ээ? Харин стратегийн түншийн хүрээнд энэ тэр асуудлуудыг хэрхэн шийдэж болох вэ? Заавал төв банкнаас мөнгө төгрөг хэвлэхгүйгээр Төв банкинд үүрэг хариуцлага хуулиар хүрээгүй, хүлээгээгүй үүрэг хариуцлага хүлээлгэхгүй үндэслэл юман дээр хатуу байр суурийг илэрхийлж ажиллах ёстой. Би ч ингэж ажиллана гэж бодож байна.

Ипотекийн ба тэр банкны хувьд гишүүнээ ийм байгаа ер нь түрүүний би Бум-Очир гишүүний асуулт дээр бас ярьсан. Бидэнд зайлшгүй энэ 6 хувийн татаастай хөтөлбөрөөс гадна одоо банкнууд дээр өөрийн эх үүсвэрээрээ олгосон, олгоод явж байгаа 10 гаран хувийн хүүтэй ийм зах зээл угаасаа үүсчихсэн байгаа. Энийг яг олон улсын энэ ипотекийн институтууд хийдэг л дээ. Заавал бас банк байх албагүй. Солонгосын нөгөө “Housing Corporation” байна. Аягүй энэ бас их үлгэр жишээ. Тэр зарчмаар бид нар нөгөө зорилтот бүлгээсээ салгаад яг орон сууцын зах зээлийг энэ орлогод нийцсэн зах зээлийг нь хөгжүүлэх ийм тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай энэ зах зээлийг үүсгэх шаардлагатай. Зүгээр банк байх ёстой юу үгүй юу гэдэг асуудал 2 дугаар асуудал. Миний хамгийн эхэнд санаа зовж байгаа юм бол бид нар ингээд нөгөө засаглал зөв юм хийж чадахгүй бол 2 дахь Хөгжлийн банк болох ийм эрсдэл бас байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Нэр дээрээ байгаагүй гишүүд орж ирчхээд дахиж ярья, үг хэлье гээд байгаа юм байхгүй шүү. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Цэвэгдоржийн Туваан гишүүн? Туваан гишүүн байхгүй байна. Одоо гишүүд орж ирж байна. Ардчилсан намын дарга, бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл даргад микрофон өгье.

О.Цогтгэрэл: Монголбанк мөнгөний бодлого эдийн засагт бараг л 2 том баганынх нь нэг. Асар чухал ийм байр суурьтай байгууллага, үүрэг функцтэй энэ байгууллагын Ерөнхийлөгчийн асуудал, томилгооны асуудал яригдаж байна. Яг өнгөрсөн хугацааны эдийн засгийн нөхцөл байдлыг ярихад Засгийн газар асар ихээр тэлдэг, зардлаа тэлдэг, бүтцээ тэлдэг, эдийн засгийн оролцоогоо тэлдэг яг л энэ бүхэнд Монголбанк эвлэрч явсаар байж өнөөгийн эдийн засгийн байгаа байдал, үр дүн нь гарч байна. Аж ахуйн нэгжүүд нь хаалгаа хаасан, барьсан, дансаа хаалгасан. Нөхцөл байдал яг л ийм.

Уг нь зүй нь саалийн үнээ гэвэл саалийн үнээндээ тэжээл өгөөд саалийн үнээ маань таргалаад, гарсан сүү саалиа боловсруулаад бид нар явах ёстой байтал одоо саалийн үнээгээ алж авч байна бид нар. Яг одоо Монголын эдийн засгийн нөхцөл байдал яг л ийм. Тэгэхлээр Монголбанкны Ерөнхийлөгч гэдэг албан тушаал уг нь 1 дүгээрт нь мэргэжлийн, 2 дугаарт нь бие даасан байдлыг, хараат бус байдлыг хангаж ажиллаж чадах ийм хүн Монголбанкны Ерөнхийлөгчөөр очих ёстой гэж миний хувьд боддог.

Тэгэхээр одоо орж ирж байгаа нэр дэвшигчийн хувьд, Наранцогт нэр дэвшигчийн хувьд яг энэ 2 шаардлагад нийцэж байна гэдэгт би хувьдаа маш их эргэлзэж байна. Ажлын түүхийг нь харахад Боловсролын яаманд ажиллаж байсан, Хөдөлмөрийн яаманд ажиллаж байсан, Эдийн засгийн яаманд ажиллаж байсан, Сангийн яаманд ажиллаж байсан, Хөгжлийн банканд ажиллаж байсан, Эрдэнэс Монголд ажиллаж байсан. 10 жилд хэчнээн ч олон ажил хашдаг юм энэ бүгд чинь тэгээд л нэг улс төрийн л томилгоо шүү дээ яг үнэндээ. Ийм олон улс төрийн томилгоо, энэний цаана тэр хараат бус ажиллах гэдэг, бие даасан ажиллагаа, Монголбанкны мөнгөний бодлогыг бие дааж авч явна гэдэг үнэхээр бол надад хүндрэлтэй л харагдаж байна 1 дүгээрт.

2 дугаарт нь тэр мөнгөний бодлого яг бусад газар дээр менежер янз бүрийн хүмүүс бас очиж болдог. Яам Тамгын газар дээр менежерүүд менежментийн ажил

гэдэг үүднээсээ бас очиж болдог. Яг Монголбанкийг ийм менежмент байдлаар, улс төр байдлаар удирдана гэдэг бол бид нарын өмнөх л дутагдлууд. Тэгээд Монголбанкин дээр явж ирсэн нь мэдээж Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн хувьд бас яг ажил хэрэг, мэргэжлийн талдаа гайгүй юм шиг байгаа юм. Тэр хараат бус байдал дээр л их алдаа гаргасан гэж боддог. Яг өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал, олон зүйлүүдийг харахад үнэхээр энэ нэг бодлогын хүү, олон олон зүйлүүдийг харахад арилжааны банкнууд нь би бол арилжааны банк, бизнес эрхлэгчдийн талд л байдаг. Тэгэхдээ яг өнөөгийн нөхцөл байдлыг харахад бодлогын хүү 12 хувьтай. 12 хувийн цаана арилжааны банкнууд 10 их наядын бондыг Монголбанкнаас сул аваад үндсэндээ жилдээ 1, 2 их наядаар нь хүүгийн орлого олоод сууж байдаг. Энэ мөнгө чинь уг нь бизнесүүд рүү очих ёстой л мөнгө шүү дээ. Эдийн засгийн эргэлтэд цусны эргэлт болж очиж байх ёстой энэ мөнгө бизнес дээр очдоггүй. Тэгэхлээр.../минут дуусав./

Н.Учрал: Цогтгэрэл даргад нэмэлт 1 минут өгье.

О.Цогтгэрэл: Тэгэхлээр харин энэ бүгдийг Наранцогт нэр дэвшигчийг хангаж ажиллаасай гэж тэгэхдээ тэгээд би хангаж ажиллаж чадна гэдэгт эргэлзэж байна. Анхнаасаа бас би өөрийн байр сууриа хэлье гэж бодож байна. Бие даасан байдал, мэргэжлийн байдал 2 дээр таны хувьд үнэхээр тийм шаардлага хангасан харагдахгүй байна шүү. Энийг уг нь бас нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов гэдэг шиг биш бүр илүү сайжруулаад тэр бүхэл бүтэн салбар системд бэлтгэгдсэн болгосон гэдэг чинь уг нь асар их л байдаг байлгүй. Монголбанк Сангийн яамны бэлтгэгдсэн боловсон хүчин сайтай газар л гэж боддог. Гэтэл тэнд бэлтгэгдсэн боловсон хүчнээс биш ингээд нэг ийм менежментийн маягийг нь хүн л, санхүү, нягтлан бодох маягийн хүн яг нягтлан бодох маягийн мэргэжилтэй ч хүн биш байх. Тэр талын л нэг ийм хүн л очиж байгаад би жоохон харамсалтай л байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын даргын зүгээс хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Наранцогт даргыг нэр дэвшүүлсэн. Тэгээд энэ бол их улс төрийн томилгоо огт биш. Төрд бэлтгэгдсэн мэргэжилтэн гэдэг ийм шалгуураар л нэр дэвшүүлсэн. Ингээд анкет CV-г нь харахаар сонгуулийн 4, 4-н жилийн циклээр л яамнуудад ажилласан байгаа юм л даа. Сонгуулийн жилүүдээр. Тэгээд үе үед өөр өөр нам засаглаж байсан. Аль аль намаас томилогдсон сайд нартай мэргэжлийн хувьд тэнцээд л ажиллаж ирсэн юм байна лээ. 4, 4-н жилээр. Тэгээд Хөдөлмөрийн яаманд ч тэр, Боловсролын яаманд ч тэр тэр төрийн сангийнх нь даргыг л хийж байсан. Ийм л бас санхүүгийн мэргэжлийн хүн гэж нэр дэвшүүлсэн.

Ер нь манай улс хүний нөөцийн хувьд их хүнд болж байгаа шүү. Бид нар нэг ийм сонсгол нэртэй тэгээд ажилд аваачихаасаа өмнө 14 хоног сошиалаар бараг дүүжилж байгаад аваачаад томилж байна л даа ямар ч хүнийг. Энэ шалгуурыг авч гарч чадаж байгаа хүн бол их ховорхон. Харин Наранцогт дарга нийгмээрээ шүүлгээд ямар нэгэн асуудалгүйгээр өнөөдөр бас ингээд очиж байх шиг байна ажилд, бололцоо бүрдэж байх шиг байна. Тэрнээс биш 14 хоногийн нийгмийн шалгуурыг даваад, сошиал тэр bully-ийг даваад ажилд очно гэдэг бол их л хүнд даваа. Тэгээд төрд байгаа хэдэн хүнээ тал талаас нь бөөрөлхсөөр байгаад ер нь төрд хүн ажиллахад их хүнд болж байна. Тийм учраас бид аливаа хүнийг ажилд нь аваачихаас өмнө баримт нотолгоогүйгээр асуудалд хандах биш үндэслэл бүхий асуултуудыг асуугаад ингээд дүгнээд явах нь цаашдаа зөв юм гэдгийг бас хэлье.

Сайнзориг гишүүнд би микрофон өгье. Сайнзориг гишүүн түрүүн үүдэнд байж байгаад тэгээд. Би ер нь уян налархай Их Хурлын дарга хийж байгаа шүү дээ. Асуудалд их уян хатан хандаад байгаа шүү дээ. Та нар хайр даавал би ингээд л аятайхан л байж байгаа шүү дээ. Пүрэвжавын Сайнзориг шүү.

П.Сайнзориг: Баярлалаа. Би бас үүдэнд сууж байгаад нөгөө нэр өмнөх гишүүд маань танхимд байгаагүйгээрээ хурдтай явчихсан юм байна. Бас боломж олгож байгаад баярлалаа. Нэр дэвшигчээс цөөн хэдэн асуулт асууя. Зарчмын хувьд Наранцогт нэр дэвшигчийг дэмжиж байна.

1 дүгээрт энэ Монголбанкны бүтцийн асуудал сая Хурлын дарга ч гэсэн хэлээд байна 700 гарлаа. Бараг ингээд сонсгол хийж байхад ч гэсэн тийм томилгоонууд явж байна. Магадгүй тэр томилгоо нь үнэхээр зайлшгүй байсан бол хамаа байж уу. Тэгэхээр өнөө, маргаашгүй ажлаа өгөх гэж байгаа хүн тэнд томилгоо хийгээд сууж байна гэдэг бол маш том ёс зүйгүй л асуудал л даа.

Тэгэхээр энэ бүтцийн хувьд та бас өнөөдрийн Монголбанкны бүтцийг юу гэж харж байгаа вэ? Энэ бүтцийн яг ийм тийм ажиллах ёстой гэхээсээ илүүтэй орон тооны тэр дээд хязгаарыг баталж өгдөггүйгээс болоод хүссэн орон тоогоо нэмээд явж байна. Тэгээд энэ тайлбаруудыг жишээ нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх чиглэлд бас Монголбанк үүрэг хүлээж байгаа учраас энэ тэр гээд яриад байгаа юм. Гэтэл яг энэ чиглэлд хамгийн их үүрэг хүлээсэн нь Санхүүгийн зохицуулах хороо байхгүй юу. Гэтэл ингээд л бас ажиллах гээд үзээд болоод байдаг. Монголбанк маань ямар үндэслэлээр ингээд 700 хүрчхэв гэдэг дээр та бас юун түрүүнд очоод нэг дүгнэлт хийгээч.

Би энэ төрийн аудитын сэдэв дээр энэ Монголбанкны хүний нөөцийн асуудал дээр аудит хийлгэе гэсэн чинь Монголбанкны хараат бус байдалтай холбоотойгоор бас болохгүй байгаа гээд. Ерөөсөө Монголд байна шүү дээ хараат бус байдлын ард ганц дураараа дургиж байгаа газар бол Монголбанк болсон. Орон тооны дээд хязгаараа батлуулдаггүй, төсвөө батлуулдаггүй, төсөв орон тоон дээрээ аудит хийлгэдэггүй. Уг нь ямар ч төрийн институц ядаж орон тооны дээд хязгаараа батлуулж байгаа. Тэгэхээр энэ уг асуудал дээр та ер нь зарчмын ямар байр суурь орох вэ? Ер нь төсвийг ч гэсэн бас тодорхой Улсын Их Хуралд ядаж танилцуулдаг баймаар байгаа шүү баталчхаад. Ийм дураараа бас Монголбанк явж болохгүй байгаад байгаа юмб Энийг нэг анхаараач ээ.

Тэгээд манай хяналтын зөвлөлийн гишүүд ч гэсэн мэдээлэлд бас их хүрч чаддаггүй юм шиг байгаа юм. Тэгээд л тэр хэдийг маань нэг ойр зуурхан байдлаар аргалаад ингээд явчихдаг. Тэгэхээр Улсын Их Хурал нөгөө бүрэн мэдээлэлтэй танилцахгүй байгаа учраас шийдвэрээ гаргаж чадахгүй байна. Энэ дээр та нэг байр сууриа хэлээч.

2 дугаарт энэ арилжааны банкнуудыг хувьцаа эзэмшигчид 5-аас дээш хувийг нь авч болохгүй ч гэдэг юм уу. Ингээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийг хязгаарлах байдалтайгаар явсан. Энэ хуулийн асуудал дээр та юу гэж боддог вэ хуулийн зохицуулалтыг? Ер нь эргэж харах бодлого байгаа юу? Энэ чинь өөрөө эргээд бусад 95 хувийг нь хэн эзэмших нь ойлгомжгүй юман дээр ингэж хүн ер нь өөрийнхөө мөнгийг оруулах болов уу? Хяналтын багцыг ядаж орж ирэх хэмжээнд ч гэдэг юм уу, эсвэл идэвхтэй байдлаар хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх

тэр бололцоо бүрдээгүй байж байхад яаж энэ 5-хан хувийг авчхаад явж болох оо? Тэгээд хэдүүлээ бас нэг банкны салбарынхан шулж байна энэ тэр гээд мессежийг хаясаар байгаад сүүлдээ ингээд нэг ийм банкны хувь энэ IPO-ийн хууль ч гэсэн хэрэгжихгүй талдаа байна. Энэ дээр та байр сууриа хэлээч.

Гадаадын банкиг оруулж ирэх тал дээр бас ямар байр суурьтай ажиллах вэ? Та бас хэлээч. Ер нь нээлттэй гээд байгаа боловч бас бодлогын хүрээнд тээг сад нь байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар БГД-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн албан хаагчдын хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сурагч дүү нартаа, хүүхдүүддээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэж байна. Сурлагын амжилт хүсье.

Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт хариулна.

С.Наранцогт: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Энэ бүтцийн хувьд би нөгөө томилогдож очоогүй учраас яг хэдэн хүн ямар бүтэцтэй ажиллаж байгаа гэдэг нарийн мэдээлэл алга байна. Тийм учраас таны хэлж байгаа саналыг бүрэн дүүрэн хүлээж авч байна. Ер нь хэрэв одоо энэ 700 гаруй хүн байгаа бол өчигдөр бас 60 гаран хүн томилогдсон гээд ийм яриа байна. Энэ бол ингээд 5-аас 6 яам гэсэн үг. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын тал гэсэн үг.

Тэгэхээр энэ хэмжээний ажил бас хийж байгаа юу үгүй юү гэдэг. Би Монголбанканд Монгол Улсын шилдэг банкны мэргэжилтнүүд, салбарын мэргэжилтнүүд бас ажиллаж байгаад итгэлтэй байгаа. Тэнд тэр дээр үед бид нар бас хамтарч ажилладаг байсан. Одоо бас яг энэ ямархуу түвшинд очсон бэ гэдэг дээр нэлээн нухацтай хандана. Би мөрийн хөтөлбөртөө ч тусгасан. Энэ бол төрийн төв институц. Улсын Их Хурлын харьяа төрийн төв институц. Итгэл даахуйц төрийн манлайлал үзүүлдэг ийм байгууллага болох ёстой. Энэ төрийн ч юм шиг, хувийн ч юм шиг ийм hybrid маягийн ийм байдал руу орж болохгүй. Төрийн хэмнэлтийн хуулийг барих ёстой. Мэдээж би энэ алдагдал үүсэж байгаа нь төрийн мөнгөний бодлого, өмнөх бодлогуудынхаа алдааг буцааж засаад ингээд их хэмжээний алдагдалд ороод явж байгаа асуудлыг ойлгож байгаа. Тэгэхдээ энэ тухайн байгууллагын өөрийн үр ашиг, үйл ажиллагаа бол үлгэр жишээ болох ёстой. Төрийн албаны ёс зүйд нийцэж ажиллах ёстой гэж ингэж бодож байна. Эхний асуудал дээр би ийм бодолтой.

2 дугаар асуудал IPO-ийн хэрэгжилт удаан байгаа нь бас цаанаа яг ямар шалтгаантай вэ гэдэг дээр би бас дахиад нарийн мэдээлэл ажилд томилогдвол энэ дээр нэлээн нухацтай хандана. Таны бас бодож байгаа бас үнэн. Бид нар ингээд хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэхгүй, хөгжиж чадахгүй нэлээн яваад байна шүү дээ энэ маань ингээд нөгөө компанийнхаа засаглал, энэ хувьцааны цаад талын агуулга энэ тэр дээрээ бас давхар нарийн бодож байхгүй бол хяналтын багц дотоодод нэлээн ингээд яачихсан би нэг тийм судалгаа маягийн юм уншсан. Юу гэхээр ингээд дахиад нэмж банкнууд хувьцаа болгохоор манай дотоодын хөрөнгийн зах зээл дээр орон зай багатай гээд. Тэгээд гадаад хөрөнгө оруулалт орж ирье гэвэл гадна сайн. Энийг оруулж ирэх ёстой.

Тэгэхдээ 34 хувийн хяналтын багцыг авч чадахгүйгээр их хэмжээний мөнгө манай улс руу оруулах уу үгүй юү гэдэг асуудал бас эргэлзээтэй. Одоогоор санал ирсэн эсэхийг би сайн мэдэхгүй байна. Энийг ажилд томилогдвол очиж энэ банкныхантай нь ч гэсэн нэлээн тулж ажиллах ёстой гэсэн ийм бодолтой байна.

Гаднын банкны хувьд би гаднын банк орж ирэхийг дэмждэг үзэл бодолтой. Тэгэхдээ ашгийн төлөө гуравдагч орны хувийн банкныг бид нар бараг урьж оруулах ёстой. Ингэж байж бид нар гаднын хямд эх үүсвэр, гадаадын шокт хариу үзүүлэх шинэ технологи, менежмент, энэ бүх гадаадын хөрөнгө оруулалтын сайн талууд дагалдаж орж ирдэг. Зүгээр харин бид нар стратегийн юм уу, эсвэл төрийн өмчит банкны хувьд мэдээж энэ улсын эдийн засаг, аюулгүй байдлын талаасаа ч тэр бид нар нэлээн бас бас бодолцож үзэх ёстой асуудал гэж ингэж бодож байна.

Н.Учрал: Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Нэр дэвшигчид бас яг ярьж байгаа энэ ажлаа та бас томилогдсон тохиолдолд бас хэрэгжүүлж ажиллахыг хүсэж байна. Тэгээд ер нь сүүлийн үед ингээд арилжааны банкнуудыг харахаар хэрэглээний зээл дээрээ их төвлөрчихсөн, хэрэглээний зээлийн ажил, асуудал нь энэ улс Улсын Их Хурлын танхим дээр хүртэл улс төр болж байна. Яг үнэндээ хэлэхэд ахмадуудын тэтгэвэр хангалттай хэмжээнд олгогддог болох ёстой болохоос биш зээл авах асуудлыг нь бид яриад сууж байгаа нь аймаар эмгэнэлтэй байгаа байхгүй юу.

Ер нь энэ хэрэглээний зээлийг дэмжих гэхээсээ илүүтэйгээр энэ бизнесийн зээлийг, хямд эх үүсвэртэй бизнесийн зээлийг олгох бодлогын өөрчлөлтүүд дээр та бас жоохон манлайлж ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд өнөөдрийн явж байгаа энэ төсвийн бодлого, мөнгөний бодлого дээр та бас ер нь ямар зарчмын байр суурьтай байгаа юм? Өнөөдрийн яг энэ явж байгаа зарчим хуулийн зохицуулалтаар яваад байж болохоор байна уу? Та аль алинд нь Сангийн яаманд ажиллаж байсан хүн одоо ингээд Монголбанкн дээр очих гэж байна. Тэгэхээр энэ дээр бас өөрчлөлтүүд шаардлага байгаа юу, юу гэж бодож байгаа вэ? Тэгэхээр та бас энэ дээр товчхон товчхон хариулаач.

Н.Учрал: Нэр дэвшигч хариулна.

С.Наранцогт: Сайнзориг гишүүний асуултад тодруулж хариулъя. Таны яг хэлж байгаа энэ зээлийн бүтэц бол макро тэнцвэртэй зохицуулалтын хүрээнд хийгдэх ёстой ажил. Энэ дээр яаралтай бас бид нар анхаарал тавьж хийх ёстой. Өөрөөр хэлбэл бодлогын хүү өндөр удаан явснаас болж энэ үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нэлээн хүнд байдалд орчихсон байгаа гэдэгтэй би санал нэг байна. Тэгэхээр энэ дээр бид нар би анхаарал тавьж ажиллана.

2 дугаар асуудал төсөв мөнгөний бодлогын уялдаа. Ер нь уялдаагүй яваад 2 талдаа мөчлөг дагаж ирснээр л өнөөдрийн хөөс бий болсон. Тэгэхээр энэ дээр зайлшгүй энийг төсөв, мөнгөний бодлого хамт хэрэгжихгүй бол үр дүн их багатай болно. Тэгэхээр эрх зүйн хувьд заавал механизм бас сайжрах ёстой. Ер нь би энэ ажилд томилогдвол Их Хуралд мөнгөний бодлого яагаад чухал юм гэдэг талаар ер нь нэлээн бас ойлголт юмыг өгнө гэсэн ийм бодолтой байгаа. Энийгээ их нухацтай хэлэлцдэг болоод яах вэ төсөв дээр нэг ийм зохицуулалт нэмэгдсэн шүү дээ. Энэ Тэмүү.../минут дуусав./

Н.Учрал: Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Улсын Их Хурлын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд оруулж ирж байгаа томилгоо учраас дэмжээд явуулъя. Монголбанк цэвэр мэргэжлийн байгууллага. Тэнд ажилдаа эзэн болсон мэргэжлээрээ өсөж дэвжээд явж байгаа мэргэжлийн карьер хөөж байгаа бас сайхан залуучууд байгаа. Гэхдээ сайны хажуугаар саар гэж Монголбанкин дээр бүүр саар нь маш их байгаа. Өнгөрсөн хугацаанд Лхагвасүрэн Ерөнхийлөгч тэр саар улсуудтай бас нэг их л бүдэг бадаг замаар явж ирсэн байх. Алдаа дутагдал нь өнгөрсөн хугацааных. Одоо бол тэнд очих юм бол та нэлээн засаж залруулах, үйл ажиллагаа талаасаа нэлээн засаж залруулах ажлууд байгаа. Тэр дээр анхаарч ажиллаарай гэж хэлж байгаа юм. Төрийн банкны захирал шиг ажил албан тушаал гарахаар нэр нь яригдаж байдаг нялх сэнгүүнүүд тэр төрийн банкаар үгүй энэ Монголбанкаар дүүрэн байгаа. Ажил хийдэггүй, албан тушаал ярьдаг. Болдог бүгдээрээ дарга, сайд, Их Хурлын гишүүн болчих амбицтай. Гэсэн мөртөө бодит байдал дээр ажил хийдэг ур чадвартай хүн байхгүй. Тэгэхээр тэр талаас нь бас сайн харж ажиллахгүй бол гэж танд захиж хэлэх гэсэн юм.

Бас нөгөөтээгүүр энэ Дэд Ерөнхийлөгч нь хуулиар олгогдоогүй ажлаа хийдэг. Хуулиар олгогдоогүй ажлаа хийдэг. Занданшатар Ерөнхий сайдын туслах байсан нөхөр ямар ч салбарын мэдлэг, мэдээлэлгүй мэргэжлийн биш хүн тэнд очоод суучихсан. Одоо ажилладаг хадгаламжийн даатгалын корпорацынхаа тушаалуудыг хэвлэлд өгөөд л балбаад өг гээд хүн балбуулах гээд явж байдаг ийм ёс зүйгүй хүмүүс хүртэл тэр дотор сууж байгаа юм. Эд нарыгаа цэвэрлэх ажил бас нэлээн хийгдэх байх гэж бодож байна. Тэгээд танд амжилт хүсье. Вакумжаад байж болохгүй шүү. Очоод та ингээд нэг юм дураараа загнаад буруу, зөрүү юм хийгээд явах юм бол огцруулах шаардлагыг эндээс би өөрөө манлайлж хийх болно шүү гэдгийг бас анхааруулаад хэлэх гэсэн юм.

Тэгээд энэ сая хөдөө 2 хоног Өвөрхангай, Архангай аймагт ажиллачхаад ирлээ. Худлаа ярьдаг 2 сайддаа хариуцлага тооцохгүй бол юу нэмээд баахан дэд сайд нар вэ? Өвөрхангай аймгийн Төрийн сантай уулзлаа. Үндсэн цалингаа л олгож байна. Нэмэлт цалин алга. Урамшуулалт цалин алга. Төрийн албан хаагч нарын чинь хэлж байгаа үг шүү. Тэр хүмүүс чинь бас өөрөө тийм цалин авна, тийм хэмжээний зээл төлнө гээд хувийн санхүүгээ төлөвлөчихсөн явж байтал Төрийн санд нь ажиллаж байгаа хүмүүс нь тэр цалин нь ирэхгүй болохоор одоо бусад нь яах юм? Сангийн сайд мөнгөгүй гэж, мөнгөтэй гэж худлаа ярьдаг, энэ Түлш, эрчим хүчний сайд Дамдинням бензинтэй гэж худлаа ярьдаг, олгодоггүй гэж худлаа ярьдаг. Сүүлдээ бензин колонкийн түгээгч нар руу орж байна шүү дээ. Квот квотоор олгоод цалингаа авдаг юм байна лээ гээд ийм хөлдүү хөлдүү тайлбар хийгээд байгаа энэ сайд, энэ яамандаа хариуцлага хэзээ тооцох юм бэ Ерөнхий сайд? Тэгээд ийм буруу юм яриад байгаа сайд нарынхаа асуудлыг ярихгүй юм бол нэмээд дэд сайд гээд ингээд төр чинь улам данхар болоод байгааг эвээр хүлээж авах боломж байхгүй. Монгол улс мөнгөгүй гэж зовлондоо уначхаад байхад дахиад дээрээс нь юун төсвөөс цалин авдаг дэд сайд нарын асуудал вэ? 1 минут нэмээд авч болох уу?

Н.Учрал: Нэмэлт 1 минут Цогтоо гишүүнд өгье.

Да.Цогтбаатар: Өвөрхангай аймаг яг төрийн сангийнх нь даргын хэлснээр 7-8 хоногийн бензиний нөөц байна. Тэгээд яг энэ чигээрээ байна гэвэл Өвөрхангай аймаг хөлдөхөд бэлэн байна. Нүүрснийхээ хэдэн машинд тэр цохолтоор бензинийг нь олгож байна. Бусад үед бензин бас л хүнд байдалд орчихлоо түлш. Тэгэхээр ингээд аймгуудаасаа эхлээд хөлдөж эхлэх гэж байна. Тэгээд сайд нар нь болохоор энд ажлаа хийж чадахгүй дэд сайд аваад ёстой мэргэжлийн хүн ирээд байна гээд байх юм.

Тэгвэл сайд нараа огцруулаад оронд нь тэр дэд сайд болох гээд байгаа мундаг залуучуудаа тавьчих л даа. Энэ түлшний, савны асуудал чинь 30 жил явж ирсэн өнөөдрийнх шиг ийм нөхцөлд хүндэрч байгаагүй шүү дээ. Яаж ажил хийх вэ гэдэг гарц гаргалгаа шийдлээ ярихгүйгээр худлаа улс төр хийгээд үгүй чадахгүй бол түлшний савгүй сууж байна биз дээ гээд ийм ялархсан байдалтай суугаад байх юм сайд нар чинь. Улсын Их Хурлын дарга бас энэ дээр зарчмаа нийлүүлээд энэ засгийг шахаж ажилламаар байна. Та Улсын Их Хурлын дарга шүү дээ. Засгийн газрын нэрийн өмнөөс ажиллахгүй байх.

Н.Учрал: Зарчмын бас шаардлагууд тавьж байна шүү. Тэгээд нэр дэвшигч анхаарч ажиллана байх. Асуултад хариулт авах уу Цогтбаатар гишүүн? Санал хэлж байна. Цогтбаатар гишүүний энэ зарчмын шаардлагуудыг хүлээж авч эргээд Цогтбаатар гишүүн болон Их Хуралд бас тэр холбогдоод нэр яригдаад байгаа түрүүн бас яригдаад байсан тэр бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ахмадууд та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай төвийн бүсээс сонгогдсон Ундрам гишүүн ганц дайчин ганцаардахгүй гэж ганц эмэгтэй гишүүн бас сайн ажиллаж байгааг төвийн бүсийнхэндээ хэлье. Баярлалаа.

Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна. Ганзориг гишүүн байхгүй байна. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Наранцогт даргыг Монголбанкны Ерөнхийлөгч нэр дэвшиж байгаад бас түүхийг нь хараад, бас ажиллаж байсан туршлагыг нь хараад дэмжиж байна. Танд ажлын амжилт хүсье. Хэд 3 зүйл, ер нь олон зүйл яримаар байна минут багтахгүй учраас 2 зүйлийг анхаараач гэж хэлэх гэсэн юм. Энэ ипотекийн зээлийг зорилтот бүлэгт нь өгөх тал дээр та онцгой ахиц гаргаач. Миний ойлгож байгаагаар ипотекийн зээл энэ түгжрэлийг бууруулах, хөдөө орон нутгийн хөгжил дэвшил энэ бүгдийг цогцоор нь шийдэх ийм бодлого ийм байгаа юм. Өнөөдөр Монгол Улс 2 өөр Монгол болчихлоо. Агаарын бохирдолтой, хөрсний бохирдолтой, түгжрэл, утаатай Улаанбаатар хот. Нийт хүн амын 50 хувь нь.

Нөгөөдөх нь дэлгэсэн тэрлэг шиг маш том нутагт 21 аймаг хөдөөгийн 300 гаруй сум. Тэгэхлээр энэ ипотекийн зээлийг орон нутагт илүү түлхүү хуваарилаач. Өнгөрсөн хугацааны олголтыг харахад бараг 50, 60 хувь нь орон сууцнаас орон сууцад шилжих, орон сууцаа томруулах ингээд зорилтот бүлэгтээ олгогдохгүй байгаа юм. Хөдөөд үндсэндээ боловсон хүчин үнэхээр ховордож байна. Эмч, багш

нар юу гэдэг юм чанартай боловсон хүчин. Судлаад үзэхэд ерөөсөө л орон сууцын асуудал 1 дүгээрт байдаг юм.

Тийм учраас энэ ипотекийн зээлийн олголтыг хөдөөгийн 21 аймаг 330 гаруй сумд квоттой болгомоор байна. Тэгэхгүй бол хэн танилтай, талтай, хэн сүлжээтэй нь авдаг энэ нөхцөл байдлаас салах хэрэгтэй. Дээр нь хотын төвд бизнесийн зорилгоор ерөөсөө өгөхийг хориглох хэрэгтэй байна. Энэ нөхцөл байдал дээр та бас онцгой анхаарч ажиллаач. Дээр нь метр квадратыг жижгэрүүлэх, анх удаа орон сууцад орох боломжийг хангах, утаа униар, яндан салгах, хөдөө орон нутагт л одоо чанартай боловсон хүчнийг аваачих тал дээр онцгой анхаарч өгөөч гэсэн ийм саналыг хэлэх гэсэн юм.

Дараагийн нэг зүйл бол ойрд маш их олон томилгоонууд болж байна. Энэ томилгоон дундаас хамгийн ард иргэдийн хүсэн хүлээхгүй байгаа зүйл бол дэд сайдын асуудал. 24 оны сонгуулиар бүрдсэн Засгийн газар дэд сайдгүй яваад ирсэн цаашдаа дэд сайдгүй явна гэж тунхаглаж байсан. Гэвч юу гэдэг юм намын өр зээлээ, зодоон ноцооноо тайвшруулахын тулд 16 дэд сайд гаргаж ирж байгаа энэ явдал үнэхээр ард түмний дургүйцлийг хүргэж байна. Өнөөдөр

Н.Учрал: Эхлээд хариулна нэр дэвшигч Санжаагийн Наранцогт хариулна. Дараа нь нэмэлт 1 минут. Шууд Батсуурь гишүүнд нэмэлт 1 минут өгье. Батсуурь гишүүн одоо асуултаа асуугаарай.

Ж.Батсуурь: Тийм. Тэгэхлээр энэ дэд сайдын асуудлуудаа анхаараач ээ Их Хурлын дарга та энэ Засгийн газарт нэг зүг чиг өгөөч ээ. Өнөөдөр төрийн албан хаагчдын тоо бол саяхан л 100 хэдэн мянга гэж байсан одоо 200 гаруй мянга гаруй байсан, 300 мянга ч хүрэх гээд байгаа юм уу. Нийт ажил алба хэрэглэж байгаа хүмүүс чинь ихэнх нь төрийн албан хаагч болчихлоо.

Тэгээд энэ сандал суудлын асуудлаа болиоч ээ. Өнөөдөр төсвийн болон бусад хөрөнгө оруулалтаар ажлаа хийсэн хүмүүс мөнгө төгрөгөө авч чадахгүй, ажил хийлгэсэн хүмүүс нь мөнгө төгрөгөө өгч чадахгүй эдийн засгийн нөхцөл байдал ийм хүндээр тусчхаад байхад тэгээд энэ оны заагаар хүмүүсийн баяр наадам тэмдэглэх гэж байгаа анхаарал сарнисан үед нөгөө чоно борооноор гэдэг шиг энд дэд сайдын асуудал оруулж ирж байгаа үнэхээр ард түмнийг цөхрөнг нь баруулж байна. Ийм учраас энэ дэд сайдын асуудлыг хориглохыг Засгийн газарт Их Хурлын зүгээс ч.../минут дуусав./

Н.Учрал: Тийм Батсуурь гишүүн санал хэллээ. Нэр дэвшигч Наранцогт дарга анхаарах хэрэгтэй. Батсуурь гишүүн та биднийг нөгөө хамтарсан Засгийн газарт ажиллаж байхад ажиллаж байсан тийм нөгөө 28 Үндэсний хороо буугаад мэдээж Засгийн газар 2.2 их наядын хэмнэлт хийгээд нэлээдгүй хэмнэлтүүд явж байгаа юм байна. Тийм мэдээллүүдийг авч байна.

Ер нь Үндэсний хороо бол бараг хамгийн багадаа дунджаар 20 хүнтэй байсан. Тэгэхээр энэ орон тоо нэг Үндэсний хороонд ч хүрэхээргүй ийм тооцооллуудыг гаргасан юм байна. Энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээллүүдийг өгөх байх. Тэгэхээр бүгдээрээ сахилга бат, хариуцлагаа мэдээж нэмэгдүүлнэ. Монголбанкин дээр энэ орон тоо нэмэгдсэн асуудлууд байна. Тэгээд юу гэж нэрлэхдээ л байгаад байх шиг байна. Тэрнээс биш нөгөө Үндэсний хороо элдэв

менежер гэж нэрлэхээр болоод байдаг ингээд нэг ийм асуудлууд үүсээд байна гэж ойлгож байна.

Бадрахын Наидалаа гишүүн байна уу? Байна.

Б.Надалаа: Байна. Би нэр дэвшигчийн сонсгол дээр нэлээн олон асуулт асуугаад хариулт аваад саналаа хэлчихсэн болохоор маш товчхон 2-хон зүйлийг давтаад хэлье.

1 дүгээрт Монголбанк буюу Төв банкны чиг үүргийг шинэчлэн тогтоох зөвөөр нь ойлгуулах яг бодлогын түвшинд ер нь олон нийтийн түвшинд ч гэсэндээ яг ямар чиг үүрэгтэй юу хийдгийг нь ялгаа заагийг нь гаргаж өгөөд тэрийг зөв байршуулахын төлөө бас ажиллаарай гэж хүсье. Яагаад гэвэл сүүлийн үед хараад байхад дээр үеийн улсын банк юм шиг аж ахуйн чанартай зээлийн чанартай бүх юмыг зохицуулдаг юм шиг, зээл олгодог юм шиг хандлагаар бүгдээрээ хандаж байгаа нь энэ Төв банкны чиг үүргийг хэрэгжүүлэхэд саад болж байгаа зүйл гэж би бодож байна.

2 дахь нь мөн адилхан зарчмын санал, хүсэлт. Мөнгөний бодлого, мөнгөний бодлого бол Монгол Улсад яг үнэндээ төсвийн бодлогын араас төсвийн бодлогын алдаа шаврыг нь цэвэрлэдэг мэт тиймэрхүү ач холбогдол багатай бодлого байгаа яг үнэндээ бол. Тэгээд энийг арай ач холбогдлыг нь өндөрсгөх талаар, төсвийн бодлоготой уялдуулах талаар, бас магадгүй төсвийн зарим шаардлагатай нийцүүлж суурь нөхцөл болгох талаар ажиллахгүй бол мөнгөний бодлогын үр дүн маш бага байгаа. Тэгэхээр төсвийн бодлоготой ямар нэгэн байдлаар уялдуулах хооронд нь холбож уях төсвийн шаардлагуудтай нийцүүлэх тийм асуудал байгаа. Энэ дээр та бас анхаарч ажиллаарай гэж хүсье. Тэгээд Монголбанкны ерөнхийлөгчөөр нэр дэвшиж байгаа Наранцогт нэр дэвшигчид амжилт хүсье. Баярлалаа.

Н.Учрал: Түрүүн нэр өгөөд байсан Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ өдрийн мэнд хүргэе. Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа Наранцогт нэр дэвшигчийг нэр дэмжиж байгаа олон газар ажиллаж байсан туршлагатай ийм хүн Монголбанкны ажлыг зөв аваад явчих байх гэж бодож байна. Энэ төв төгрөгийн ханш уналт дээр нэлээн анхаарч ажиллах хэрэгтэй байна. Энэ асуудлыг нэлээн тусгайлж анхаарч Их Хуралд холбогдох Байнгын хороонд танилцуулах нь зүйтэй гэж үзэж байна. Түрүүн бас гишүүдийн яриад байгаа тэр ипотекийн зээлтэй холбоотой асуудлыг анхаарч ажиллаарай. Энэ бас Монголбанкин дээр болон бусад банкнууд дээр хол асуудал их байдаг юм байна. Овоорчихсон, танил тал харж ипотекийн зээлийг шийддэг, бүүр төлбөр мөнгө авдаг тухай асуудал ч яригдаад байгаа. Энэ дээр бүүр тусгайлан хяналт шалгалт хийх хэрэгтэй. Энийг Наранцогт Ерөнхийлөгчид сануулж хэлье.

Мөн тэр Монголбанкны тэр данхайсан бүтцийг анзаарах ёстой шүү. 200-гаад хүн байсан одоо 700 болсон юм байна. Баахан дарга нар болсон юм байна. Хувьдаа банк бустай, хувьдаа мөнгө төгрөг эргүүлдэг системтэй нөхдүүд Монголбанк удирддаг сурагтай байгаа. Энийг цэгцэлж, цэвэрлэж цэвэрлээрэй. Нөгөө олон хяналтын менежерүүдээс Монголбанкин дээр бас томилогдсон байх вий очоод явуулаарай. Хэрэв тэр хяналтын менежер энэ тэр байгаа бол. Сүүлийн

үед нь улс төржөөд манай Ардчилсан намынхан мэдэгдэл хийгээд байгаа дэд сайд нарыг томиллоо, тэгэхээр бид нар хуралдаа орохгүй ч гэх шиг. Дэд сайд Засгийн газрын нэг хэсэг нь юм Амгаланбаатар гишүүн ээ. Өөрөөр хэлбэл энд сууж байгаа Батшугар сайд, Бат-Амгалан сайд нар энд сууж байгаад ард нь яамны ажил нь явж байх ёстой. Хурал дээр дуудагддаг.

Тэгэхээр оронд нь дэд сайд нар чинь Байнгын хороод дээр очиж асуултад хариулна яаман дээр ажлаа явуулна. Дэд сайд нарыг үнэхээр дэд сайд гэхээр хүнд хэцүү байгаад байгаа бол Ардчилсан намынхан маань нэрийг нь сольчих хэрэгтэй. Барилгын яамны дэд сайдыг хяналтын менежер гэдэг ч юм уу тийм нэр өгчихвөл. Тэгвэл бас манай Ардчилсан намынханд их таалагдах юм шиг байгаа юм. Нөгөө Ардчилсан намын томилсон 128 менежерийг чөлөөлж байгаа учраас 30 тэрбум төгрөг хэмнэж байгаа учраас Ардчилсан намд таалагдахгүй байгаа. Тэр менежер дотор чинь жинхэнэ хулгай хийсэн нөхдүүд бас байх шиг байгаа шүү тэр компанид очоод 10, 20 хувийг нь авъя барья гэж ярьж явдаг нөхдүүд байдаг гэж байгаа. Тэгэхлээр энэ 128 менежерийг хасаж, 30 тэрбум төгрөг хэмнэж байгаа явдал зөв өө. Тэгээд Ардчилсан намд таалагдахгүй байгаа дэд сайд нарын нэрийг өнөөдрөөс эхлээд менежер гээд нэрлэх. Цахим хөгжлийн яамны менежер гэдэг нэртэй болчихсон нь шүү дээ. Ийм саналыг хэлье. Ардчилсан намынхан маань тэгвэл хурал хуйндаа суух байх гэж бодож байна.

Н.Учрал: Нэр дэвшигч хариулна. Санал хэллээ дээ тийм. Батшугар гишүүн.

Э.Батшугар: Баярлалаа. Нэр дэвшигчид нэг сануулж онцгой сануулах нэг зүйл байна. Энэ нь энэ 5 сард Зээлийн мэдээллийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт орсон мөн үүнийг дагаад нэг тогтоол Улсын Их Хурлаар батлагдсан. Энэ нөгөө хар жагсаалт гэдэг зүйлийг байхгүй болгоод, ангилал байхгүй болгоод цэвэр онооны болон кредит скор-ын систем рүү орсон юм. Харамсалтай нь энэ бодит амьдралдаа хэрэгжихгүй байгаад байна. Тэгэхээр үүнийг хэрэгжүүлэхийн тулд та ямар арга хэмжээ авах вэ гэж асууя. Ингэж хэрэгжиж эхэлснээрээ ялт ч үгүй зээлээ төлчихсөн иргэдэд санхүүгийн боломжийг нь нээж өгнө. Ахиж зээл авах бололцоог нь онгойлгож өгч байгаа юм.

Хоёрт нь үндсэн чиглэлд Си Би Ди Си гэж орсон байгаа. Та үүн дээр бас онцгой анхаарч ажиллаарай. Энэ орчин үеийн мөнгөний бодлоготой бас нийцэж байгаа зүйл шүү. Зээлийн хүүгийн бүтцийг харахад бол 66 хувь нь ойролцоогоор эх үүсвэрийн зардал байдаг, 22 хувь нь үйл ажиллагаа ашиг, 15 хувь нь их эрсдэлийн зардал. Тэгэхээр энэ 15 хувь дээр ажиллах бас бололцоо байгаа 1 дүгээрт энэ кредит скор болон онооны систем доор бүрэн нэвтрүүлж эхлүүлснээр.

Хоёрт нь активын удирдлагын компани яаралтай Монгол Улсад хэрэгтэй институт юм байх ёстой зүйл. Тэгэхээр та бас үүнийгээ бас хуулийг нь оруулж ирэх байдлаар, боловсруулах байдлаар ажиллаарай гэж танд бас хэлье. Ингэснээр 15 хувь гэдэг чинь 18 хувийн дундаж зээлийн хүү чинь өөрөө 3 хувиар 15 хувь руу буух тийм бололцоо нь байгаа шүү гэж хэлмээр байна. Тэгээд таны ажилд бас амжилт хүсье.

Н.Учрал: Санал хэллээ. Энхтайваны Бат-Амгалан гишүүн.

Э.Бат-Амгалан: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Наранцогт даргыг ер нь дэмжиж байгаа, олон газраар ажиллачихсан, туршлага хуримтлуулсан олон жил төрд ажилласан ийм хүн дэмжиж байгаа. Ер нь манай барилгын салбартаа бас Монголбанк маань нэлээдгүй хамтарч ажиллах ёстой гэж ингэж харж байгаа. Ёстой гэдэг нь юу гэсэн үг юм бэ гэхлээр энэ ипотекийн зээлийн асуудалтай салбарын хэмжээнд цаашдаа хамтарч ажиллана гэж ингэж ойлгож байгаа. Монгол Улсын хэмжээнд өнөөдөр 1 сая орчим өрх ажиллаж амьдарч байна. улсын хэмжээнд түүний дал орчим хувь нь буюу 700 мянган өрх орон сууцаар буюу төвлөрсөн дулаан хангамж, инженерийн шугам сүлжээнд хамрагдаагүй ажиллаж байгаа.

Ерөнхий сайд Монгол Улсын Засгийн газраас 80 мянган айлын хөтөлбөр хэрэгжүүлээд орон сууцын бодлогыг бид нар дэмжээд ингээд ажиллаад явж байна. Яг одоо орон сууцжуулалтыг бодлогоор дэмжихээр тусгай зориулалтын банкны асуудал яригдаад ажлын хэсгүүд гараад ажиллаад явж байна. Тэгэхээр энэ банкны эх үүсвэрийг ямар ямар эх үүсвэрүүдээс бүрдүүлбэл зохимжтой гэж та харж байгаа вэ? Монголбанк бол энэ ажлын хэсгүүдэд танай банкны төлөөллүүд нэлээдгүй орсон байгаа. Мөн зөвхөн энэ орон сууц худалдан авах эрэлт талыг нь дэмжээд явахаас гадна нийлүүлэлт тал дээр нь ямар бодлого барьж ажиллах вэ гэж энэ бас цаашдаа асууя.

Ер нь эх үүсвэр бүрдээд 3-4 их наяд төгрөгийн эх үүсвэр бүрдээд энэ эрэлт, нийлүүлэлт талыг нь балансжуулаад тэнцвэржүүлээд ажиллах тохиолдолд энэ төгрөгийн ханш энэ инфляцын асуудлууд ер нь ямаршуухан хэмжээнд хөдөлгөөн орох бол гэж, хэрхэн нөлөөлөх гэж та харж байгаа вэ? Ер нь энэ барилгын салбартай Монголбанк маань нягт ойрхон уялдаж хамтарч ажилласнаар энэ ялангуяа нийслэл Улаанбаатар хотод энэ түгжрэлийн асуудал, энэ утааны асуудлуудыг шийдэхэд нэлээн дөхөм болох байх. Тийм болохлоор иргэдийн амьдралын чанарын түвшнийг тодорхой хэмжээнд сайжруулах ёстой гэж ингэж бодож байна. Таныг ажлаа аваад эрс шинэчлэл хийгээд барилгын салбартай хамтарч ажиллана гэж итгэж найдаж байна. Тэгээд дэмжиж байна.

Н.Учрал: Санал хэллээ. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

Э.Бат-Амгалан: Санал биш дарга асуулт асуусан.

Н.Учрал: Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Бат-Амгалан гишүүний асуултад хариулъя. Ипотек дээр бид нар яг би тантай санал нэг байна. Бид нар энэ зорилтот бүлгээ л маш сайн тодорхойлоод тэрнийхээ асуудлыг энэ хөнгөлөлттэй зээлээрээ шийдэж явах ёстой. Харамсалтай нь түрүүн хэлсэн яг зорилтот бүлгийн маань 40 хувь шийдэгдсэн. Тэгэхээр би энэ дээр онцгой анхаарна ажилд томилогдвол. Нийслэл бол ялангуяа энэ дээр бас энэ газар чөлөөлөлт, яндан буулгах чиглэлээр ингээд төсвөө заруулаад нэлээн ажил хийгээд концепцын хувьд бас зөв зөв концепцууд гаргаж байгаа юм байна лээ. Би энийг ажилд томилогдвол уулзаж нэлээн нарийвчилж бас ярина.

Ерөнхий зарчмын хувьд бид аль болох мөнгө хэвлэх биш бодит мөнгөөр л энийг санхүүжилтийг нь хийж явах учиртай. Энэ түрүүн бас асуултад хариулахдаа

орлогод нийцсэн үлдэгдэл зах зээл боломжтой хүмүүсийн зах зээлийг бид нар механизмаар бүрдүүлнэ. Тэр нийлүүлэлт тал дээр ер нь тэр энэ ялангуяа Улаанбаатар хот дээр нийслэлийн явуулж байгаа тэр концепцоор явахад бас нэлээдгүй юу гарч ирэх юм байна лээ. Яг инфляцын хувьд тооцоо мэдээж энэ хувийн тооцоо байгаа. Гэхдээ энэ төв банкин дээр ажиллаж байгаа мэргэжлийн хүмүүсийн яг модель дээр суурилсан тооцоон дээр ажиллаж би танд тодорхой мэдээлэл өгнө өө. Баярлалаа.

Н.Учрал: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Наранцогт даргыг бас дэмжиж байгаа гэдгээ бас илэрхийлье. Ажлаа эхэлж байгаатай холбогдолтой бас хэд хэдэн санал, асуултыг асууя. Монголбанкны орон тоотой холбогдолтой асуудал дээр бас онцгой анхаарал хандуулах, аливаа бас асуудлууд нь нууцаар орж ирж байгаа бас ийм асуудлууд бас байгаа. Ил тод нээлттэй байх тал дээр бас цаашдаа гол анхаарлаа хандуулж бас ажиллах нь зөв гэсэн ийм саналыг хэлэхээр байна.

Ахмадын тэтгэврийн асуудал дээр уул нь төр оролцоод байгаа сарын хугацааг нь их, бага гээд ингэхгүйгээр өөрсдөө зээлээ авах тэр эрхийг нь олгох нь зүйтэй байгаа юм. Харин үндсэн асуудал руугаа бид бүхэн бас анхаарал хандуулахгүйгээр тодорхой энэ зээлийн хүү бууруулах, тэтгэвэр нэмэгдүүлэх гэдэг энэ асуудлуудаа голчилж, бас ярьж, анхаарах хэрэгтэй байна гэдгийг би бас сануулан хэлье.

Ипотекийн зээлтэй холбогдолтой олон асуудлыг бас манай гишүүд хэлж байна. Зөвхөн энэ орон сууцын реформ сум, орон нутагт байгаа иргэдийг дэмжих асуудал дээр бид нар бас дундын хувилбаруудыг гаргаж ирэх хэрэгтэй байгааг бас танд сануулъя хэлье. Ялангуяа залуучуудын чиг хандлагууд бас их өөр болж байна. Ипотекийн зээл аваад 30 хувиа бүрдүүлээд 50 жил орчим бас зээл төлөөд Ингээд үндсэндээ амьдралын зорилго нь бас зээл төлөх юм шиг амьдардаг ийм үе бас ийм өөр болж байна. Түрээсний орон сууц, төрийн албан хаагчдыг дэмжих орон сууцын хөтөлбөрүүд яг бодит байдал дээрээ үндсэндээ бас зайлшгүй хэрэгцээтэй байна. Тэгээд сум болгон жил болгон 10-аас доошгүй түрээсний орон сууцыг нэмэгдүүлээд явах бодлогыг бас Засгийн газар, Монголбанк бас тодорхой хэмжээнд бас цаашдаа хэрэгжүүлээд яваач гэдэг саналыг бас Байнгын хороогоор гаргаж өгсөн байгаа. Энийг бас та цаашдаа анхаараасай гэж бодож байна.

Хөдөө аж ахуйн салбартай холбогдолтой тодорхой 3 асуултыг би бас асууя. Эдийн засгийг солонгоруулах манай Монгол Улсын бас хувьд давуу тал болж байгаа энэ салбаруудаа хөгжүүлэх чиглэл дээр өнгөрсөн хугацаанд 2 тодорхой бас асуудлыг хийсэн нь хөдөө аж ахуйн салбарт олгож буй хөнгөлөлттэй зээлийн энэ боломж байгаа юм. Төсвөөс 10 орчим тэрбум төгрөг гаргаад банкны эх үүсвэрийг ашиглаж бид нар түүнийгээ багадаа 10 дахин нэмэгдүүлж, 100 орчим тэрбум болгож өсгөж байгаа ийм олон улсын бусад улсууд хэрэгждэг ийм бас туршлага. Тэгэхээр энэ хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх үүн дээр барих бодлогын асуудлыг бас би цаашдаа ямар байх вэ гэдэг асуулт байгаа юм.

Мөн энэ хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа энэ бодлого үйл ажиллагаа аль нэгэн улс төрчдөөс хамаарч мөн улс төрийн тодорхой энэ

сонирхлоор дэмжинэ, дэмжихгүй, болино, болихгүй гэдэг энэ тогтвортой биш ийм байдалтай бас үргэлжлээд байгаа юм. Тэгэхээр цаашдаа энэ салбарыг хөгжүүлэх тодорхой санхүүгийн эх үүсвэрийг бий болгох чиглэл дээр төрөлжсөн банкнуудыг бий болгож явж байгаа олон улсын туршлагууд байна. Энэ хөнгөлөлттэй зээлүүдийг үндсэндээ үргэлжлүүлэх чиглэлийн бас энэ туршлагуудыг бас хэрхэн хэрэгжүүлж болох вэ гэдэг ийм бас асуултуудыг асууя.

Н.Учрал: Нийслэлийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн гадаад хэлний багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш нартаа ажлын амжилт, сайн сайхныг хүсье.

Ганхүлэг гишүүн нэмэлт 1 минут.

М.Ганхүлэг: Тэгэхээр хоёрт нь энэ хөдөө аж ахуйн ер нь төрөлжсөн банкнууд дээр ямар байр суурьтай байх вэ? Ялангуяа хөдөө аж ахуй дагнасан ийм бас банкт байх нь зөв үү энэ чиглэлээр бас цаашдаа яавал зөв бэ гэдэг энэ саналыг сонсьё. Малчид нэлээдгүй энэ зуд, ган гачиг гээд энэ байгалийн эрс тэс асуудал, нөхцөл байдалтай тулгардаг 20 орчим хувийн хүүтэй хэрэглээний зээл авч асуудлаа шийдээд явж байгаа. Ингээд арилжааны банкны хүү үндсэндээ яаж үүсэж байна гэхээр 2-3 хувь нь нэг эрсдэлийн хүү гэж ингэж орж ирээд байх шиг байгаа юм. Малчдаас өөрсдөөс нь хамаараагүй байгалийн онцгой ийм нөхцөл байдал үүссэн. Энэ тусгай нөхцөлийг харгалзаж энэ зээлийн хүүгийн энэ эрсдэлийн асуудлыг 2-3 хувиар бууруулах ийм байдлаар бас арга хэмжээг аль аль талаас нь хамтран авах боломжууд бас байж болох уу гэдэг ийм 3 асуултыг асууя.

Н.Учрал: Нэр дэвшигч Наранцогт.

С.Наранцогт: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя 3 чиглэлээр. Ипотекийн хувьд би бас хүмүүс гишүүдийнхээ асуултад хариулсан нэлээд анхаарал тавьж ажиллана. Сонсголын үеэр би 2 чиглэлд Төв банк Засгийн газартай ажиллах ёстой гэж ингэж үзэж байгаа.

1 дүгээрт энэ ипотекийг 2013 оноос хойш мөнгө хэвлэх журмаар хэрэгжүүлээд ирсэн. Дээр нь энэ өөрөө манай улсын бас нэлээдгүй тулгуур асуудал. Одоо ч гэсэн энэ үйл ажиллагаанд оролцоод, хөтөлбөрт оролцоод явж байгаа учраас энийгээ харин зөв болгоё оо, нарийн фокустай болгоё оо, энэ нэмэлт зах зээлийг хөгжүүлэхэд Төв банк бас дэмжлэг үзүүлж ажиллая гэдэг ийм чиглэлтэй.

Нөгөө чиглэл бол дунд хугацаанд энэ экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэл дээр стратегийн түнш бодлогын зохицуулалтынхаа хүрээнд бас энэ боломжийг нэмэгдүүлэх эх үүсвэр, урт хугацаатай хөнгөн хөнгөлөлттэй эх үүсвэрүүдийг бүрдүүлэх тэр боломж, дэд бүтэц дээр дэмжлэг үзүүлэх журмаар ингээд хамтарч ажиллах ийм нь зүйтэй гэсэн ийм л 2 чиглэл байгаа юм. Тэгээд та энэ асуудлыг хоёуланг нь ингээд хөндлөө. Хөдөө аж ахуй бол мэдээж манай нэг экспортыг дэмжих салбар мөн.

Тэгэхдээ бид ингээд их өргөн хүрээнд яг өмнөх бид нарын алдаа, туршлага юу байна вэ гэхлээр асуудлыг их өргөн хүрээнд явдаг. Экспортыг дэмжинэ гээд. Тэгээд эхний ээлжид бид нар яг ямар үйлдвэрлэлийг салбарын тэр мэргэжлийн

холбоодтойгоо, компаниудтайгаа, тэгээд банкнуудтайгаа их нарийн тодорхойлохгүй ингээд ерөнхий эх эх үүсвэр тавиад л ингээд л тэн дээр янз бүрийн байдлаар зарим нь ч бас үр дүнгээ өгдөг нэлээд нь үр дүнгүй болдог. Энэ ЖДҮ-гийн сан гээд баахан юм болсон тэгээд хөдөө аж ахуйн тал дээр.

Тэгэхээр энэ дээрээ ингээд Засгийн газар өөрөө бас их нарийн фокуст гаргаж ингэж ажиллах хэрэгтэй. Тэр сүүдрийн банк, тусгайлсан банкнуудыг бас амжилттай хэрэгжүүлсэн туршлагууд олон улсад байдаг бас болохгүй юм байхгүй. Гэхдээ хамгийн гол нь энэ үйл ажиллагаа л зөв хийж, зөв менежмент, зөв засаглалтай хийж явахгүй бол хөрөнгө оруулагч нь эсвэл засаглалаа авч явахгүй бол энэ өөрөө ингээд манай дээр хэд хэдэн муу туршлага байгаа.

Тийм учраас энэ энийг нухацтай биш маш нарийн төлөвлөгөөтэй л хэрэгжүүлэхээс биш ерөнхий агуулгаар нь хэрэгжүүлэхэд их хүндрэлтэй юм байна лээ. Зээлийн хүүг тухайлан малчдын зээлийн хүүг ярьсан. Ер нь зээлийн хүү дээр нарийвчилсан анализ хийж, тодорхой хэмжээгээр дүгнэлт хийх шаардлага байгаа юу? Байгаа. Гэхдээ хяна захиргааны аргаар хүүг тогтоох ямар ч бололцоогүй. Харин өөр зах зээлийн бөгөөд олон улсын сайн туршлага дээр суурилсан нарийн судалгаа, шинжилгээ, зардлын задаргаа энэ зүйлүүдээ бид нар авч үзэж байж энэ зах зээлийн журмаараа цаашаа явах тэр бололцоо дээрээ л ажиллах ёстой.

Ялангуяа таны хэлж байгаа тэр эрсдэлийн хувьд зүйл мөн. Энэ дээр эрх зүйн шинэчлэлт хийх хэрэгтэй. Бид энэ зээлтэй холбоотой шүүхийн асуудлыг ер нь тусгайлан энэ цахимжсан их хурдтай жилийн дотор шийддэг ийм болгохгүй л бол ингээд 4, 5 жил шүүхийн маргаанаар явдаг энэ нь буруу ашиглагддаг хууль шүүхийн байгууллага дээр бас асуудал гардаг ийм. Энэнээс болоод эрсдэлийн зардал буурч өгөхгүй байгаа юм.

Н.Учрал: Ганхүлэг гишүүн тодруулна.

М.Ганхүлэг: Хөдөө аж ахуйн салбар өөрөө өргөн цар хүрээтэй учраас асуудлыг бас өргөн харахаас өөр аргагүй бас байгаа юм. Тэгээд энэ хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа 4 хөтөлбөрийг энэ нь илүү, энэ нь дутуу, энэ нь зөв, энэ нь буруу гэж бас дүгнэх гээд байх шиг байгаа юм. Шинэ хоршоо нь болохоор буруу үйлдвэрлэлийг дэмжиж байгаа нь зөв энэ тэр гээд. Энэ чинь өөрөө өртгийн сүлжээнийхээ хувьд нэг нь үйлдвэрлэлийн анхан шатны бүтээгдэхүүнийг бий болгох. Нөгөөдөх нь болохоор экспортын чиг баримжаатай ажлын байр, бусад үйлдвэрлэлийг дэмжих гэдэг энэ агуулгаараа хөгжиж байж энэ өөрөө сууриараа зөв явах гээд байгаа юм л даа. Тэгээд ингээд зарим нь хөтөлбөр нь дуусаад, зарим нь шинээр эхлээд ингээд явж байгаа асуудлыг цаашдаа тогтвортой байлгах гарц нь энэ салбарыг ойлгодог, дэмждэг төрөлжсөн ийм банктэй холбогдолтой асуудал байх юм гэсэн энэ өнцгөөс нь би бас хэлж ярьж байгаа юм. Та бас анхаараарай.

Түрээсийн орон сууц гэдэг зөвхөн ипотекеэр бид нар хэмжээд яваад байна л даа. Түрээсийн орон сууц буюу заавал урьдчилгаагүйгээр түр хугацаанд тэр тухайн сум, орон нутагт очиж ажиллаж амьдраад ингээд явах хувийн хэвшилтэй хамтарсан ийм хөтөлбөрүүдийг шинээр бий болгож.../минут дуусав./

Н.Учрал: Нэр дэвшигч анхаарч ажиллах хэрэгтэй. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Хэд хэдэн зүйлийг онцолж хэлмээр байна. Хурлын тэмдэглэлд тусгуулмаар байна. Эхний ээлжид энэ томилгоотой холбоотой асуудлууд яригдаж байна. Их Хурлын дарга маань индэр дээрээс албан ёсоор хэллээ. Өмнөх Монголбанкны Ерөнхийлөгч маш тааруухан ажилласан. Төсөв, орон тоогоо тэлсэн, хэдэн яамтай тэнцэхүйц хэмжээний болгож өргөтгөсөн гээд нэлээн ийм ноцтой факт, баримтуудыг ярьж байна. Тийм учраас дараа энэ танхимд томилгоо хийх болбол тэр чөлөөлөгдөж байгаа хүнийг тайлан тавиулмаар байна. Тэгэхгүй нийгэмд ямар мэдээлэл өгч байна гэхээр жишээгээр Шадар сайдын албан тушаалаар шагнагдсан хүн Төсвийн байнгын хорооны дарга хийж байхдаа Дэгийн хууль зөрчсөн. Хууль зөрчөөд шагнагдаад сайдаар шагнагдаад байдаг энэ нөхцөл байдлыг ард түмэн эсэргүүцэж байгаа.

Тийм учраас дараа дараагийн томилгоо, энгийн жишээгээр хэлэх юм бол бизнесийн байгууллагууд энгийн мэргэжилтэн авахдаа хүртэл өмнөх байгууллагын reference буюу дүгнэлтийг авч үздэг. Монголын төр болохоор зэрэг юу хийсэн нь мэдэгдэхгүй, ямар үр дүнд хүрсэн нь мэдэгдэхгүй улсуудыг тийм ингээд л чөлөөлөөд л явчихдаг. Энэ өнгөрсөн 6 жил ямар ухралт хийсэн юм, алтны нийлүүлэлт яаж өссөн юм, долларын ханш хэчнээн хэмжээний зээл 6 жилд гарсан юм, долларын тэр хүүгийн хэмжээ нь аж ахуйн нэгжүүдэд ямар дарамт учруулсан юм энэ талаар Наранцогт дарга би судлаач хүн гэж харж байна. Бас энэ дээр мэдээллээ хэлмээр байна.

2 дугаарт хамгийн түрүүнд тодорхой хариулмаар байна. Өнөөдөр Монгол Улсад эрэлт, нийлүүлэлтээр зохицуулагддаг зах зээлийн орчин байна уу та юу гэж бодож байна? Эсвэл төрийн оролцоотой зах зээлийн нийгэм байна уу? Өнөөдөр яг ямар зах зээл байгаа юм бэ? Өнөөдөр нөхцөл байдлаа хар хэрэглэгчдэд ямар ч ээлгүй. Банкин дээр очно зөвхөн нэг талыг барьсан стандарт гэрээгээр зээлийн гэрээ тулгадаг. Банк болгон бараг шахуу өөрийн даатгалын компанитай. Сонголт өгдөггүй. Энэ хүний эрхийг зөрчиж байгаа, хэрэглэгчийн эрхийг зөрчиж байгаа маш олон асуудлууд ил байгаад байхад өнөөдөр хэн ч дуугардаггүй. Дээрээс нь өнөөдөр гадаа бензиндээ очерлож байна. Өнөөдөр бензин олдохгүй байна. Гэтэл Монголбанкны асуудлыг хөндөөд тэр репо зээл ямар явцтай яваа юм? 1 их наяд төгрөгийн репо зээл гаргаж байгаа юм. Та тэр тал дээр байр сууриа илэрхийлээд бодлогоо ямар ажлаар эхлэх юм бэ гэдгийг хариулмаар байна.

Дараагийнх нь зүйл энэ минут дуусах гэж байна. Тодруулъя хариулт авч байгаад.

Н.Учрал: Пүрэвдаваа гишүүн амьдрал ярьж байна. Тодорхой асуудлыг хөндөж байна. Наранцогт дарга хариулъя. Энэ эдийн засагч хүн бас бодитой асуудлыг ярьж байна шүү. Нэр дэвшигч хариулна.

С.Наранцогт: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хугацааны энэ тэлэлт үнэхээр өнөөдрийн хөөсрөл, энэ үнэт мөнгөний үнэ цэний уналт гээд энэ өнөөдрийн хямралын ирмэг дээр авчирсан нөхцөл байдал үүсгэсэнтэй тэрэнтэй би санал нэг байна. Ер нь бид нар нээлттэй эдийн засаг, зах зээлийн ийм эдийн засгийг сонгосон. Чөлөөт эдийн засагтай улс төрийн

зохицуулалт байгаа. Бид аль болох салбаруудаа либералчлах чиглэл рүү явах ёстой. Тэгэхгүй болохоор ингээд төр бас оролцох юмандаа оролцоод, оролцохгүй юмандаа оролцоод ингээд байхаар ийм гажиг, гажуудлууд үүсээд байгаа юм.

Тэгэхээр бид нар ер нь мэдээж огцомдуулж зах зээл дээр огцом ийм хямралыг үүсгэж болохгүй, огцом савлагааг үүсгэж болохгүй. Гэхдээ аажим аажмаар энэ нефтийнхээ асуудлыг ч гэсэн бид нар яг бодитой бодит юм руу нь л явуулах ёстой байсан. Гэтэл ингээд олон жил төв банкнаас санхүүжилт хийгээд ийм байдалд явж байгаа нь бас би миний хувьд бас буруу. Энийг үе шаттай бид нар бас зах зээлийнх нь зарчим руу явуулах ёстой. Банкнууд дээр ч гэсэн энэ харьцангуй манайх бас энэ төлбөр тооцооны систем, хүртээмж юмаараа нэлээдгүй сайжирсан. Гэлээ гэхдээ энэ бид нар энэ системийн банкнуудынхаа засаглалыг сайжруулах, таны хэлсэн сая энэ олигопол маягийн байдал үүсэж байгаа бол энэ дээр Төв банк хяналтаа тавьж энийг бас либералчлах ийм зүйлүүдийг хийгээд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ёстой.

Энэ зээлийн хүүтэй холбоотой дээр ч гэсэн бид нар нэлээн нухацтай дүгнэлт, би хувийн дүгнэлтээ хийж байгаа. Гэхдээ энийг би яг томилогдоод очвол энэ банкныхантай нэлээн нухацтай ярих ийм шаардлага байна. Эрэлт өөрөө бас их байгаа юм. Эрэлт нь ч байгаа, нийлүүлэлт нь ч нэмэгдэж байгаа. Тэгээд энэ зах зээлийн тодорхой нөхцөл байдлуудаас болоод зайлшгүй өнөөдрийн ийм өндөр инфляцтай байгаа үед зээлийн хүүг энэ инфляцын түвшнээс зэрэгцүүлээд юм уу доошлуулах ийм боломж байхгүй. Энэ бодлогын хүүгээр энэ асуудал зохицуулагдаж байгаа гэдэг зүйлийг танд хэлье. Мэдээж бид энэ бүх зүйлээ зөв чиглэлд салбаруудаа зөв либералчлах чиглэлүүд явж байж бид нар, манай эдийн засаг, манай энэ зах зээл бол яг бодит хөрсөн дээрээ бууж, яг бодит зах зээлийнхээ зарчимд шилжинэ. Энэний дараа бүх зүйл төрийн оролцоо аль болох багасаж ингээд зүйл ном ёсоороо явах юм гэдэг зүйлийг хэлье.

Н.Учрал: Пүрэвдаваа гишүүн тодруулна.

Д.Пүрэвдаваа: Наранцогт даргад маш тодорхой хариултыг та нэг цаасаар өгөөрэй гэж хүсмээр байна. Ялангуяа тэр репо зээлтэй холбоотой ямар том том аж ахуйн нэгжүүд ер нь эдгээрт хамрагдах гээд байгаа юм, бодлого нь юу юм, цаг хугацааны төлөвлөгөө юу юм гэдгийг. Та миний өнөөдрийн төлөвлөгөөгөөр та өнөөдөр ингээд Их Хурлаас дэмжлэг аваад албан тушаалаа авах байх гэж бодож байна. Тийм учраас албан тоотоор тэр репогийн асуудал ,нийт долларын энэ зөрүүнд аж ахуйн нэгжүүд хэрхэн хохирч байгаа юм, иргэд хэрхэн хохирч байгаа талаар мэдээлэл авмаар байна.

Мөн дараагийн асуудал нь юу вэ гэхээр энэ том том компаниуд бүгд банктай байдаг. Бүх компаниуд өнөөдөр энэ нөгөө л хэдэн том компаниуд өөрсдөө банк ажиллуулдаг, ресторан ажиллуулдаг, бүүр захын дэлгүүр ажиллуулдаг энэ компаниудтай яаж жижиг дундынхан өрсөлдөх вэ? Тийм учраас та эх оронч зан юу гэдэг юм чиглэл гаргаж энэ бүхнийг цэгцлэх ёстой шүү гэж хэлмээр байна.

Н.Учрал: Санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны урилгаар Төв аймгийн Зуунмод сумын ЕБС-ийн 11-ийн ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат асуулт асууна.

С.Эрдэнэбат: Наранцогт нэр дэвшигчийг бас төрийн албанд олон жил ажилласан олон салбарт ажилласан ард иргэдийн болон төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбооны туршлагаар бол олон жил ажилласныг мэднэ. Дэмжиж байна. Хэд хэдэн зүйл дээр анхаарч ажиллаач гэдэг зүйлийг бас би тодруулж хэлмээр байна.

Би энэ өнгөрсөн оны эхэн үеэс л авхуулаад Засгийн газар маань зүв зүгээр зээл, хууль нь ингээд л явж байсан зүйл дээр нэг яамны сайд нь бичиг өгөөд Монголбанкны ахмадын зээлийг үндсэндээ бараг 600 мянган төгрөгийн тэтгэврийн зээл, тэтгэвэр авч байгаа хүний 200 мянгад нь л бараг зээл олго гэдэг нэг ийм бичиг очсон юм шиг байгаа юм. Тэгээд л энэнээс авхуулаад жилжингээ үргэлжилсэн энэ нэг тэтгэврийн зээлийн асуудал. Тэгэхээр энэ тал дээр манай зүйл маань одоо ч гэсэн бас хүмүүсийн асуудал байна. Сая одоо, сүүлд Их Хурлаас бас Өргөдлийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Их Хурлын дарга гээд олон Ерөнхий сайд энэ тэр гээд л янз бүрийн хүмүүсийн түвшинд яригдаж байж энэ нэг тэтгэврийн зээлийн асуудал 36 хүртэлх сараар сунгаж байх ийм шийдвэр гарсан. Бас хэсэг бүлэг бас ахмадууд бас дахиад санал тавиад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр ахмад гэж үзэж болохгүй бас хүмүүс байна л даа. 45-тай, 50-тайдаа тэтгэвэрт гарчихсан хүмүүс 6, 700 мянган төгрөг амьдарч чадахгүй учраас зээл аваад ажлын байр бий болгоод өөрөө өөртөө гэр бүлээрээ жижиг өрхийн ЖДҮ-лэлийн ийм бизнес хийгээд байгаа юм.

Тэгээд манай зээлийн юуг харахаар ахмадуудад ерөнхийдөө моргейжийн зээл олддоггүй, бизнесийн зээл олддоггүй, хөнгөлөлттэй зээл олддоггүй учраас ганц байгаа нь найдвар нь тэтгэврийн зээл байгаа юм. Тийм учраас энэ арилжааны банкнуудад сая сүүлийн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр заавал байлгах нөөцийн хэмжээг бас тодорхой хэмжээгээр чөлөөлж, мөн эрсдэлийг нь жигнэсэн зээлийн тэтгэврийн зээлийг буулгаж тэр боломж олгосон байна лээ. Тэгэхээр үнэхээр тэр бизнес хийх гээд байгаа хүмүүс нь ядаж тэр 36 биш юм гэхэд 24, 25, 6 гээд хүн болгон өөр байгаа байх. Арилжааны банкнууд нь хоорондоо ярьчихсан юм шиг ерөөсөө 24-өөс дээш олгохгүй гэдэг ийм байдал байгаад. Тэгээд энэ чинь олигпал зах зээл болчихоод байгаа юм биш биз дээ гэдэг тал дээр та бас нэг энэ санал, бодлоо бас нэг хэлээч.

Хоёрдугаарх нь би энэ мөнгөний эх үүсвэр их үнэтэй байна гэж банкнууд яриад байгаа юм. Манай улсад нийтдээ 3 мянга, 3 сая 675 мянган данс байна хадгаламжийн. 27 их наяд төгрөг байна. Энэний 500 сая төгрөгөөс дээш хэмжээтэй хадгаламж эзэмшигч нар 5 мянган хүн л байна. Нийт хадгаламжийн 50 хувийг бараг эзэлж байна. Тэгэхээр энэ юуг харуулж байна вэ гэхээр нэг хэсэг хүмүүст асар их хэмжээний мөнгө байна, энэ нь өөрөө эргээд нөгөө мөнгө хүүлэх буюу өндөр хүүгээр хадгална. Тэрийг нь цааш нь дамжуулж зээлдэх учраас эрс.../минут дуусав./

Н.Учрал: Эрдэнэбат гишүүнд 1 минут өгье.

С.Эрдэнэбат: Тийм учраас энэ мөнгө хүүлэлтийн гэдэг нэг ийм зүйл нь цаанаа эх үүсвэртэйгээ холбоотой. Эх үүсвэр нь өөрөө магадгүй цаанаа одоо энэ чинь орлогын л дэндүү их ялгаа байгааг л харуулаад байгаа юм л даа. Маш цөөхөн хүнд нийт мөнгөний хэсэг бүлэг хүмүүс байна. Дээрээс нь энэ банк бус санхүүгийн ломбард, өдрийн зээл гээд. Сарын үндсэндээ бараг 30, 40, 50 хувийн хүүтэй зээл байна гэдэг чинь энэ яг ний нуугүй хэлэхэд маш хүүгийн дарамтад иргэд байгааг харуулж байгаа юм. Тийм учраас энэ тал дээр бас анхаарах хэрэгтэй байна.

Моргейжийн зээлийг түрүүн бас хэн хэллээ, хүмүүс хэллээ. Өндөр, тансаг гэдэг юм уу тийм байруудад ихэнх нь ингээд олгогдчихсон. Жирийн иргэд олгогдохгүй байгаа энэ. Жирийн багш, эмч ажилчид хүмүүст олдохгүй байна.

Гуравдугаарх нь энэ зээлдэгчийн эрх ашгийг хамгаалахын бүтцийг Монголбанкин дээр бий болгож өгөхгүй болохгүй юм байна гэж би харсан. Банкнуудын эрх ашгийг төлөөлдөг бас юм уу бас янз бүрийн аргаар орчихдог юм шиг байгаа юм. Зээлдэгчдийн эрх ашгийн юман дээр та анхаарч өгөөрэй.

Н.Учрал: Наранцогт нэр дэвшигч хариулна.

С.Наранцогт: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэтгэврийн зээлд ингээд хамаагүй оролцоод, оролцохгүй юманд нэлээн оролцсоноос болоод асуудал үүслээ гээд тэгсэн тэрэнтэй санал нэг байна. Гэхдээ нөгөө ялт ч үгүй энэ бас мөнгөний үнэ цэний уналтаас болоод ядуу орлоготой иргэдийн нөгөө амьжиргаа нэлээн хүнд, гар дээр олгогдох орлого багасчихсан байгаа учраас энэ бас саяын энэ бодлого Төв банкны хувьд бас өөрийнхөө оролцох түвшинд оролцож энэ 36 сар болгосон асуудал нь ахмадуудын гар дээр очих сард очих орлогыг л нэмэгдүүлэх ийм зорилгыг агуулж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Ялгаварлан гадуурхах маягийн тэр нөгөө бусад зээлүүд олдохгүй байна гэдэг асуудал бол бас банкнууд дээр яригдана гэдэг нь нөгөө тавигдаж байгаа шаардлагаараа ялт ч үгүй тийм юм руу орж байгаа болов уу гэж ингэж бодож байна. Гэхдээ таны хэлж байгаа олигопол шинжтэй хэт хэр хэрэглэгчдийг хохироод дог яг зах зээлийн, зах зээлээс хэт давуу байдлыг үүсгэсэн зүйл бол мэдээж энэ төв банкин дээр хяналтынхаа чиг үүргээр анхаарал тавьж, оролцож, хяналт шалгалтын хүрээнд хийгдэх ёстой ажил мөн үү мөн. Гэхдээ нэг зүйлийг би та бүхэнд бас хэлье зээлийн хүү ингээд өндөр байна, хадгаламж эзэмшигчид нь цөөхөн хадгаламж эзэмшигч олон байна, энэнээс болоод байна гэдэг асуудал бас эмзэг асуудал.

Яагаад гэвэл манай банкнуудын эх үүсвэрийн 44 хувь нь хадгаламж эзэмшигчдийн хөрөнгө дээр тогтож байна. Нөгөө талдаа гадаад пассив нь 62 хувиар нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл гаднаас мөнгө татаж авчирч байгаа тэгээд энэний нээлттэй позиц хэр байна, ямар нөхцөлөөр авсан байна гэдгийг ч бид нар бодох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ нь гадаад зах зээлээс ирэх бидэнд бас нэг сорилт гэсэн үг, эрсдэл гэсэн үг.

Тэгэхээр зэрэг нөгөө бид хэд ингээд манай макро нөхцөл өөрөө энэ боломжийг нь олгоогүй үед захиргааны аргаар юм уу хүчээр нөгөө мөнгөө бас байршуулж байгаа хадгаламж эзэмшигч рүүгээ дайрах юм бол эд хөрөнгийн

урсгал нээлттэй ийм жижиг зах зээлд байгаа улс хөрөнгө урсалт, зээл долларжилт руу шилжих энэ инфляц өндөр байгаа үед бид нар хадгаламжийн хүүг үр ашиггүй чиг рүү чинь гэнэт дагалдах бас ийм зах зээлийн нарийн хүндрэлүүд гарах ёстой.

Мэдээж бид нар инфляцын Төв банкны гэдэг гол мандат инфляцыг нам дор түвшинд барих тэгээд энийгээ дагасан энэ эх үүсвэрийн зардал багасах, энэ бусад банкны үйл ажиллагааны бас үр ашгийг сайжруулах дээр ч гэсэн анхаарна. Бас нэг ажигласан зүйл бол өнгөрсөн жилээс хойш банкны ашигт ажиллагаа 16 орчим хувиар буурсан байна. Энэ дээр нь хүн хүний нөөцийн зардал 14.1 хувиар нэмэгдсэн байна лээ. Энэ чинь өөрөөр хэлбэл юу гэсэн үг вэ гэхээр үйл ажиллагааны зардал, бас энэ аж ажиллаж байгаа хүмүүсийн цалин мөнгөнөөс болоод нэмэгдээд бас ашгаа шахаж байна л гэсэн санаа. Тэгээд энэ бүх асуудлыг бид нар цогцоор нь бодож асуудалд хандах нь зүйтэй. Мэдээж энэ хэрэглэгчийн эрх ашиг хамгийн чухал. Энэ ч бас Төв банкны хуулиар хүлээсэн үүрэг. Тэгэхээр энэ дээр таны хэлж байгаа санаануудыг бүгдийг нь ажил хэрэг болгохын төлөө энд тооцоо, судалгаатай ажиллая гэж ингэж бодож байна.

Н.Учрал: Эрдэнэбат гишүүн тодруулна.

С.Эрдэнэбат: Би нөгөө яах вэ саяын тоог бусад улс орнуудтай харьцуулахад манайх хэт их ялгаатай болчихоод байгаа дээр анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл саяын тэр моргейжийн зээлээсээ авхуулаад л мөнгө угаалт их явж байна. Энэ байшин барилга руу асар их бохир мөнгөнүүд орж ирдэг. Энийг нь банк нь өөрөө цаагуураа зээлээр дэмжээд байгаа юм шиг ийм зүйлүүд яваад байгаа учраас энийг бодож хэлсэн шүү. Түүнээс биш мөнгөө банканд хадгалах нь муу зүйл биш гэдгийг хэлмээр байна даа.

Дээрээс нь манай зээлжих чадвар сайжирч байгаа гэж гадаад эх үүсвэрт санхүүгийн үнэлгээ сайжирч байгаа. Дээрээс нь 6 тэрбум долларын үлдэгдэлтэй болсон гэж валютын нөөц. Тэгэхээр энэ нь өөрөө цаанаа эргээд хүү буурах ийм нөхцөл би бодит нөхцөл бас бүрдсэн байгаа юм болов уу гэж харж байгаа. Тийм учраас энэ хүүг буулгах асуудал дээр та бас хамгийнхаа түрүүний ажлуудыг хийгээрэй. Тэр бүтцийн хувьд хяналтын бүтцүүд дээрээ бас анхаарал хандуулаарай гэж хэлмээр байна. Баярлалаа.

Н.Учрал: Санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

Л.Соронзонболд: Наранцогт нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Сонсгол дээр ерөнхийдөө асуух асуултуудаа асуучихсан. Тийм учраас нэг хэдэн үг хэлье гэж бодож байна. 1 дүгээрт эдийн засгийн гадаад, дотоод орчныхоо нөхцөл байдлаа тааруулаад Монголбанкны бие даасан байдал болон төсвийн бодлоготойгоо яаж уялдаж ажиллах вэ гэдэг энэ тэнцвэрээ олох дээр нэлээн сайн анхаарч ажиллаарай гэж захимаар байна. Өнөөдөр Монгол улсын нөхцөл байдал нэлээн хүнд байна. Компаниудын борлуулалт буурсан байна. Компаниуд ч тэр, иргэд ч тэр аль аль нь өрийн дарамтад орсон ийм байдалтай байгаад байгаа.

Тийм учраас та ажлаа аваад нэлээн сайн танилцаж байгаад энэ мөнгөний бодлогын хэт хатуу бодлого цааш нь үргэлжлүүлж явуулах уу ингэвэл эдийн засаг маань агших уу? Эд нар гээд тэр юмнуудаа нэлээн сайн тооцож байгаад

шийдвэрүүдээ гаргах байх гэж найдаж байна. Ард, иргэд бол бас зээлийн хүүг бууруулах тал дээр ч тэр компаниуд ч тэр хүлээлт өндөртэй байгаа. Зээлийн хүүг бууруулъя гээд ярихаар инфляцын асуудал яригдаад байдаг. Тэгээд инфляцыг зөвхөн мөнгөний бодлогоор, зээл, бодлогын хүүгээр удирдана гэж байхгүй. Тийм учраас та хөтөлбөр дээрээ бичсэн тэр Макро тогтвортой бодлогын зөвлөл гээд Эдийн засгийн хөгжлийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам гээд байгууллагуудтайгаа нягт уялдаатай ажиллаж, энэ дээр бас нэлээн үр дүн гаргаарай гэж бас хэлмээр байна.

Хамгийн гол нь эдийн засгийг тэлэхдээ тэгээд аль болох инфляц бага, төгрөгийн ханш бага унасан байдлаар ажиллаж үр дүн гаргаарай гэж л захимаар байна даа. Тэгээд амжилт хүсье.

Н.Учрал: Соронзонболд гишүүн санал хэллээ. Сонгобайн Замира гишүүн асуулт асууна.

С.Замира: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа Наранцогт даргыг дэмжиж байна ерөнхийдөө. Учир нь маш их туршлагатай бэлтгэгдсэн боловсон хүчин байна гэж харж байна даа. Хэд хэдэн асуулт асууя.

1 дүгээрт гадаадад бага хүүтэй хадгалагдсан гэх мөнгийг татаж авч дотооддоо эргэлтэд оруулах боломж байна уу?

2 дугаарт гадаадын банк оруулж ирэх асуудал ойрын хугацаанд шийдэгдэх үү?

3 дугаарт ипотекийн зээлийн санхүүжилт, хүү, эргэн төлөлт, ялангуяа өөрийн хашаа хашаандаа байшин барьж, амар тайван амьдрах тал дээр ипотекийн зээлийг зохицуулах боломж байна уу? Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах тэтгэврийг нэмэх тал дээр ямар бодлоготой байна аа? Монголбанканд 200-гаад албан хаагч байна гэсэн. Одоо харин 3 дахин үржиж, 700-гаад болж үлдсэн байна. Дээрээс нь ихэнх нь ББСБ-даа мөнгө хүүлэгч байна гээд ард түмэн нэлээд шүүмжлээд байгаа. Энийг эмхлэн цэгцлэх үү? Ийм хэдэн асуулт байна. Дараа нь тодруулъя.

Н.Учрал: Нэр дэвшигч Наранцогт.

С.Наранцогт: Замира гишүүний асуултад хариулъя гадаадын эх хямд эх үүсвэр, хадгаламжийн талаар гээд би таныг нөгөө Ирээдүйн өв сангийн асуудлыг ярьж байгаа юм болов уу гэж ингэж ойлголоо. Ирээдүйн өв сан хуулиараа зохицуулагдаж байгаа. Яг хуулийн заалтыг хэрэгжүүлээд ажиллаж байгаа гэж ингэж ойлгож байна. Ер нь Баялгийн сангийн асуудал, Ирээдүй өв сан бол Баялгийн сангийн нэг тусгай сан. Энэ асуудал бас нэлээд Их Хурлын түвшинд яригдаж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Тэр үеэр тодорхой бодлоготой энэ дээр бас концепцтой Төв банкны байр суурийг оруулж ирэх нь зүйтэй гэж ингэж бодож байна.

Гадаад банкиг би бас ярьж байгаа. Гадаад банкиг оруулж ирэх сайн талууд байна. Ялангуяа гуравдагч орны ашгийн төлөө хувийн банкиг Монгол

Улсад бид нарт хэмжиж оруулж ирэх ёстой. Ингэж байж бид нар өрсөлдөөн, эх үүсвэр, олон сайн хөрөнгө оруулалтын сайн зүйлүүд бий болох учиртай гэж ингэж үзэж байгаа. Өөр зорилго, стратегийн болоод төрийн өмчийн асуудал бол тусдаа гэсэн ийм бодолтой. Ипотекийн зээлийг манай гишүүд их олон ярилаа. Энэ дээр яг л би түрүүн хариулсан шигээ 2 ч зүйлээр явах ёстой.

1 дүгээрт энэ зорилтод энэ дүрэм, журмыг өөрчилж зайлшгүй оруулах ёстой юм байна гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас бид нар зөв концепц дээр энэ зорилтот бүлэгтээ энэ зардал гаргаж хэрэгжүүлж байгаа бусдын бас энэ мөнгө, төв банкнаас мөнгө хэвлэж хэрэгжүүлсэн энэ хөтөлбөрөө яг л зорилтот зах зээл рүүгээ шилжүүлэх ёстой. Харин орлоготой, боломжтой иргэддээ бас боломжийг нь олгосон тэр орон сууцны олон улсын туршлагын дагуу зах зээлийг нь бий болгох нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна.

Тэтгэврийн зээлийн хүү ер нь яг үндсэндээ Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа Тэтгэврийн сангийн хуулиараа явж байгаа ажил. Банкны зүгээс яг явуулж байгаа үйл ажиллагааныхаа хүрээнд, зохицуулалтынхаа хүрээнд их боломж ямархуу боломж байна тэр боломжоо л ашиглаж оролцож оролцсон. Тэрийгээ л баримтлах нь зүйтэй. Тэрнээс төв банкнаас тэтгэврийг нэмэх ч юм уу нэмэгдүүлэх, энэ зөрүүг шийдвэрлэх ийм боломж байхгүй гэдэг зүйлийг танд хэлье.

Тийм бүтэц, зохион байгуулалтын хувьд бас энэ Улсын Их Хурлын даргаас болоод энэ гишүүдийн өгч байгаа зөвлөмж, энэ санал, хэрэгжүүлэх шаардлагатай зүйлүүдийг би нухацтай авч үзнэ. Чиг үүргийн давхардал, хэрэгцээгүй давхардсан бүтэц, ингээд ажил үүргийн тэгш бус хуваарилалт, үр ашиггүй үйл ажиллагаа байх ёсгүй. Энэ дээр бүгдээрээ үр дүнтэй, үр ашигтай давхардсан бүтэцгүй ийм бүтээмж өндөртэй ажиллах ёстой. Хэрэв 3 дахин хүн нэмэгдсэн бол ажлын бүтээмж 3 дахин нэмэгдэх ёстой.

Н.Учрал: Замира гишүүн бас тэр тэтгэврийн зээлийн асуудлыг хөндөөд байна шүү. Тийм. Замира гишүүн.

С.Замира: Баярлалаа. Одоо Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкууд ард түмнийг маш их шулж байна. Өндөр хүүтэй дээрээс нь татаас авна, дээрээс нь хахууль авна дуртай хүнд зээлээ өгнө, дургүй хүнд юу ч өгөхгүй тийм байдалтай. Ер нь санхүүгийн байгууллага нь нэлээд замбараагаа алдсан байдалтай байгаа. Ийм үед Монголбанкны Ерөнхийлөгч нь солигдож ийм туршлагатай хүн ирж байгаад маш их баяртай байна. Тийм учраас энэ бүгдийг нь эмхлэн цэгцлэх байх гэж танд найдаж байна. Танд ажлын амжилт хүсье. Баярлалаа.

Н.Учрал: Замира гишүүн санал хэллээ. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Наранцогт даргыг дэмжиж байгаа. Би бас энэ тухай танд сонсгол дээр хэлсэн. Урьд өмнө нь ажиллаж байсан туршлага, тэр тусмаа Сангийн яамны Төрийн нарийнаар ажиллаж байхдаа нэлээн чамбай хуулийнхаа дагуу ажиллаж байсан дээр бас үнэлгээ өгдөг юм шүү. Тийм болохоор энэ Монголбанкны Ерөнхийлөгчөөр ажиллах боломж, бололцоотой гэж өөрийг чинь харж байгаа.

Би танд хэлсэн зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох буюу зээлийн хүүг бууруулах хууль санаачилна . Энэ хуулийг дэмжээрэй гэж танд хэлсэн. Та дэмжинэ гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл мөнгө хүүлэлттэй холбоотой асуудал Монгол Улсад гарлаа. Одоо энэ сүүлийн аппликэйшний зээл ч гэж нөгөө ямар ямар зээл билээ өдрийн зээл ч гэл үү эд нар чинь хэдэн хувь болчихоод байгаа юм бэ? Бараг л ч 30-аад хувь руу орчихоод байгаа юм уу? Ийм хэмжээний энэ мөнгө хүүлээд л ийм хэмжээний ард иргэдийгээ мөлжсөн мөлжлөг, мөнгө хүүлэлт чинь мөлжлөг шүү дээ. Энэ чинь бүр Дундад зуунаас эхлэлтэй ийм асуудал гээд байгаа шүү дээ. 1500-гаад онд Англид бүр тодорхой арга хэмжээ авч байсан юм байна лээ.

Тэгээд энийгээ бодоход ер нь 76 улсын судалгаагаар Дэлхийн банкны судалгаагаар 76 улсад энэ мөнгөний асуудлыг, хүүгийн асуудлыг, хүүний зээлийн хүүгийн тогтворжуулах, зээлийн хүүг барих, зээлийн хүүг өсгөхгүй байх, дээд хязгаарыг тогтоох, таазыг тогтоох ийм хуулиуд байгаад байгаа юм байна.

Тийм болохоор ийм хууль зээлийн хүүний дээд хязгаарыг тогтоох хууль санаачилнаб Энэ дээр дэмжиж ажиллаарай гэдгийг танд хэлье. Энэ маань наад зах нь эдийн засгийн хувьд мөнгө хүүлэлт биш, хүүлэх мөнгө эдийн засаг руугаа ордог, эдийн засагт эргэлт ордог. Эргэлт болж очдог. Аж ахуйн нэгжүүдэд очдог, аж ахуйн нэгж хөл дээрээ босдог, цаашдаа ажлын байр бий болгодог, орлого бий болгодог. Бүүр нарийн яривал энэ бидний өнөөдрийн 30 хувьтай байгаа ядуурлын хэмжээг бууруулах гол асуудал. Бидний барьж байгаа том бодлого чинь дундад түвшний иргэдтэй болно, орлого бүхий иргэдтэй болно гээд байгаа шүү дээ энэний чинь ганц гол механизм чинь ЖДҮ-лэл үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын байр бий болгох орлого бий болгох асуудал шүү дээ. Энэний чинь гол механизм нь юу юм гэхээр нөгөө хөрөнгө оруулалтыг бий болгох банкны зээлийг зохих түвшний хүүтэй банкны зээлийг ард иргэддээ хүргэх. Тэгээд бизнесийн зээл гэж байж байна. Тэр ахмадууд дээр очиж байгаа зээлүүдийн хэмжээ байж байна. Энэ бүх зээлүүд чинь хүндээ үр өгөөжтэй байхын тулд зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох ийм хуулийг санаачилна. Энийг таныг дэмжээрэй гэж байна.

Ингээд Монгол Улсын Монголбанкны Ерөнхийлөгчид өөрийг тань дэмжиж байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Н.Учрал: Наранцогт нэр дэвшигч.

С.Наранцогт: Бат-Эрдэнэ гишүүний асуулт, саналтай холбогдуулаад би нэгхэн л зүйлийг хэлье гэж бодож байгаа. Би таны нөгөө зээлийн дээд хязгаар гэдэг яг мөнгө хүүлэлтийн агуулгаар хэт өндөр зээлийн хүү дээр тавигдахад дэмжих бололцоотой гэдэг зүйлийг хэлсэн. Та бас ийм зүйлийг ярьж байгаа тэн дээр би бас танд тодруулж хэлэхийг хүсэж байгаа юм. Эрэлт, нийлүүлэлтийн хууль ерөөсөө үйлчлэхгүй байна 5, 10 жилийн өмнө байсан нь одоо ч хэвээрээ байна гээд. Тэгээд манай нөгөө суурь макро нөхцөл сайжрахгүй болохоор зээлийн эрэлт, нийлүүлэлт нь өндөрсөн нь бас үнэн. Зээлийн нийлүүлэлт нэмэгдсэн нь, эрэлт нь бас нэмэгдээд байгаа.

Өнгөрсөн жилийнхээ зээлийн зээл 24 хувиар өссөн. Тэр дундаа нөгөө хэрэглэгчийн зээл нэмэгдээд, тэтгэврийн зээл 44 хувиар нэмэгдээд, цалингийн зээл нэмэгдээд энэнтэй холбоотой ялангуяа бас таны хэлж байгаа үйлдвэрлэлийг

дэмжих зээл маш чухал нь харагдаж байгаа юм. Юу вэ гэхээр иргэдийн найдваргүй зээлийн хэмжээ 153 хувиар өссөн өнгөрсөн оноос. Энэ чинь өөрөө юуг харуулж байна вэ гэхээр бас эрсдэл нэмэгдэж байна, эрсдэлийн зардал нэмэгдэж байна гэж харагдаж байгаа юм.

Тэгэхээр хэдүүлээ нөгөө асуудлаа бүх талаас нь хараад бүх учир шалтгааныг нь авч үзэж асуудалд хандах нь зөв байгаа. Бид нар зах зээлийн яг эрэлт, нийлүүлэлтээр явж байгаа зүйл дээр бид нар бас хамаагүй захиргааны аргаар оролцож болохгүй гэдэг зүйлийг би танд хэлэх гэж байгаа. Мэдээж бас сайжруулах орон зайнууд байгаа. Тэр дээр цөмөөрөө ажиллая. Танд би тодорхой яг судалгаатай мэдээллүүдийг хүргэх замаар энэ дээр нэлээн бас холбогдож ажиллая гэж ингэж бодож байна.

Н.Учрал: Бат-Эрдэнэ гишүүн тодруулна.

Ж.Бат-Эрдэнэ: Эдийн засагч та нараас бид нар зөндөө сонслоо шүү дээ. Яг зах зээлийн шугамаар явах ёстой, эдийн засгийн онолоороо явах ёстой эд нар гэсэн юмнуудыг зөндөө л судалж байгаа, зөндөө л сонсож байгаа, зөндөө л хүлээж байгаа. Тэгээд бусад орнууд чинь, зарим улсуудад энийг чинь тогтоогоод болоод байх шиг байна шүү дээ. Тэгээд эд нарыгаа хэдүүлээ судалъя. Заавал өнөөдөр хүчиндээд ингээд яриад байх нь юу байх вэ.

Гэхдээ нэг зүйлийг л бодох хэрэгтэй байна шүү дээ. Энэ зах зээлийг чинь зохион байгуулж зохицуулах хэрэгтэй шүү дээ төрөөс. Тэнд нь хүмүүс хүүлээд ард иргэдийг тэр үнэтэй зээлээр нь өөрөөр хэлбэл эдийн засгийн боломж, бололцоогүй байгаа нөхцөл байдлыг нь харгалзаад том өндөр хүүтэй зээл өгөөд, амьдралд нь хор болгоод, зээл, хүүд нь баригдуулаад тэгээд л хэчнээн өнөөдөр зөндөө л ярьж байна шүү дээ энэ чинь өчнөөн олон компани үүд хаалгаа барилаа, үүд хаалгаа хаалаа, цаашаа бизнес эрхлэх боломжгүй боллоо гээд. Энийгээ л харъя л даа. Энэ өнцгөөс нь харъя. Зах зээлийг тэр зохицуулалттай нь хэдүүлээ тохируулах гээд үзье

Н.Учрал: Санал хэллээ. Наранцогт дарга анхаарах хэрэгтэй. Болдын Жавхлан гишүүн асуулт асууна.

Б.Жавхлан: Наранцогт нэр дэвшигчийг дэмжиж байгаа6 Байнгын хороон дээр үгээ хэлсэн асууж, тодруулах зүйлээ ч асуучихсан. Энэ 3 зүйл захиж хэлэх гэсэн юм. Өөрийг чинь бас нэлээн өндөр хүлээлттэй байгаа шүү. Олон эдийн засгийн төв бодлогын ялангуяа макро бодлого ийм төлөвлөлт дээр ажиллаж байсан байгууллагуудыг удирдаж, бодлогын олон шийдвэрүүд дээр хамтарч ажилласан олон улсын гэрээ хэлэлцээр олон төслүүд дээр бас өөрөө бүрийг нь гардаж удирдаж явсан ийм боловсон хүчин байгаа. Тийм учраас 1 дүгээрт таныг Монголбанкн дээр очиход ер нь сайн үзүүлэлтүүд бас байгаа, гарсан байгаа шүү.

Хамгийн 1 дүгээрт төсвийн бодлого, мөнгөний бодлого хамтарч ажилласны үр дүнд валютын нөөц, Монгол Улсын валютын нөөц түүхэндээ анх удаа 6 тэрбум доллар хүрсэн.

2 дугаарт эхний хагаст 650 сая долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл одоо 150 сая доллар нэмэх болж ингэж сайжирсан байгаа.

3 дугаарт зээлжих зэрэглэл 3 агентлаг дээрээ бид нэгэн дээр нь хэвийн хадгалж үлдсэн, 2 дээр нь бид 12 жилийн өмнө хүрч байсан үзүүлэлтдээ, үнэлгээндээ хүрсэн байгаа. Хэдийгээр 12 жил боловч энэ маш үнэ цэнтэйгээр бид нар энэ үнэлгээ дээр эргэж ирсэн байгаа. Энийг цаашаа хадгалж явах нь маш чухал шүү. Эдгээрийн үр дүнд мөн төгрөгийн ханш тогтворжиж, наадмын үеэр мөнгө 3650 гарчхаад байсан валютын ханш өнөөдөр 3550 гээд ямар ч байсан 100 төгрөгөөр бас чангарсан ийм үзүүлэлтүүд гарсан байгаа. Эдгээрийгээ маш сайн харж цаашаагаа хадгалж явах тал руугаа бодлогоо чиглүүлээрэй.

2 дугаарт, гадна талдаа тодорхойгүй байдлууд үргэлжилж байгаа, биднээс шалтгаалахгүй олон зүйлүүд бидэнд олон сувгаар нөлөөлж байгаа. Ийм үед геополитикийн ээдрээтэй үед олон улсын санхүүгийн төв байгууллагуудтай ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банк гээд мөн олон ийм бүс нутгийн Хөгжлийн банкнууд байгаа санхүүгийн байгууллагууд байгаа. 2 талт мөн томоохон эдийн засаг улсууд байна. Эдгээртэй бодлогоо зөв ойлгуулж, дипломат харилцаагаа их маш сайн барьж ингэж явах нь маш чухал шүү маш үнэ цэнтэй ийм байгаа.

Мөн он гараад АНУ-ын ... -тэй бид бас чухал уулзалтууд хийнэ. Энэ төлбөр, тооцооны асуудлууд гээд тулгамдчихсан асуудлууд байгаа. Энэ рүүгээ, энэ ажил руугаа их яаралтай ороорой гэж захъя. Мөн ингээд өөрөө дэмжигдээд явна гэдэгт итгэж байна. Тэгээд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн болно. Өөр олон техникийн шинжтэй ярилцах асуудлуудаа энэ зөвлөлөө хэвийн биш ийм том сорилтын үед маш давтамж өндөртэйгөөр их идэвхтэй ажиллуулах.../минут дуусав./

Н.Учрал: Нэр дэвшигч. Жавхлан сайд 1 минут өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр тэр зөвлөлөө маш сайн идэвхтэй ажиллуулах дээр Монголбанк өөрөө их том судалгааны институт, маш олон сайн боловсон хүчинтэй. 90 оноос хойш энэ чинь бараг 20-иод Засгийн газар 20-иод Ерөнхий сайд. Гэтэл та бол 90 оноос хойш дөнгөж 8 дахь Ерөнхийлөгчөөр томилогдох гээд ингээд энд хэлэлцэгдэж байна. Тэгэхээр Төв банк бол харьцангуй тогтвортой институт. Энд бэлтгэгдсэн боловсон хүчнүүд таны хамгийн том капитал шүү гэдгийг захиж хэлье. Баярлалаа.

Н.Учрал: Санал хэллээ. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ер нь энэ сүүлийн арилжааны банк байгуулагдаад энэ зах зээлийн системд ороод ингэснээс хойш 8 дахь банкны Ерөнхийлөгч яригдаж байна өнөөдөр. Өмнө байсан Ерөнхийлөгчид ихэнх нь ганц нэг хүнийг эс тооцвол улс төрчид юм уу, эсвэл банк, санхүүгээ яг банкаар явсан аль нэг банкнаас хараат иймэрхүү банкны ерөнхийлөгч нар болдог байсан. Анх удаагаа тэрнээс хамааралгүйгээр ийм хүн ирж байна гэж ойлгож байна. Өөрийг чинь бас мэднэ. Бүх шат дамжлагуудыг дамжаад ингээд явж байгаа. Тэр тусмаа нэг олзуурхууштай юм нь таны суурь боловсрол ийм физикийн хүн байгаа. Энэ чинь маш сайн. Ер нь байгалийн тодорхой шинжлэх ухааны суурьтай хүн яг зөв сайн ажиллаж чаддаг. Тэгэхгүй тэгээд ерөнхий мэдлэгтэй ерөнхий тийм хүмүүс юмыг бас зөвөөр харахдаа жоохон учир дутагдалтай байдаг гэж боддог би, миний хувьд.

Тэгээд хэд хэдэн зүйл байна. Бас сайн юман дотор бас нэг зүйл бий. Та хэн нэгэн банкныхаас, хэн нэгэн банк нөхдүүдээс хамаарахгүй ч гэсэн бас нэлээн тийм олон ажлыг сайн хийсэн. “Орона”-гийн гэрээ болон сүүлийн үед миний мэдэхийн энэ юманд амжилттай оролцож, амжилттай хийсэн. Гэхдээ Засгийн газартай их ойрхон ажиллаж ирсэн та. Өмнөх Ерөнхийлөгч нар Засгийн газрын бас нэг хараат тэд нарын дуулгавартай маягаар ийм ажилладаг байсан. Ийм байж болохгүй. Энийг ерөөсөө давтаж болохгүй. Монголбанк бол бүрэн хараат ийм ажиллах ёстой шүү.

Нөгөө талаар алтны үнэ маш их өсөж байгаа. Миний хувьд 2 мянга, энэ алтаа авч чаддаггүй болчихсон байсан юм. Би 2.5 хувийн татвартай болгоод хэрвээ Монголбанкинд тушаавал гэсэн ийм хуулийг би санаачлаад оруулж ирж байхад бүгдээрээ дэмжихгүй байсан боловч авч гараад батлуулсан. Тэрний дараа буцаагаад 20 хэдэн тонн алт ирдэг болсон. Тэгээд яагаад буцаагаад энэ 5 болчихов? Энийг та юу гэж бодож байна? Ингээд 2.5 буцаагаад болгох хэрэгтэй. Тэгвэл миний тооцоогоор бараг 40, 60 тонн алттай болно Монголбанк. Энэ алтны үнэ өсөж байх үед бүр хэрэгтэй байсан. Ямар нөхдүүд яагаад тэрийг тийм болгосныг би ойлгохгүй байгаа. Тэр байтугай би дотроо Оюу толгой хүртэл алтаа Монголбанкинд өгөх ийм боломжтой. Тогтворжуулалтын.../минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Д.Ганбат: Хөрөнгө оруулалтын тогтворжуулалтын гэрээгээр 5 хувьтай л даа Оюу толгой өөрөө листед компани байхгүй юу. Тэр яг ашгийн үүднээсээ 265 хувийн татвар төлөхийн тулд Монголбанкинд өгөхөөс өшөө аргагүй байсан юм. Энэ санхүү, эдийн засгийн механизмаар ингэж шийдэж байсан байхгүй юу. Гэтэл яагаад тэрийг тийм болгочхов оо? Энэ талаар танд мэдэж байгаа барьж байгаа юм бий юү?

Нөгөө талаар энэ 700 хүнтэй байна Төв банк маань. Боловсон хүчний хувьд маш сайн гэдэг боловч энэ 700 хүн арай л ахадсан, хэтэрсэн тоо юу? Тэнд чадал чадвартай 200 хүн байдаг, бусад 400, 500 хүн нь бас л ямар нэгэн улс төрчдийн, дарга нарын ийм магадлал байна уу ийм байж болохгүй шүү. Энийг өөрчлөх хэрэгтэй гэсэн ийм зүйлийг яримаар байна. Энэтэй та хэр санал нийлж байна?

Н.Учрал: Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Ганбат гишүүний асуултад хариулахад энэ алтны тушаалт бас буурсан байна лээ. Надад яг энэ авсан мэдээллээр 24 онд 11.6, 25 онд 9.6 тонн гээд Монгол Улс дунджаар жилд 20 тонн алт олборлож байгаа гэсэн. Ийм байдаг. Тэгэхээр ялт ч үгүй бид нар ингээд макро суурь нөхцөл маань экспорт маань импортоо гүйцэхгүй урсгал данс маань ийм алдагдалтай ийм нөхцөл байдалд бид нарын хамгийн түрүүн хэрэгжүүлж өөрийнхөө нөөц бололцоог ашиглах зүйл энэ алтныхаа нөөцийг нэмэгдүүлэх, алтаа Монголбанкандаа тушааж авч мөнгөжүүлэх асуудал байгаа юм.

Тэгэхээр тантай энэ дээр 100 хувь санал нэг байна. Буцаад 5 хувь болсон шалтгааныг мэдэхгүй боловч бид нар ерөөсөө энэ алтыг Төв банкинд төвлөрүүлдэг механизмыг татварын болоод бусад энэ хууль хяналтын

байгууллага, далд эдийн засгийн сувгуудыг хаах ийм заваар алтыг Төв банкандаа төвлөрүүлэх нь бидний хувьд стратегийн маш чухал зүйл. Би тантай энэ дээр санал нэг байна.

Нөгөө талаар Монголбанкны хувьд түрүүний хэлсэн манай бас шилдэг боловсон хүчнүүд ажилладаг ийм институц. Яг одоо би дотоод мэдээллийг мэдэхгүй болохоор хэлж мэдэхгүй байна. Олон гишүүд энэ тал дээр санал юм гаргаж байна. Хэтэрхий олон орон тоотой байна. Тэгэхээр яг барих үндсэн бодлого бол яг мэргэжлийн мерит зарчмаар явж байгаа ажлаа хоёргүй сэтгэлээр хийдэг энэ хүмүүсээ дэмжиж ажил төрлийн ачааллыг тэнцүүлж, бүтээмж нэмэгдүүлж ажиллах учиртай. Хэрвээ ажил хийдэггүй, шаардлага хангахгүй ийм хүмүүс байвал тэгээд хариуцлага тооцохоос өөр аргагүй л гэж ингэж бодож байна.

Н.Учрал: Тодруулах уу? Болсон байна. Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Өнөөдөр Монголбанкны Монгол Улсын бас энэ санхүүгийн системд ажиллаж байсан төрийн албаны бас энэ арвин ийм их туршлагатай ийм хүн Наранцогт дарга маань Монголбанкны Ерөнхийлөгчөөр нэр дэвшиж орж ирж байгаад миний хувьд бас дэмжиж байгаагаа бас илэрхийлье.

Ингээд Монголбанкны шинэ ажилд очихтой холбоотойгоор бас хэд хэдэн саналыг би бас хэлэхийг хүсэж байгаа. Энэ санал дотор бас Улсын Их Хуралтай бас хамтарч хийхэд нэлээдгүй бас ажлууд байгаа гэдгийг бас хэлье.

1 дүгээрт нь энэ Монголбанк макро эдийн засгийн, тэр дундаа мөнгөний бодлогыг тодорхойлогч байгууллага. Энэний цаана гол нь инфляцыг зорилтот түвшинд байлгах ёстой ийм үүрэгтэй байгууллага байгаа. Өнөөдрийн эдийн засгийн гол асуудал инфляц дагасан хүндрэлүүд энэ нийгэмд нэлээдгүй байна. Хамгийн гол асуудал байна. Сүүлийн жилүүдийн энэ он дамжсан энэ өндөр инфляц бол иргэдийн цалингийн, тэтгэврийн худалдан авах чадварыг бууруулсан. Энэ нь эргээд амьжиргааны дарамтыг бий болгож байгаа юм. Бизнесийн үйл ажиллагаанд ч гэсэн энэ эргээд сөргөөр нөлөөлж байгаа юм. Ингээд Улсын Их Хурлаас жил болгон инфляцын зорилтот түвшнийг баталдаг. Энэ оных ч тэр, ирэх оных ч тэр 5 хувийн голчтой инфляцын түвшинтэй байна гээд байгаа юм. Энэний цаана юу яриад байгаа юм бэ гэхлээр зэрэг 5 хувийн инфляцтай байж чадах юм бол Монголбанкны бодлогын хүү 6-7 хувьтай байж чадна аа.

Ингэх юм бол арилжааны банкнуудын олгох зээлийн хүү 12 хувь буюу сарын 1 хувийн хүүтэй болж бодлого нь зөв болж явах ёстой. Энийг л ард иргэд, Улсын Их Хурлын гишүүд бид хүсэж байгаа. Энийг бас Монголбанкнаасаа хүлээж байгаа. Ингэж чадах юм бол бид нар бизнес эрхлэлтийг нэмэгдүүлж чадна, ажлын байрыг нэмэгдүүлж чадна, цалингийн хүсээд байгаа өсөлтийг бий болгож чадна. Хамгийн гол нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх ийм боломж нь бүрдэх ёстой. Тэгэхлээр энэ асуудал дээр та бас хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу Монголбанкны хараат бусаар ажиллах зарчмынхаа дагуу Монголбанкны бодлогын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа аливаа шийдвэрт хараат бусаар санал, зөвлөмжөө гаргаж, Улсын Их Хурал, Засгийн газарт ирүүлж ажиллахыг бас танаас хүсэж байгаа юм.

2 дугаарт нь Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ хэрэгжүүлэхээсээ гадна банкны салбарыг зохицуулагч байгууллага байдаг. Өнөөдөр Монгол арилжааны банкнуудтай холбоотой зөндөө асуудлууд яригддаг. Татан төвлөрүүлсэн эх үүсвэрүүдийгээ буцааж өгөхгүй байгаатай холбоотой асуудлаас өгсүүлээд л, банкны эздийн давхар бизнес зарим харилцагчийнхаа бизнесийг булааж авсантай холбоотой асуудлуудаас өгсүүлээд л, гадаадын банк оруулж ирэх асуудлаас өгсүүлээд л зөндөө асуудлуудыг ярьж болно. Арилжааны банкнууд цахимжаад байгаа мөртөө өнөөдөр Монголын гадагшийгаа биш юм гэхэд дотооддоо хийгдэж байгаа гүйлгээнээс авдаг шимтгэл хэвээрээ байгаад байдаг. 2024 оны байдлаар арилжааны банкнуудын ашигт ажиллагаа 1.7 их наядад хүрчихсэн. Тэгсэн мөртөө дотоод гүйлгээнийх нь шимтгэл нь хэвээрээ байгаад байдаг, нэмэгдээд байдаг, цахимжаад байдаг ийм нэг ойлгомжгүй юм яваад байгаа. Банк бол итгэлцэл дээр тулгуурласан бизнес. Харилцагч татах хадгалан.../минут дуусав./

Н.Учрал: Заяабал гишүүнд 1 минут өгье.

Б.Заяабал: Харилцагчийг татах, хадгаламж татах болохоор итгэлцэл дээр тулгуурласан бизнес хийгээд эхэлдэг. Зээл олгох болохоороо энэ нь итгэлцэл биш болоод хувирчихдаг. Эрсдэлтэй төлөв рүү оруулаад эхэлдэг. Тэгэхлээр энэ дээрээс эхлээд банкны үйл ажиллагааны энэ арилжааны банкнуудын дотоод үйл ажиллагаануудыг онцгой анхаарах ийм шаардлага бас байгаа гэж ингэж үзэж байгаа юм. Шинэ төрлийн бүтээгдэхүүнүүдийг бас энэ арилжааны банкнууд зах зээлд гаргамаар байна. 6 хувийн ипотек гээд гаргачихсан. Энэ дээрээ асар их хэмжээний очер, арын хаалга үүсгэчихсэн.

Гэтэл 8 хувьтай, 10 хувьтай, 12 хувьтай, 13 хувьтай ч гэдэг юм уу гэх мэтчилэн ийм шинэ төрлийн бүтээгдэхүүнүүдийг тохирсон үйлчилгээнүүдийг бас гаргах зайлшгүй шаардлага бас байгаа юм. Монгол Улсын зээлжих зэрэглэл өслөө, банкнуудын зээлжих зэрэглэл өслөө, гаднаас хямд эх үүсвэртэй бонд бослоо гээд байдаг. Тэгээд өндөр хүүтэй зээл өгчихсөн зээлийн гэрээнүүдээ эргэж харж Refinancing хийх тал дээрээ яагаад үйл ажиллагаа явуулдаггүй юм бэ гэдэг бас ийм зүйлүүд бас бодогддог юм. Тэгэхлээр энэ бүх зүйлүүд дээр та бас онцгойрч анхаарахыг ажиллахыг хүсье.

Н.Учрал: Санал хэллээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн байхгүй байна. Чинбатын Номин гишүүн байхгүй байна. Банзрагчийн Түвшин гишүүн асууна.

Б.Түвшин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монголбанкны өөрийнх нь ер нь балансын асуудал нэлээн хүндэрсэн харагдаад байгаа. Тэгээд миний харж байгаагаар энэ хөрөнгөнөөсөө нийт өр төлбөр нь давчихсан, нийт өөрийн хөрөнгө нь -4.8 их наяд, хуримтлагдсан алдагдал 7.5 их наяд төгрөгийн алдагдалтай. Тэгэхлээр энийг 1 дүгээрт ер нь ийм хүнд нөхцөл байдлыг та хүлээж авч байна. Энийг ер нь 1 дүгээрт яаж засах вэ? Энэ асуудал чинь өөрөө нөгөө Монголбанкны хуулийн 30.3-д зааснаар аудитын дүгнэлт ч тэр, санхүүгийн тайлан ч тэр олон нийтэд нээлттэй байх ёстой байтал хууль дээрээ нээлттэй гэж байгаа боловч бодит байдал дээрээ энэ нээлттэй бус байгаад байна. Энэ асуудлыг 1 дүгээрт тодруулъя.

2 дугаарт ерөөсөө энэ мөнгөний бодлогын асуудал дээр ашиг сонирхлын асуудал дандаа яригддаг. Та аль нэгэн банканд хувьцаа эзэмшиж байгаа юу, аль нэг банк бустай юу? Энэ талаар бас тодорхой хэлээч.

3 дугаарт аль нэгэн улс төрийн ялангуяа энэ сонгууль дөхөөд ирэхлээр л нэг ийм төсөл, хөтөлбөр хийгээд шууд төв банкнаасаа энэ төсөл, хөтөлбөр рүү ороод ингээд зээл санхүүжилт гаргачихдаг. Энэнээс болж энэ алдагдлууд үүсэж байгаа болов уу гэж бодож байна. Тэгээд ийм хүнд банкиг яг ямар арга хэмжээ хэрэгжүүлж байж хэвийн байдалд нь оруулъя гэж бодож байна вэ? Энэ нөөцийн буюу нийт хөрөнгө нь -10-24-ийн хооронд хэлбэлзэж байгаа нь яг нэг ийм ердийн Төв банкны бүтэц буюу байх хязгаараас давчихсан. Энэ давчихсан байгаа байдал нь өөрөө дараагийн шатын хүндрэл рүү оруулах уу үгүй юү гэдэг дээр та хувьдаа юу гэж дүгнэж байна? Хуримтлагдсан алдагдал нь -26 хувьд хүрчихсэн нийт хөрөнгийнхөө. Тэгээд энэ чинь нөгөө Ай Эм Пи Өү гаргасан тэр удирдаж болох түвшин гээд байгаагаас өндөр түвшинд гараад явчихсан. Тэгэхлээр одоо бид нар гаднын санхүүжилтийн хяналтад орох уу? Ер нь энэ тал дээр энэ нөхцөл байдлыг яаж шийдье гэж бодож байна?

Хамгийн том эрсдэлтэй зүйл бол өрхийн зээлийн орлого давхар зээлтэй иргэдийн хувь буюу өрхийн зээлийн эрсдэл их өндөр харагдаж байна. Энэ талаар бас та энэ 4 том асуултад хариулаад өгөөч.

Н.Учрал: Цайны завсарлагагүй үргэлжлүүлээд хэлэлцэх үү? Тэгье үргэлжлүүлээд хэлэлцье. Асуултад хариулна. Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт.

С.Наранцогт: Түвшин гишүүний асуултад хариулъя. Таны дурдсан асуудлууд бас үнэн бодитой. Монголбанк алдагдал нэлээд нэмэгдсэн. Энэнийх нь 67 хувь Төв банкны үнэт цаасны төлбөрт гарсан байгаа юм. Тэгэхээр энэнээс болж үүдэлтэй. Өөрөөр хэлбэл, өмнөх энэ олон жилийн бодлогын хүрээ хүрээнд мөнгөний зах зээл хөөсрөөд энэ хөөсөө татаж авахын тулд л хэрэглэж байгаа арга. Та энийг өөрөө их сайн мэдэж байгаа. Тэгээд бас үйл ажиллагааны зардлаас хүлээж байгаа алдагдлуудаас болж ингээд алдагдлууд нь бас нэмэгдэж байгаа. Свот хэлэлцээнүүдийг бас хийж байна. Энэнээс болж алдагдал хүлээсэн байна. Ингээд энэ зүйлүүд нийлээд Төв банкны алдагдлыг бүрдүүлж байна. Төв банкны алдагдал мэдээж хэрэг аж ахуйн нэгжүүдийн алдагдлаас арай өөр ойлголт. Энийг та бас сайн мэдэж байгаа.

Тэгэхээр бид яах вэ гэхлээр яг богино хугацаанд инфляц ийм өндөр, зах зээл өөрөө яг ийм нөхцөл байдалд байгаа учраас мөнгөний хатуу бодолтой богино хугацаандаа үргэлжилнэ. Сая Заяабал гишүүний хэлснээр бид нар энэ үндсэн асуудлуудаа шийдэх хүртэл энэ алдагдлыг бууруулах боломж ингээд харагдахгүй байгаа юм. Энэ чинь яагаад гэвэл үргэлжлүүлээд энэ алдагдлаа нэмэгдүүлж төлөгдөөд явна гэсэн үг.

Гэхдээ ер нь богино хугацааны дараа энэ дунд хугацаанд инфляцыг нам доор түвшинд аваачаад тэгээд юм яг энэ явах ёстой зохист явах зүйл рүүгээ орж ирээд тэгээд эндээс энэ алдагдлыг яг зайлшгүй биш байдлаар үүсгэж байгаа алдагдлууд юу байна вэ гэдэг дээр би аж томилогдвол нэлээн нухацтай анализ

хийж би танд бас танилцуулга хийнэ. Ингэж байж бид нар энэ алдагдлыг бууруулах ёстой. Энэ бол зарчмын асуудал. Энэ дээр ингэж яая гэж бодож байна.

Ашиг сонирхлын хувьд надад ямар ч ашиг сонирхол байхгүй. Би аль ч банканд хувьцаа байхгүй, банк санхүүгийн байгууллага байхгүй. Надад ерөөсөө энэ дээр ямар нэгэн асуудал байхгүй. Мөрийн хөтөлбөр дээр тусгаснаараа энэ нөгөө репо санхүүжилт урт хугацааны репо гээд зүйлүүд дээр нэлээн санхүүжилтүүд яваад байгаа. Ер нь энэ хагас төсвийн үйл ажиллагааг би зогсоох ёстой гэсэн хатуу байр суурьтай байгаа. Мэдээж энэ өдөр тутмын үйл ажиллагаа энэ төлбөр тооцоог хангах чиглэлээр репо санхүүжилтүүд банканд өдөр тутам хийгддэг ажлууд бий. Энэ бол ил тод, нээлттэй шударга журмаа л барьж явах ёстой. Тэгэхгүйгээр нөгөө танил давуу байдлыг аль нэг газар олгоод байдаг байж ерөөсөө болохгүй. Энийг мөрийн хөтөлбөртөө ч би бичсэн, яг энэ чиглэлээрээ ажиллана гэж ингэж бодож байна.

Н.Учрал: Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Таны үгнээс нэг чухал үг бас харагдаж л байна л даа. Энэ хагас төсвийн байдалтай гээд байгаа. Ерөөсөө энэ төсвийн байдал нь өөрөө яг энэ инфляцдаа нөлөөлөөд байдаг. Тэгэхлээр мөнгөний бодлогоо сангийн бодлоготой хэлэлцэхдээ яг адилхан хэм хэмжээнд үзэхгүй бол өнгөрсөн 2 жилийн хугацааг л бид нар мэдэж байна гэхэд мөнгөний бодлого ерөөсөө 7 хоногийн дотор нэг хагас хагас асуулт асуугаад л тэгээд л дуусчихдаг. Гэтэл яг мөнгөний бодлогодоо нөлөөлж байгаа зүйл нь энэ тэлчихсэн төсөв буюу бүтээмжгүй эдийн засгийн зарлагууд нь нөлөөлөөд байгаа тал дээр энэ Монголбанкнаас бас дүгнэлт, санал, санаачилга гаргаж ажиллах ёстой гэж бодож байгаа. Тэгээд энэ тал дээр та нэг дэлгэрэнгүй тайлбар хэлээд өгөөч.

Н.Учрал: Наранцогт дарга.

С.Наранцогт: Тантай санал нэг байна. Яагаад гэвэл энэ Төв банк өөрөө нэг талдаа энэ инфляцыг хязгаарлах үндсэн чиг үүрэгтэй боловч нөгөө гараараа ингээд хагас төсөв, төсвийн шинжтэй үйл ажиллагаа санхүүжүүлээд ирэхээр энэ мөнгөний зах зээлийг хөөсрүүлэх ажилдаа оролцоод байна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр ерөөсөө бид нар энийг ер нь хийхгүй байх ёстой. Зайлшгүй 2 чиглэл гэсэн. Тэрийг жич ярина.

Мөнгөний бодлого хэлэлцэх асуудал дээр тантай би бас санал нэг байна. Ер нь өөрийн төв банкных нь өөрийнх нь оролцоо ч тэр тэгээд Их Хурал дээр авч хэлэлцэж байгаа байдал нь ч гэсэн бас тэгсхийгээд таны хэлж байгаа шиг яваад байгаа юм. Энийг бид нар их нарийн хэлэлцдэг болох ёстой. Мөнгөний бодлогод их ач холбогдол өгдөг байх ёстой. Яг мөнгөний бодлогоо Их Хурал баталчихсан бол тэрнийхээ хүрээнд л төсвөө баталдаг байх ёстой. Энийг шаардлагатай бол эрх зүйн өөрчлөлт хийх ёстой. Бүүр энэ хатуу төсвийн алдагдалгүй явдаг энэ зарим.../минут дуусав./

Н.Учрал: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Наранцогт даргын сонсгол илэрхийлж байгаа, асуултад харуулж байгаа байр сууриуд, өнөөдрийн бас

асуултад хариулж байгаа гишүүдийн асуултыг бас анхааралтай сонсоод сууж байна. Тэгээд 1 зүйл дээр санал нэгдэхгүй жоохон эргэлзээд байгаа нь тэр гадаадын банк оруулж ирнэ гэдэг дээр маш итгэлтэйгээр зөв гэж хэлээд байгаа юм л даа. Тэгээд шалтгааныг хэлэхдээ мэдээжийн хэрэг мөнгөний эх үүсвэрүүд нэмэгдэнэ дээр нь энэ банкны салбарт өрсөлдөөн үүсээд зээлийн хүү буурна гээд байгаа.

Гэтэл яг бодит байдал дээрээ зээлийн хүү өндөр байгаа нь өрсөлдөөнөөс, өрсөлдөөн байхгүй байгаадаа биш байгаа харагдаад байгаа юм. Манайх чинь импортлогч улс учраас төсөв хэт тэлэхээрээ валютын эрэлт нь нэмэгдээд төгрөгийнх нь ханш суларч байдаг. Тэгээд инфляц нь өсөж байдаг. Засгийн газар нь байнга төсвөө жил болгон өсгөөд сүүлийн 4 жилд хэд дахин өсчихсөн. Төгрөгийн ханш нь төдий чинээгээр суларчихсан ийм үр дүнтэй.

Ингээд инфляц өсөнгүүт нь Монголбанк нь бодлогын хүүгээ өсгөж хаяад ингээд компаниа банкнууд нь гадагшаа эрсдэлтэй, эрсдэлгүй баахан зээл олгож байсан дор өндөр хүүтэй Монголбанк руугаа шилжүүлэх маягтай. Ингээд зах зээлээс мөнгөө татах байдлаар инфляцыг хамгаална гэдэг ийм үйл ажиллагаа хийгээд ингээд үндсэндээ банкнуудын хүү өндөр тэгээд компаниуддаа зээл олдохгүй, аж ахуйн нэгжүүдийн зээл олдохгүй ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм. Энэ дээр яагаад ийм өндөр итгэлтэй байгаад байгаа юм бэ гэж. Энэ гадаадын банк орж ирэхийн эрсдэлтэй талууд бас бий л дээ.

Жишээлбэл, эдийн засгийн хараат байдал нэмэгдэнэ. Дотоодын банкны зах зээлд эрсдэл үүснэ. Тэгээд Наранцогт дарга хэлж байгаа нь төрийн биш хувийн, арилжааны шинжтэй банкнуудыг оруулж ирнэ гэдгээрээ тэр нөгөө эдийн засгийн тусгаар тогтнолтой холбоотой асуудлыг аюулгүй байдлыг нь хангачихна гэж үзэж байх шиг байгаа юм. Гэтэл үндсэндээ эдийн засгийн тусгаар тогтнол гэдэг нь тэр төрийн өмчит банк байна уу, арилжааны банк байна уу гэдгээсээ үл шалтгаалаад манай дотоод асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яагаад ийм их итгэл өндөр байгаа вэ гэдэг дээр та тодорхой тайлбар хэлээдхээч. Эрсдэлтэй хүлээн зөвшөөрч байна уу? Энэ эрсдэлтэй талууд олон байгаа. Эрсдэлтэй талуудыг ер нь юу гэж бодож байна? Гадаадын банкнуудыг оруулж ирэх нь. Зөвхөн зээлийн хүү бууруулах зорилгоор оруулаад ирчихээр энэ дээр чинь асуудал үүсэхгүй юу? Зээлийн хүү бууруулах нь явж явж Засгийн газрын л энэ төсвийн бодлогын л асуудал байгаа. Тэгэхээр Монголбанкны Ерөнхийлөгч гэдэг зүгээр ингээд Засгийн газар нь төсвөө тэлээд инфляц хөөрөгдөөд нөгөө талдаа Монголбанкны Ерөнхийлөгч нь Монголбанк нь ингээд бодлогын хүүгээр жонглёрдоод суудаг биш илүү нөлөөлдөг байгаасай гээд олон гишүүд захиж байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар бодолтой байна вэ?

Н.Учрал: Наранцогт нэр дэвшигч хариулна.

С.Наранцогт: Лодойсамбуу гишүүн тантай санал нэг байна. Таны яг зарчмын санал зөв. Ер нь энэ ингээд манай чуулган энэ олон нийтэд нээлттэй явдаг гаднын олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулагч бүгдээрээ бас анхаарч байдаг. Тийм учраас би бас ингээд Төв банкинд нэр дэвшигчийн хувьд аль болох захиргааны арга гаднын хөрөнгө оруулалтыг хаах, боох асуудлыг ярихаас би цээрлээд байгаа юм.

Ер нь таны яг болгоомжилж байгаа асуудлыг би бас бодож байгаа. Тэр судалгаатай бас Төв банкны судалгаа байгаа гэдэгт итгэлтэй байна. Ажлаа хүлээж авбал би очоод нарийн танилцана. Мэдээж энэ тал эмзэг асуудлыг ойлгож байгаа. Би ямар байдлаар ер нь зарчмын хувьд Монгол Улсын энэ бид ингээд захиргааны зах зээлийн зарчмуудыг эвдэх тийм захиргааны аргаар хүү тогтоох, гаднын хөрөнгийг үргээх иймэрхүү мэдэгдэл, зарчмын байр суурийг хариуцлагатай албан тушаалтан барих ёсгүй гэдэг ийм зарчмын байр суурийг маань та ойлгоорой.

2 дугаарт тэр бодлогын хүүг жонглёрдож суудаг гэдэг асуудал дээр чинь бас санал нэг байгаа. Бид нар энэ дээр өөрсдөө төсөв батлагдах үед, Мөнгөний бодлого батлагдах үед Их Хурал тэр дундаа Эдийн засгийн байнгын хороонд асуудлаа маш нарийн судалгаа дэлгэрэнгүй танилцуулж асуудлаа бид нар бодитой ярьж, зөв шийдвэр гаргадаггүй. Тэгээд дараа нь бие биеийгээ муулдаг, эсвэл хаалгаа хаачхаад бид нар бие даасан хараат бус шүү дээ гээд суугаад байж болохгүй юм л гэж би бодоод байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Лодойсамбуу гишүүн тодруулъя.

Ч.Лодойсамбуу: Тэгээд Ардчилсан намын зүгээс ер нь ингээд төсвийн хэт тэлэлт, төсвийн үргүй зардлуудыг багасгах шаардлагуудыг удаа тариа тавьсаар өнөөдрийг хүрч байгаа. Тэгээд энэ Их Хурлын танхим, чуулганы танхим, энэ Засгийн газрын хуралдааны танхимаас худлаа ярихыг болиулмаар байна. Энэ дэд сайдыг томилдог дээр Монгол Улсын Засгийн газрын танхимаас худлаа ярьж байна. Их Хурлын чуулганы хуралдааны танхимаас гишүүд нь худлаа ярьж байна. Улаан цайм хууран мэхэлж байна.

Жишээлбэл, тэр бүтээмжийн, хяналтын гээд байгаа менежерүүд чинь компаниас цалин авдаг болохоос төсвөөс цалин авч байхад тэр төсвийг нь хэмнэж байгаа юм ерөөсөө биш. Энэ худлаа ярьсандаа энэ Засгийн газар, энэ Ерөнхий сайд, саяын хэлсэн энэ Их Хурлын гишүүд Монгол Адын намын гишүүд бүгдээрээ уучлалт гуйх хэрэгтэй. Хууран мэхлэх ажиллагаа хийж байгаагаараа. Энэ төсөвтөө ерөөсөө хамаагүй тэр компаниас цалин авдаг. Одоо харин 16 дэд сайд бол төсвөөс цалин авна. Одоо төсөвт 100 төгрөг ч байхгүй. Тэгэхээр бүгдээрээ уучлалт гуйх хэрэгтэй. Энэ танхимаас ядаж худлаа хэл.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн алга байна. Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Нэр дэвшигчид би нэг зүйл захиж хэлэх гэсэн юм. Энэ Ардчилсан нам олон болоод засгийн эрх барьж байхад энэ нэг ипотекийн зээлтэй холбоотой асуудлыг анх 8 хувийн зээл гэдэг асуудал шийдсэн юм. Маш олон залуучууд байртай болсон. Өнөөдөр ерөөсөө залуучуудын хүсэл мөрөөдөл байр шүү дээ. Яаж байртай болох вэ, яаж нэг хэдэн төгрөгөөрөө орон гэрээ төвхнүүлэх вэ гэдэг ийм л мөрөөдөлтэй байгаа. Харамсалтай нь энэ мөрөөдөл унтраад байна. Ерөөсөө энэ ипотекийн зээл гэдэг танил талтай хүнд гардаг, танил талаараа дамжуулж ипотекийн зээл авдаг, орон байртай болох мөрөөдөл нь биелдэг нэг ийм л байдал руу оччихоод байна.

Тэгэхээр манай Норовын Алтанхуяг Ерөнхий сайдын хэлсэн нэг сайхан үг байдаг юм л даа. Шинэчлэл гэдэг сэтгэл гаргаж хийх ёстой ажил юм гэдэг үг байгаа юм. Тэгэхээр танд захиж хэлэх үг нь сэтгэл гаргаж ажиллаарай. Тухайн үедээ Монголбанкны Ерөнхийлөгч Золжаргал, Монгол Улсын Ерөнхий сайд Алтанхуяг нар олон мянган залуучуудыг байранд оруулж байсан энэ үйл явц улам суларсаар байгаад өнөөдөр цөөн нэг зээл танилтай хүний гардаг ийм байдалтай болсон. Энийг чинь дагаад залуучуудын байртай болох мөрөөдөл, барилга, орон сууц олноороо баригдаж Улаанбаатар хотын утаагүй болох мөрөөдөл замхарч байна.

Тэгэхээр гар хумхиж суулгүйгээр, ямарваа нэг шалтаг шалтгаан тоочихгүйгээр улс төрчдийн буруу нь байх юм бол улс төрчдийн бурууг нь хэлээд, дэмжлэг байх юм бол дэмжлэгээ хүсээд энэ залуучуудыг байртай болгох, ипотекийн зээлийг хэвийн олох энэ нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө чин сэтгэлээрээ, сэтгэлээ дайчилж, сэтгэл гаргаж, шинэчлэл хийж ажиллаарай гэж ингэж хүсье.

Улс орны нөхцөл байдал амаргүй байгаа. Бид нар жилийн жилд олон зүйлд татаас өгч, олон зүйлд мөнгө хэвлэх байдлаар ингэж аргалж байгаа. Төсөв тасарч байгаа тэгээд энэ нөхцөл байдлыг тэртээ тэргүй олон яригдсан, олон байгаа учраас нэг нуршиж яримааргүй байна. Тэгэхдээ энэ урьд нь хийж байсан ажлууд дээрээ бас бид хамт ажлын хэсэг болж аливаа нэг асуудлыг шийдвэрлэхийн төлөө явахад нэлээн сэтгэлтэй, зүтгэлтэй, дээрээс нь хувийн ашиг сонирхолгүй ингэж ажиллаж байгаа байдал чинь анзаарагдсан юм. Тэгэхээр одоо яг энэ хандлагаараа Монголынхоо мянга мянган залуучуудыг орон байртай болох тэр мөрөөдлийг нь биелүүлэхэд Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд мөнгөний бодлогыг барьдаг гол байгууллагын удирдлагын хувьд хичээл зүтгэл гаргаж ажиллаарай гэж хичээнгүйлэн захъя. Захиасаа бас дараа дараагийн удаад байнга нэхэж шаардаж ажиллах болно гэдгээ илэрхийлье.

Ж.Бат-Эрдэнэ: Алтангэрэл гишүүн үг хэллээ. Ганбаатар гишүүн

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Монголбанкны Ерөнхийлөгчид дэвшигчид нэр дэвшиж байгаа хүн бас Монгол Улсын төсөв ялангуяа энэ Сангийн яам холбогдох газруудад ажиллаж байсан туршлагатай хүн нэр дэвшиж байгаад талархалтай байгаа.

Ер нь өнгөрсөн хугацаанд ний нуугүй хэлэхэд Монголбанк бол Засгийн газрын дохиураар, дээрээс нь Засгийн газрын кассын үүрэг гүйцэтгэж ирсэн шүү. Тэгээд одоо яагаад ч юм өмнөх Ерөнхийлөгч өнөөгийн байдал ханш ямар байгаа билээ? Ийм байдалд оруулчхаад баахан шагнал хүртээд яваад байгааг үнэхээр ойлгохгүй байгаа. Та өөрөө бас эдийн засгийн хүн сайн мэдэж байгаа байх. Энэ эдийн засаг руу асар их мөнгө нийлүүлээд тэгээд энэ улс төрийн энэ шийдвэрүүдийг дагаад энэ утоп баахан поп шийдвэрүүд нөгөө Шинэ хоршоо гэдэг шиг тэгээд үүнийгээ нэг баахан бага хүүтэй зээл олгоод үндсэндээ түүнийхээ зөрүүг үнэт цаас гаргаад, алдагдалд хүлээгээд үндсэндээ Монголбанкны алдагдал үүнээс эх үүсвэртэй.

Өнөөгийн энэ инфляц, мөнгөний ханшны уналт үүнтэй л холбоотой. Үүнийх нь хөлд аж ахуйн нэгжүүд, ард иргэд үнэхээрийн энэ инфляцад яаж нэрвэгдэж

байгаа билээ. Хамгийн гол нь Монголбанкны үндсэн ажил бол Монгол төгрөгийн үнэ цэнийг төгрөгийн ханшийг тогтвортой барих асуудал. Яг энэ чиглэлээрээ яаж ажиллах юм, татвар зээлийн дарамтад хүүд байгаа энэ аж ахуйн нэгжүүдээ яаж дэмжиж ажиллах юм. Дээрээс нь төсвийн болон энэ мөнгөний бодлогын уялдааг хэрэгжүүлэхэд эрх зүйн орчин чинь хэр хангалттай байгаа юм гэдэг ийм 3 асуулт байна. Тэгээд асуултдаа хариултаа авчхаад тодруулах эсэхээ шийдье.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

С.Наранцогт: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Яг манай гишүүд нөгөө тойргийн сонгогдож энэ ард иргэдтэй ойрхон ажиллаж байгаа учраас яг бодит нүүрлээд байгаа асуудлуудыг их бодитой ингээд хараад байгаа гэдэг нь харагдаж байгаа. Тэгэхээр мөнгөний үнэ цэн буурсан энэ зүйл бол энэ өнгөрсөн хугацааны төсөв мөнгөний бодлогоор эдийн засаг маань хөөсөрсөн. Энэнээс болоод яг энэ өнөөдрийн үр дагавар бий болоод таны хэлж байгаа нэг ёсондоо бид нар түймэр тавьчихаад тэгээд энийгээ унтраах гэж л энэ их зардал гаргаад нөгөө бодлогын хүүг их өндөр бариад энэнээс болж аж ахуйн нэгж компаниуд бас их хүнд байдалд орж байгаа гэдэгтэй би санал нэг байгаа.

Тэгээд 6, богино хугацаанд мэдээж яг ийм нөхцөл байдлыг ингээд тэр дор нь засах гэдэг тийм том амлалт хийхгүй ч гэсэн энийг энэ макро тэнцвэрийн бодлогоор энэ компаниуд маань жишээлбэл татвараа төлж чадахгүй нөхцөлд орсон байна. Энийг нь дээр нь нэмээд зээлийг нь зогсоох юм ингээд ер нь маш хэцүү юм руу орох ёс болчихож байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь яг нөгөө би их нарийн мэдээлэлгүй учраас яг ингэнэ тэгнэ гэхгүй. Гэхдээ нэлээн нарийн сонсголын үеэр мэс заслын аргаар гэдэг нь эшлэлээр дотогшоо орж асуудлуудыг нэг бүрчлэн ингэж үзэж энэ дээр тодорхой богино хугацаанд энэ хүндрэлийг давах, энэ хөөсийг хагалахгүй байх энэ бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дунд хугацаанд ер нь яг гишүүд маань бас байнга ярьж байна. Ийм зүйл ингэж зүйл гаргадаггүй байх бид нар тогтолцоо системийн шинэчлэлийг л хийх ёстой. Монголбанкин дээр ч тэр Их Хурал энэ хууль, эрх зүйн хүрээнд ч тэр. Тэгэхээр энэ дээр ингээд томилогдоод ажиллах юм бол нэлээн шинжлэх ухааны судалгаа, тооцоо, яг бодит дата дээр зөв оноштой үндэслэлтэй ингэж зүйлүүдийг гаргаж ирээд тэгээд энэ төсөв, мөнгөний бодлого Их Хурал баталдаг учраас Их Хурлын гишүүддээ Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүд ялангуяа маш нухацтай нэгдсэн ойлголттой байж бид нар энэ төсөв, мөнгөний бодлогоо баталж яваад энэ улс орныхоо эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлыг яг улс орныхоо макро үндсэн байгаа байдалтай уялдуулж ингэж тодорхойлж баталдаг болсны дараа бид нарт дахиж ийм хүндрэл үүсэхгүй. Баланстай тогтвортой өсөлт хангаад ард иргэдийн аж амьдрал бол энэ хэмжээгээрээ баталгаажих ийм боломж бүрдэнэ гэж ингэж бодож байгааг хэлье танд.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүн тодруулах уу болсон уу? Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн алга байна. Тогмидын Доржханд гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе Нэлээн анхааралтай энэ томилгооны асуудлыг анхаарч байна. Ер нь манай парламент дээр анхаарлын улс төр их

давамгайлаад зарим гишүүд маань бодлогын мэтгэлцээн, бодлогын асуудал гэхээсээ илүү камерт зориулж их үг хэлдэг болсон байна. Миний хувьд Наранцогт нэр дэвшигчийг дэмжиж байна. Гэхдээ энэ дээр 3 тодорхой асуулт бас танаас асуумаар байна.

1 дүгээрт манай улсад мэдээж зээлийн хүү өндөр байгаа. хүртээмж муу байгаа гэдгийг бид нар бүгдээрээ л ярьж байгаа. Хүн болгон энийг мэддэг, ярьдаг. Үүний голлох шалтгаан нь инфляц гэдгийг бид нар бүгдээрээ хүлээн зөвшөөрч байгаа. Инфляцын түвшин өндөр, бодлогын хүү өндөр. Ингээд нөхцөл байдлаас болоод бодлогын хүү маань өндөр байна. Гэхдээ Монголбанкны бодлогын хүү 12 хувь, хэрэглээнд гарч байгаа зээлийн хувь хүү 17, 18 цаашлаад 20 хувь байна.

Тэгэхээр бодлогын хүү болон энэ зээлийн хүүгийн ялгаа 5-8 хувийн зөрүүтэй байна. Гэтэл өндөр хөгжилтэй улсуудад энэ ялгаа 2-3 хүүд л, хувьд л баригддаг бодлогын хүүтэйгээ маш ойрхон явж ирдэг. Тэгээд энэ олон хувийн, хүүгийн ялгаа таны бодлоор юунаас болж байна гэж бодож байгаа вэ? 1 дүгээрт тэр макро тогтворгүй байдлын эрсдэл нь хэдэн хувь гэж бодож байна? Валютын ханшийн эрсдэл нь хэдэн хувь гэж бодож байна? Уул уурхайн мөчлөгийн эрсдэл нь хэдэн хувь гэж бодож байна? Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл муу байгаатай холбогдуулалтай буюу хууль, эрх зүйн орчны шинэчлэл хийгдэхгүй байгаатай холбоотой эрсдэл нь хэдэн хувь гэж бодож байна? Мэдээж энэ дээр бид нар бас Улсын Их Хурал ч гэсэн арга хэмжээ авах ёстой. Тэгэхээр Улсын Их Хурлын зүгээс энэ бодлогын хүү болон зээлийн хүүгийн ялгаа, заагийг багасгахад иргэддээ хямд хүүтэй зээлийг олгоход Улсын Их Хурлын зүгээс ямар хууль, эрх зүйн дэмжлэг, бодлогын дэмжлэг хэрэгтэй гэж та үзэж байна? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт бизнес эрхлэгчдийн дунд одоогийн зохицуулалтаар факторингийн үйлчилгээ гэж байдаг. Энэ өөрөө нийлүүлэлтийн санхүүжилтийн маш чухал хэлбэр байгаа. Тэгтэл одоогийн нөхцөл байдал дээр энэ факторингийн үйлчилгээний эрсдэл бол энгийн зээлийн эрсдэлээс өндөр та гэж үзсэн байгаа. Тэгээд ийм учраас энэ маань өөрөө хүртээмж багатай, эрсдэл өндөртэй гэдэг юм руу яваад бид нарын нөгөө бизнес эрхлэгчдийн дунд зээлийн төрөлжсөн факторингийн зээлийн үйлчилгээ ерөөсөө хөгжиж чадахгүй байгаад байна. Тэгэхээр энэ нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн чухал хэрэгсэл факторингийг банкнууд хөгжүүлэхэд одоогийн активын ангиллын журам дээр юу саад болж байна гэж та үзэж байна? Монголбанк энэ чиглэлээр зохицуулалтыг ер нь эргэж харах бололцоо байгаа юу гэдэг дээр таны бас бодлыг авмаар байна.

3 дахь асуулт хэрэглэгчийн эрх ашиг талаас асуумаар байна. 1 минутаа дарга нэмээд авчихъя. Банкны үйлчилгээнд зээл төлбөр.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн 1 минут өгье.

О.Номинчимэг: Төлбөр, тооцооны үйлчилгээ дээр хурдан цахим зээлийн үйлчилгээ нэмэгдэж байгаа. Хүртээмж бас сайжруулах талаар ч гэсэн явагдаж байгаа. Гэхдээ энэ цахим зээл, төлбөр тооцооны энэ бүтээгдэхүүн, үйлчилгээний холбоотой хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал нэлээн яригддаг. Нөгөө талаасаа нөгөө банк санхүүгийн байгууллагын эрсдэлийг бууруулах зохимжтой арга нь юу вэ гэдэг асуудал яригдаад байгаа. Сүүлийн үед энэ банкнуудын олгож байгаа цахим зээлийн чанар бусад зээлтэй харьцуулахад чанаргүй зээлийн хувь,

хэмжээ нэлээн өсөөд байгаа юм байна. Тэгээд энэ нь эргэн төлөлт харьцангуй муу байгаад байна. Тэгэхээр энэ дээр цахим зээлийн эрсдэл өндөр байгаа шалтгааныг та юу гэж ойлгож байна? Энэ талаар Төв банкны зүгээс юу хийх ёстой гэж бодож байна гэдэг дээр нэр дэвшигчээс хариулт авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Наранцогт хариулъя.

С.Наранцогт: Та зээлийн хүү өндөр байгаа энэ бүтцийг юу гэж харж байна вэ гээд. Эхний хэлэх зүйл бол мэдээж хэрэг бид нар олон улстай харьцуулах нь зөв. Тэгэхдээ ижил төстэй эдийн засгийн бүтцийн хувьд ижил байгаа улсуудтай бид бас өөрсдийгөө харьцуулахгүй бол, харьцуулж явах нь бас зүйтэй. Тэгэхээр нөгөө бид хэдийн хөгжиж буй орны яг эдийн засгийн бүтэц олдог орлого, үйлдвэрлэл хэр хэмжээнд өссөн байна. Тэгээд энд төлбөрийн тэнцэл маань ямар явж байгаа вэ гэдгээс бас нэлээд суурь үзүүлэлтүүд хамаарч байгаа.

Бодлогын хүү дээр нэмээд бүтцүүд ямар байна вэ? Үндсэндээ л 4 бүтэц байгаа. Эх үүсвэр өөрөө 12 хувь, дээр нь нэмээд нөгөө эрсдэлийн таны хэлж байгаа эрсдэл 2.5, үйл ажиллагаа 2.5. Тэгээд банкнуудын ашиг нь 1.5 гэсэн. Ер нь нэг ийм ойролцоо тооцоог би хувьдаа гаргаж үзсэн. Тэгэхээр эрх зүйн хувьд та ямар дэмжлэг хэрэгтэй байна вэ гэдэг бол Улсын Их Хурлаас энэ шүүхийн энэ зээл, зээл, санхүүгийн энэ барьцаа авдаг энэ шүүхийн маргааныг энэ чиглэлд хийгдэж байгаа зээлтэй холбоотой шүүхийн маргааныг их хурдан шийдвэрлэдэг болох хэрэгтэй. Турк энэ тэр гээд зарим улсуудад энэ ерөөсөө бараг цахим бүртгэл болчихсон юм билээ. Автоматаар нөгөө шийдээд явчихдаг барьцаа хөрөнгө нь. Нөгөө талдаа мэдээж хэрэглэгч хохирох барих гээд асуудлууд давхар байх байх. Тэгэхдээ энэ дээр ингээд нухацтай хандаад тв банкнаас бас гаргасан, бэлдсэн тооцоо судалгаа би байгаа байх гэж би бодож байна. энэ чиглэлд зайлшгүй ажиллаж байж энэ эрсдэлийн зардал буурна.

Үйл ажиллагааны зардлын хувьд бас түрүүн би хэлж байсан өнгөрсөн жилтэй харьцуулахад банкны ашиг 16 орчим хувиар буураад тэр юунаас болсон байна вэ гэхээр хүн хүний нөөцийн зардал нь 14 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь банкнууд маань бас үйл ажиллагааны зардалд шахагдаж байгаа гэсэн үг. Тэгээд ашиг 1.5 хувь. Ашиг ч гэсэн өнгөрсөн жилээсээ бас буурсан. Тэгээд манай гишүүдийн бас хэлээд байгаа нь тэр өөрийн өөрийн хөрөнгийг ашигтай харьцуулахаар өндөр байна гэдэг нь тэр нь бас үнэн байгаа юм. Өөрөөр хэлбэл, өөрийн хөрөнгөө бас нэмэгдүүлэх шаардлага байна гэсэн үг. Тэр хэмжээгээр банкнуудын эрсдэлийг бууруулах. Нийт гаргасан зээлтэйгээ харьцуулсан харьцаа нь болохоор бас олон улсын түвшинд оччихсон байна гэсэн үг. Зээл гараад тэрэнтэй холбоотой үйл ажиллагааны бас тодорхой зардлууд гарч байна гэсэн үг.

Цахимжиж байгаа хэр нь ингээд бас хураамж банкнуудын бас би нэгдсэн дата авч үзсэн үзсэн. Тэгэхэд ялт ч үгүй бас үйл ажиллагааны тэр ашгийн нэлээд том нь тэр хураамжийн зардал дээр байна лээ. Тэгэхдээ мэдээж бид нар асуудалд хандахдаа ялангуяа Төв банк бол энэ банкнуудтай өнөөдөр энэ гишүүдэд банкнуудын үйл ажиллагаатай холбоотой нэлээдгүй зүйлүүд яригдлаа. Энийг Төв банк хяналт шалгалтынхаа үүргийн хүрээнд яг бодитой тогтоож, хянаж, шалгаж, зохицуулалтынхаа үүргийг гүйцэтгэх хэрэгтэй. Би тодорхой ялангуяа саяын тэр ипотекийн зээл дээр гарч байгаа доголдол энэ тэр дээр ажилд томилогдвол ажил авмагцаа хяналт шалгалтыг нэлээн өргөн хэмжээнд оруулж шалгах ёстой юм

байна гэж бодож байна. Түүнтэй адилхан яг анализ судалгаа бид нар хийж үзэх ёстой. Энэ яг зардал үнэхээр бодитой байна уу, эсвэл ингээд хөрөнгө оруулалтаа нөхөөд бодитой бууруулах боломж байсаар байтал ийм хэрэглэгчдийг хохироож байгаа асуудал байгаа юм уу гэдэг зүйл дээрээ нухацтай ажиллана. Тэгэхээр ер нь Төв банк асуудалд ингээд нухацтай хандаж яг тооцоо судалгаа хийгээд тэгээд энэ ард иргэдээс ирж байгаа асуудал ингээд Их Хур.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дахиад тодруулъя Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Улсын Их Хурал дээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ороод ирчихсэн байгаа. Тэгээд дүн шинжилгээ хийгээд үзэхээр ер нь шүүхийн шийдвэр гүйцэтгэл хурдан, түргэн шуурхай болсноор зээлийн хүү 2 хүртэл хувь буурах боломжтой гэсэн судалгаа нь гарчихсан байгаа. Бусад мэдээж тэр хүчин зүйл буюу манай улсын уул уурхайгаас хэт хараат байдал, макро эдийн засгийн тогтворгүй байдал, таны хэлээд байгаа төлбөрийн тэнцэл гээд эдийн засгийн нөхцөл байдал ийм өндөр хүүтэй байхад нөлөөлж байгаа.

Гэхдээ бид нар хийж чадах, өөрсдөөсөө хийж чадах боломжтой юман дээр анхаараад энэ иргэддээ, аж ахуйн нэгжүүдээ хямд төсөр эх үүсвэртэй, хүү багатай зээл олгодог байх дээр анхаарах ёстой. Энэ цахим зээлтэй холбоотой асуудал дээр ер нь Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг бид нар бас харахгүй бол хэрэглэгчийн эрх ашиг манай иргэний хуулийн суурь зохицуулалт дээр үнэхээр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтууд их сул байдаг. Ялангуяа энэ 21 дүгээр зуун, цахим хэрэглээ, цахим гэрээтэй холбоотой.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Даваасамбуугийн Ганмаа гишүүн байхгүй байна. Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Наранцогт даргыг дэмжиж байгаа нь бас туршлагатай, төрд олон жил ажилласан хүн гэж бодож байна. Нөгөө талаар бас хариуцлагатай ажиллах байх гэж бодож байна. Хэд хэдэн асуудал асууя. Сая Онончимэг гишүүний саналыг бас дэмжиж байгаа юм байна. Энэ зээлийн хүү маш өндөр. Эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байгаа улсуудын 80 хувь нь цалингийн зээлтэй. Хүүхдээ сургаж байна. Хүүхдийн төлбөр, амьдралын шаардлагаар зээл авч байгаа. Зээлийн доод хэмжээ нь 1.9, дээд хэмжээ нь 2.5 хувь байна. Гэтэл арилжааны банкнууд ашиг нь маш өндөр байна. Хэдэн 100 тэрбум их наядаар нь ашиг хүсэж байна гэж улсууд яриад байгаа юм. Тэр нь үнэн үү? Ер нь зээлийн хүүд ядахдаа 2-оос доошоо буулгаад 1.6, 7 хавьцаа уулзаж болдоггүй юм уу? Төрийн байгууллагад ажиллаж байгаа улсууд байна шүү дээ эд нар чинь найдвартай зээлдэгчид байгаа шүү дээ уг нь. Төрийн үйлчилгээний байгууллага, эрүүл мэнд, боловсролын байгууллагад ажиллаж байгаа улсууд. Энэ талаар та ямар бодлого барих вэ ер нь?

Нөгөө талаар эрүүл мэндийн салбарын өр зээл байгаа. Жилийн жилд нуудаг. Зарим нь 30 хэдэн тэрбумд өртсөн, доод тал нь 3 тэрбумын өртэй. Жишээлбэл хотын клиникийн эмнэлгүүд, аймгуудын нэгдсэн эмнэлгүүд байгаа. Энэ талаар судалгаа гаргасан уу та? Сая бид эрүүл мэндийн салбарын цалинг 75 хувь нэмэгдүүлнэ гээд юунд тусгачихсан, чуулганаар баталчихсан. Гэтэл энэ НДШ-

ийн босгыг 15 хувиар нэмэгдүүлчихсэн шүү дээ. Тэгэхээр чинь ялгаагүй болчихоод байна л даа. Тэгэхээр энэ тал дээр та ямар бодлого барих вэ дараа тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулъя.

С.Наранцогт: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ зээлийн хүүг л бууруулах талаар ингээд манай олон гишүүд ярьж байна. Би сая зээлийн зардал юунаас бүрдэж байгаа ингээд тайлбарлаад энэ дээр бид нар зохицуулалтын хүрээнд ямар арга хэмжээ авч болох вэ? Ер нь суурь асуудал инфляц. Энэнээс болоод ингээд чөтгөрийн тойрог үүсээд энэ яг гацчихаад байгаа юм зээлийн маань.

Нөгөө талдаа зээлийн эрэлт их байна. Мөнгөний үнэ цэнтэй холбоотой бас энэ иргэдийн маань зээл авах зээл их өндөрсөж байна. Би түрүүн хэлсэн цалингийн зээл бол өмнөх жилээс 14 хувиар, тэтгэврийн зээл 44 хувиар нэмэгдчихсэн байна. Нөгөө талдаа эдгээрийнх нь найдваргүй зээлийн хэмжээ мөн иргэдийн цалингийн зээл 152 хувиар найдваргүй зээл нэмэгдчихсэн. Энэ нь өөрөө их бас анхаарал татахуйц тоо болчихоод байгаа. Тэгээд таны хэлж байгаагаар надад яг тэр нөгөө салбарын тоо баримт алга байна. Би ажил аваад томилогдвол энийг бас салбараар нь нарийвчилж ер нь Төв банк мэдээж энэ ийм асуудлуудыг их нарийвчилж авч үзэх ёстой. Нарийвчилсан нарийн судалгаан дээр үндэслэж, дүгнэлт, оношийг зөв тогтоож явах ёстой. Ерөнхий зарчим өнөөдрийн бид нарын нөхцөл байдал дээр болоод энэ инфляцын өндөр түвшин, бодлогын үнийн өндөр төвшнөөс болоод зээлийн хүү маань энэ өндөрт очоод тогтчихоод ингээд байна.

Цаашдаа хамгийн том зардал нь эх үүсвэрийн зардал. Энэ эх үүсвэрийн зардал бид нар инфляц өндөр байгаа түвшинд энэ инфляцаас доордсон эх үүсвэр аль ч тохиолдолд татагдаж орж ирэх бололцоогүй. Тийм учраас банкнуудын гадаад пассив 60 гаруй хувиар нэмэгдсэн байна лээ. Тэгэхээр энэ маань юуг харуулж байна вэ гэхээр дотоод эх үүсвэрээсээ бас хамааралгүй гаднаас арай илүү хямд үүсвэр авчирч зээл нэмэгдэж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ зээлийн асуудал дээр хэд хэдэн юмнууд хийгдэх ёстой, бас иргэдийнхээ санхүүгийн боловсролыг оруулаад энэ зээл гэдэг бол өөрөө бас тийм сайн зүйл биш өрийн дарамтад оруулж, иргэдийг бас өөрсдийн санхүүгийн хувьд хүнд байдалд оруулах зүйл гэдэг зүйлийг бас нөгөө талдаа ойлгож өгөх хэрэгтэй байгаа. Бид бас ингээд зээлийг захиргааны аргаар юм уу зээлийг шууд тэглэхдэг энэ тэр гэсэн ойлголтыг ард иргэдэд ерөөсөө өгч болохгүй. Бид энийг аль болох энэ суурь нөхцөлүүдээ төв банкнаас болоод төрийн бодлогоор сайжруулж, зах зээлийнхээ орчныг сайжруулж явах болохоос биш ямар нэгэн байдлаар захиргааны арга хэрэглэх журмаар энэ зээлийн хүүг бууруулж болохгүй юм гэдэг зүйлийг би танд хэлэхийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тогмидын Доржханд. Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Тэгэхээр сая нөгөө эрүүл мэндийн салбарыг дэмжихгүй бол ер нь эмнэлгүүд цалинг л өгч байна. Эм байхгүй ард иргэд гаднаас авчирч байна. Тийм учраас та тухайн салбарын эмнэлгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар болон нягтлангуудаас нь тодорхой ямар хэмжээний өр байна тэрийг аваад гаргахгүй бол

энэ нуусаар байгаад сүүлдээ өчнөөн тэрбум хүрчхээд байна. Тийм учраас энэ дээр нэлээн анхаарч ажиллах байх гэж бодож байна.

Нөгөө талаар гадаад өр хэр байна? 40 тэрбум доллар хүрчихсэн гээд байна. Энэ үнэн үү энэ талаар асууя. Тэгээд танд бас ажлын амжилт хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Наранцогт хариулъя. Гадаад өр.

С.Наранцогт: Гадаад өрийн дарамт нэмэгдэж байгаа нь үнэн. Гэхдээ энэ Засгийн газрын өр нь 8.1 тэрбум гэж хамгийн сүүлийн. Бусад 20-иод тэрбум доллар нь нийтээрээ таны хэлж байгаа тэр 40 орчим тэрбум байгаа гэдэг нь үнэн. 20 гаран тэрбум нь энэ нөгөө Оюун толгойн хөрөнгө өр гэж ингэж бид нар бүртгэж байгаа. Өнгөрсөн жилд манай банк санхүү бус санхүүгийн байгууллагуудын гадаад пассив нэмэгдсэн байгаа. Тухайлан Засгийн газар бол гадаад өрийн дахин санхүүжилт хийсэн. Миний харснаар нэг банкнууд Засгийн газар гаднаас 1.7 тэрбум доллар төвлөрүүлээд энэний яг 750 нь цэвэр дүнгээр төлбөрийн тэнцэлд нөлөөлсөн байна лээ. Тэгэхээр энэ нь юу гэсэн үг вэ гэхлээр 1.7 орчим тэрбум доллар гаднаас оруулж ирээд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Надад асуулт байхгүй. Тэгэхдээ маш тодорхой 3 саналыг хэлье. Санал хэлэхээсээ өмнө би нэг зүйлийг бас онцолж хэлмээр байна. Наранцогт нэр дэвшигчтэй би Сангийн яаманд бас цуг ажиллаж байсан. Энэ хүн бол санхүүгийн чиглэлээр маш сайн мэргэшсэн ийм төрийн албан хаагч. Дээрээс нь Эдийн засгийн хөгжлийн яаманд бас ажиллаж байсан. Макро тэгээд санхүүгийн зах зээлийнхээ асуудлыг сайн мэддэг ийм мэргэжилтэн хүн нэр дэвшүүлж байгаад би маш их тааламжтай хүлээж авч байна.

Төсвийнхөө бодлогыг мэддэг, тэгээд санхүүгийн зах зээлээ ойлгодог, мөнгөний бодлого, макроогоо бас харж чаддаг ийм хүн Монгол банканд ажиллах бол Засгийн газартайгаа бас ойлголцоод явахад маш нэмэртэй байдаг. 3 зүйл байна.

Нэг нь болохлоороо Монголбанкны үүрэг юу юм бэ гээд тэгэхлээр Монголбанкны үүрэг гэдэг инфляц биш шүү ганц. Бас ханш байдаг. Төгрөгийн тогтвортой байдал гэдэг ар талдаа хамгийн чухал юм ханшаа тогтвортой барих ийм асуудал байдаг. Тэрний ар тал нөөц байдаг. Тэгэхээр Монголбанкны Ерөнхийлөгч гэдэг хүн маш муухай ааштай хүн байх ёстой. Дээрээс нь нөөцөө тэврээд байж байдаг хүн байх ёстой байдаг. Нөөцийн хувьд юу байдаг вэ гээд тэгэхлээр алт чухал шүү. Зарим эдийн засагчид болохлоор алт үнэтэй болчихоод байна алтаа зар гээд байдаг тэр буруу шүү. Алтаа бид нар бүүр 100 тонн, 300 тонн ийм нөөцөд хүргэх юм бол дэлхийн бүх хөрөнгө оруулалтын банкнууд, банк санхүүгийн сангууд чинь бүгдээрээ хүрч ирээд маш их хэмжээний бага хүүтэй ийм зээлийн эх үүсвэрийг Монголын зах зээлд нийлүүлэх бүрэн боломжтой. Ийм байдлаар бид нар зээлийн хүүг асар богино хугацаанд буулгах ийм эдийн засгийн хөшүүрэг нь бий болно оо гэдэгт анхаарч ажиллах хэрэгтэй шүү. Нэг.

2 дугаарт нь энэ мөнгөний бодлого гэдэг төсвийн бодлогын тохируулагч болоод явж байдаг. Зах зээл дээр мөнгө байхгүй тохиолдолд бид нар бодлогын

хүүгээ буулгах замаар зах зээл рүү мөнгөө оруулаад явж байх ёстой. Гэтэл яг ингээд бодлогын хүүгээ бууруулах, зах зээлээ бизнесүүд рүүгээ мөнгө гаргах ийм шаардлага үүсчхээд байгаа гэдгийг бас анхаараарай.

Тэгээд төсөв 1 жилээр батлагддаг мөнгөний бодлого гэдэг улирлын шинж чанартайгаар тохируулагчийн үүрэг гүйцэтгэж явдаг юм шүү. Тийм болохлоор энэ дээрээ нөөцөө, мөн инфляцаа хэтэрхий их онилж явж байна гэж байгаад зах зээлээ бас ингээд буцалж болохгүй шүү гэдэг дээр нэг санаа хэлмээр байна. Анхаараарай.

Дараагийнх нь гадаадын банк. Гаднын банк наашаагаа оруулж ирэхэд маш нээлттэй хандах ёстой. Тэгээд манай Наранцогт нэр дэвшигч энэ дээр бас нээлттэй хандаж байгаа гэж ойлгож байгаа. Гаднынхан орж ирэхэд манай зах зээл дээрх ийм бүтээгдэхүүн хэрэгтэй, төслүүд хэрэгтэй байдаг шүү. Bankable төслүүд. Энэ төслүүдтэйгээ бид нар дэмжиж оруулж ирж байж, хаалгаа нээж байж гаднын банк орж ирнэ. Тэгэхлээр энэ дээр нээлттэй хандах хэрэгтэй.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Чуулганы хуралдааныг 14 цаг хүртэл завсарлуулж байна.

Үдээс хойших чуулганы хуралдаан үргэлжилнэ. Гишүүдийг танхимд урья.

13.13 цаг

Пүрэв гараг 18 Арванхоёрдугаар сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 13 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААН

Н.Учрал: Үдээс хойших хуралдаан үргэлжилнэ. Гишүүдийг танхимд урья.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалтыг явуулах ёстой. Гишүүд танхимд цуглая. Гишүүдийг танхимд урьж байна. Бүлгийн дарга нар гишүүдээ танхимд уриарай. Үдээс хойш чуулганы хуралдаан үргэлжилнэ. Үдээс хойш чуулганы хуралдаан үргэлжилж байна. Гишүүдийн танхимд урья.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж эхэлнэ. Мөн эхний асуудал буюу Сонгуулийн ерөнхий хорооны даргыг чөлөөлөх асуудлаар бас мөн санал хураалт явуулна. Үргэлжлээд дандаа санал хураалтууд байгаа шүү. Гишүүдийг танхимд урья. Гишүүдийг танхимд урья. Нэр дэвшигч танхимд орж ирье. Гишүүдийг танхимд урья.

Эхний санал хураалт. Сонгуулийн ерөнхий хорооны даргыг чөлөөлөх асуудлаар санал хураалт явуулна. Дараа нь Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүдийг танхимд урья. Монгол Ардын намын бүлгийн дарга Батжаргал дарга гишүүдээ цуглуулъя. Батжаргал дарга өөрөө хуралдаа ирье. Цогтгэрэл дарга Ардчилсан намын бүлгийн дарга, ХҮН нам чуулгандаа цуглая. Ирэх 7 хоногт Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулиудын хэлэлцэх эсэхийг дэмжинэ. Чуулганы хуралдаан ирэх 7 хоногт нэлээн ачаалалтай байна. Хэлэлцэх эсэхийг дэмжсэн хуулиудаар гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүдийг байгуулна. Батжаргал дарга хуралдаа цуглая, бүлгийн гишүүдээ дуудъя. Санал хураалт явууллаа шүү.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн даргыг чөлөөлөх асуудлаар санал хураалт явуулна. Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох асуудлаар санал хураалт явуулна. Энэ томилгоонууд чинь хуулийн хугацаатай тэгээд ингээд байлгаад байж болохгүй байна. Нөгөө Хяналт шалгалтынхаа хуулийн дагуу сонсголоо явуулаад процедурынхаа дагуу явж байгаа асуудал. Тийм учраас хурдан хугацаанд шийдвэрлээд ажлыг нь шахаад шаардаад явна. Сахилга бат, хариуцлагаа нэмэгдүүлъя. Монгол Ардын намын бүлгийн дарга, Ардчилсан намын бүлгийн дарга. Энэ сахилга бат, хариуцлагаа нэмэгдүүлнэ шүү нөхөд өө. Шууд санал хураалтаар эхэлнэ сайд нар цуглаарай.

Санал хураалтад, эхний асуудлаар санал хураалт явуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргыг чөлөөлөх асуудлаар санал хураалт явуулах ёстой.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэнэ.

Санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе. Нэг ирцийн санал хураалтыг явуулъя. Ирцийн санал хураалт. Гишүүдийг танхимд урья. Алдаржавхлан гишүүн, Алтанхуяг гишүүн, Амарсайхан гишүүн, Амгаланбаатар гишүүн, Баасанжаргал гишүүн, Бадамсүрэн гишүүн, Бат-Амгалан гишүүн, Батбаатар гишүүн. Энэ түрүүн яваад байсан яасан бэ? Батбаатар гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Батбаяр гишүүн, Батцэцэг гишүүн. Энэ Батцэцэг гишүүн хаачив? Баярбаатар гишүүн. Бейсен гишүүн ирчихсэн байна. Бейсен гишүүн ирчихсэн байна. Сая бүртгэлийн санал хураалтад ороогүй. С.Ганбаатар, Д.Ганбат? Ганбат гишүүнийг дуудаарай. Ганмаа гишүүн сая санал хураалтад ороогүй байна. Даваасүрэн гишүүн, Дэлгэрсайхан, Дэлгэрсайхан гишүүн хаана байна? Дэлгэрсайхан гишүүнийг дуудаарай. Эхлээд түр хорооны санал хураалт явуулаадахъя. Тэр Баярмаа гишүүний санаачилсан түр хорооны санал хураалт явууллаа. Тэгээд Дэлгэрсайхан гишүүнийг дууд. Жаргалан гишүүн, Замира гишүүн, Мандхай гишүүн байна. Сая ороогүй байна. Мөнхбат гишүүн сая санал хураалтад ороогүй байна. Мөнхбаясгалан гишүүн байна. Мөнхтуяа гишүүн байна. Наранбаяр гишүүн байна. Номин гишүүн. Номин гишүүн хаана байна? Дуудаарай. Одбаяр гишүүн. Одноо дарга хаана байна хаачив? Пунсалмаа гишүүн. Пүрэвдорж дарга нэг арга хэмжээтэй гээд байгаа юм. Саранчулуун гишүүн сая кнопт ороогүй байна. Соронзонболд гишүүн байна. Сэдээ гишүүн? Сэддорж дарга байна. Туваан гишүүн, Туваан гишүүн хаачив? Тэмүүжин гишүүн байна. Ундраа гишүүн. А.Ундраа гишүүн? Уянгахишиг гишүүн орж ирсэн үү? Даваагийн Цогтбаатар гишүүн байна.

Цогтгэрэл дарга. Цэнгүүн гишүүн. Цэнгүүн гишүүн? Чинбүрэн сайд хаана байна? 8 санал хураалт хийх гэж байна дараалаад. Чинбүрэн сайд хаана байна? Чойжилсүрэн сайд, Л.Энх-Амгалан гишүүн, Д.Энхтүвшин хаана байна? Д.Энхтүвшин гишүүнийг дуудаарай. Энхцэцэг гишүүн, Энхцэцэг гишүүн хаачив? 8 санал хураалт явуулъя. Батцэцэг сайд? Дуудаарай. Дараалаад 8 санал хураалт явуулъя.

Пүрэвийн Дэлгэрнараранг өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц шүү дээ. Санал хураалт явуулах гэж байна. Дэмжигдэхгүй бол үлдэнэ гэсэн үг. Чөлөөлөгдвөл Нарийн бичгийн дарга нь үүрэг гүйцэтгэнэ.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас Пүрэвийн Дэлгэрнараранг өөрийнх нь хүсэлтээр чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

74 гишүүн дэмжиж, 71.8 хувиар санал дэмжигдлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай”

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Пүрэвийн Дэлгэрнараранг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Сонгуулийн ерөнхий хорооны даргыг шинээр томилох хүртэл хугацаанд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байхыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Нарийн бичгийн дарга Даваанямын Даваа-Очирт даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Улсын Их Хурлын гишүүдэд талархлаа.

14.27 цаг

Үргэлжлээд Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулах ёстой. Бүртгэлийн санал хураалтыг явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Бүртгэлд 84 гишүүн бүртгэгдлээ. Татгалзсан гишүүд байхгүй гишүүд байна уу? Бадамсүрэн сайд хаана байна? Энэ Бат-Амгалан сайд хаана байна? Дууд дууд. Батсүмбэрэл хаана байна? Батсүмбэрэл гишүүн? Батсүмбэрэл гишүүнийг дууд дууд. Энэ Батцэцэг сайд хаана байна? Элчин сайдуудаар эхлээд санал хураачихъя Батцэцэг сайдад хэлээрэй. Элчин сайдуудын асуудлыг оруулж ирсэн. Эхний санал хураалт явуулчих уу гээд Батцэцэг сайдад нэг хэл дээ. Элчин сайдаар санал хураалт явуулах гээд байна гээд. Батсүмбэрэл гишүүн орж ирлээ. Энэ Даваасүрэн, Дэлгэрсайхан сайд хаана байна? Баярмаа гишүүн тэр түр хороогоор санал хураалт эхлүүлчих үү? Дэлгэрсайхан сайд хаана байна?

Үгүй нээрээ энэ хариуцлагатай баймаар байна. Энэ өөрийнхөө асуудлыг болохоор орж ирээд өрөөлийн асуудал болохоор хамаагүй юм шиг ханддаг энэ чинь Монголбанкны Ерөнхийлөгчийг энэ чинь хуулийн хугацаа нь дуусчхаад байна шүү дээ. Энэ Сайнзориг ороод ирчихсэн байна. Сайнзориг гишүүн ороод ирсэн байна. Туваан сайд хаана байна? Чинбүрэн сайд хаана байна?

Сайд нар ядраад ажилдаа түүртээд байвал хэлээрэй. Үгүй нээрээ хэлээрэй. Ядраад, түүртээд ажил нь амжихгүй сайд нар байвал хэлээрэй. Тийм бас энэ чинь сайдын ажлын албыг Их Хурлын гишүүнтэй хавсаргаж хийх чинь бас түүртдэг ажил шүү дээ. Өөрөө хувийн зохион байгуулалт, хувийн зохион байгуулалт өндөртэй хүмүүсийн хийдэг ажил шүү энэ сайд чинь. Тэрнээс биш ингээд ажилдаа түүртээд байвал энэ амжихгүй ажил. Тийм учраас хэлэх хэрэгтэй. Бас ийм аль алийг нь амжуулах боломжтой, хувийн зохион байгуулалт өндөртэй яг ид хийж бүтээх насан дээрээ явж байгаа хүмүүс энэ дотор их олон байгаа шүү. Манай энэ олонхын бүлэг дотор. Тийм, тэгээд маш олон тийм гишүүд байгаа. Мэдлэг, чадвар, туршлагатай, нэлээн тийм ажлыг хийх эрмэлзэлтэй, хувийн зохион байгуулалт өндөртэй хүмүүс манай олонхын бүлэг дотор олон Их Хурлын гишүүн бас намын даргадаа энэ байдлаа уламжлаад байгаа гэдгийг ажлаа түүртэж байгаа хүмүүст бас сануулъя.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэлээ. Санал хураалт явуулна. Дэлгэрсайхан сайд орж ирлээ.

Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 83 гишүүн дэмжиж, 79.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

“Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай”,

Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилсугай.

2. Бядрангын Лхагвасүрэнгийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдсон Санжаагийн Наранцогтод ажлын амжилт хүсье. Улсын Их Хурлын гишүүдэд талархлаа. Хэлэлцэх асуудал үргэлжилнэ.

14.33 цаг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 55.2 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

14.35 цаг

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байна.

Санал хэлэх юм уу? Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал горимын санал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг дахин айлтгая. Уг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 1 дүгээрт байр сууриа нэгтгэх тухай асуудал байна.

2 дугаарт зарим яригдаж байгаа мэдээллүүдийг нягтлах асуудал байгаад байгаа. Тийм учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу ажлын 5 өдрийн завсарлага хүсэж байна

Н.Учрал: Хэзээ бүлэг хуралдах юм, хэзээ бүлгийн хуралдаан хийх юм? Ирэх нэг дэх өдөр бүлгийнхээ хурлыг хийгээд эцэслэх хэрэгтэй. Ажлын 5 хоногийн завсарлага өглөө. Дараагийн асуудалд орёё.

14.37 цаг

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад бэлтгэлээ. Одоо санал хураалт.

Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

74 гишүүн дэмжиж, 70.5 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Цогтбаатар гишүүнийг нэмье дэмжсэнээр бүртгэж авъя. Батжаргал гишүүнийг дэмжсэнээр бүртгэлд авъя.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

76 гишүүн дэмжиж, 72.4 хувиар санал дэмжигдлээ.

3.Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

79 гишүүн дэмжиж, 75.2 хувиар санал дэмжигдлээ.

Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

14.40 цаг

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Индэрт урья.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нарын зүгээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы

нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Тус Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нэрс гарсан байна.

Бөхчулууны Пүрэвдорж? Бөхчулууны Пүрэвдорж дарга алга байна. Дуламын Бум-Очир? Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Энэ хуулийн төслийг Засгийн газрын оруулж ирсэн саналын зарчмаар дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна. Нэг жаахан ялгаатай зүйл байгаад байгаа. Тэр юу вэ гэхээр цагаан сар, наадам хагас, бүтэн сайн таарвал тэрийг нь дараагийн ажлын өдөрт нь шилжүүлж өгч амрах ийм заалт байгаа Засгийн газрын саналаар.

Өнгөрсөн жил юу болсон бэ гэхээр та бүхэн мэдэж байгаа би бас нэг сануулъя гэж бодож байна. Шинийн нэгэнгүй байсан. Тэгээд шинийн 2, 3 нь болохоор хагас, бүтэн сайн таарчихсан байсан. Ингээд сар шинээ үндсэндээ хагас, бүтэн сайны хоёрхон өдрийн дотор тэмдэглэн өнгөрүүлэх ийм нөхцөл байдал үүссэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газар яаралтай шийдвэр гаргасан. Түүнийх нь ард мэдээж байгууллагууд, аж ахуйн нэгжүүд ажил төрлөө зохицуулах гээд нэлээд их асуудал болсон. Нэлээн тулж Засгийн газар шийдвэр гаргасан учраас. Тийм учраас энэ мэт асуудлуудыг зохицуулах үүднээс энэ хуулийн төсөл бас хэрэгцээ шаардлагатай байна гэдгийг хэлж байгаа юм.

Нөгөө талдаа мэдээж цагаан сар, наадмаар хэрвээ амралтын өдөр таарчихвал ажлын өдрийг нь амралтын өдөр болгож сунгаж ажиллуулах нь зарчмын хувьд зөв байх. Бид энэ өв соёлын асуудлыг зөндөө ярьдаг. Тэгэхээр энэ үүднээсээ энэ хуулийн төслийг дэмжиж байгаа гэдгийг хэлмээр байна.

Бас нэгэн зүйлийг би гишүүддээ болоод иргэддээ мэдээлэл болгоод хэлчихмээр байна. Миний өөрийн санаачилсан Битүүний өдрийг амралтын өдөр болгох тухай хуулийн төсөл Засгийн газар дээр санал авах гээд өгчихсөн байгаа. Энэ хаврын чуулганд, энэ намрын чуулганд багтаагаад хэлэлцээд шийдвэр гарчих болов уу гэж бодож байгаа юм. Энэ талаар мэдээлэл өгч байгаа гол шалтгаан юу вэ гэхээр бас иргэд асуугаад байх юм энэ битүүний өдөр амрах юм уу үгүй юм уу гээд. Тэгээд энэ хуулийн төсөл маань бас агуулгын хувьд төстэй учраас хүмүүс бас дунд нь энэ хууль мөн үү, биш үү гэж гишүүд маань хүртэл асууж байна.

Тэгэхээр яг энэ хууль биш шүү. Миний санаачилсан хуулийн төсөл энэ намрын чуулгандаа багтаад намрын чуулган хаахаас өмнө орж ирээд хэлэлцэгдэх болов уу гэж бодож байна. Хэлэлцээд хэрвээ гишүүд дэмжих юм бол энэ ирэх жилийн гэх үү энэ хавар болох битүүний өдөр нийтээрээ амрах ийм нөхцөл байдалтай болох юм гэдгийг бас хариуцлагатайгаар мэдэгдмээр байна. Баярлалаа.

Н.Учрал: Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Баяр ёслол бол зөвхөн ёслол, заншил гэхээсээ илүү хүмүүсийн сэтгэл зүйд дархлааг бий болгож өгдөг ийм нийгмийн үйл ажиллагаа. Гэхдээ нөгөө талд энэ өдрийг сонгох, энэ өдөртэй холбоотой ямар сөрөг үр дагаврууд байдаг вэ гэхлээр энэ яаралтай тусламжийн үйлчилгээнүүд нийгмийн эмзэг бүлгүүдэд байнгын хэрэгтэй үед тусламж үйлчилгээ хүргэдэг салбарын асуудлууд дээр ямар өөрчлөлт гарах бол оо гэдгийг ер нь судалж үзсэн болов уу? Яагаад гэхлээр хэдийгээр бүх нийтээрээ баярлаад баяраа тэмдэглээд бүгд амардаг боловч эрүүл мэнд, хүний амь нас, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ялангуяа нийгмийн үйлчилгээ авдаг, эрүүл мэндийн үйлчилгээ авдаг бүлгүүдэд тэр үеэр ингээд нөгөө бүх юм нь ингээд хаагдаад амарчихлаар хамгийн их орхигдож бас хохирдог асуудлууд гардаг. Дээрээс нь баяр ёслолын үеэр хамгийн их гэмтэл, осол, эрүүл мэндийн бас ийм дуудлагууд бас бий болдог. Тэгэхээр энэ дээр ер нь ямар үр дагавар гарахыг надад ирсэн материал дээр би хараагүй байгаа учраас тодруулж бас асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Зулпхар гишүүн. Уянга гишүүн.

Б.Уянга: Саранчулуун гишүүндээ баярлалаа. Яг энэ чиглэлээр болохоороо таны танд гишүүдэд тараагдсан хуультай холбоотой судалгаа тэр холбогдох тайлангуудад дурдаж судлагдаагүй.

Гэхдээ таны хэлсэн зүйл үнэн юм билээ. Гэмтэлтэй холбоотой, гэмтлийн эмнэлгүүдийн ачаалал нэмэгддэгтэй холбоотой асуудал хөндөгддөг. Өшөө бас нэг зүйл нь болохоороо яг энэ үндэснийхээ 2 баярыг л ярьж байгаа шүү дээ наадам болон цагаан сар ярьж байгаа. Энэ баяр жил болгон Бямба, Ням гарагтай амрах ёстой өдрүүд нь давхцаад байдаггүй. Давхцасан тохиолдолд ямар нэгэн байдлаар Засгийн газар дандаа хойш нь шилжүүлдэг юм байна лээ. Тэгэхээр ингээд эдийн

засгийн хувьд нь судалъя гэсэн ч шилжүүлэхгүй байсан тохиолдол байхгүй учраас судлахад тийм яг тоон тийм шинжилгээ гаргаж тавихад хүндрэлтэй байсан. Тэгээд нийт яг энэ Нийтээр тэмдэглэдэг баярын тухай хуулиар зохицуулагддаг 9-н баярын 16 амралтын энэ өдрүүдийн агуулга нэмэгдэж баярын тоо нэмэгдээгүй.

Ер нь нийтээрээ хуулийн заалт 22 оноос хойш байхгүй байхад хүртэл Засгийн газраас зөвлөсүгэй гээд тогтоол гарахад нийтээрээ монголчууд д дагаж мөрдөж байгаа энэ зохицуулалтыг хуульд нь хэм хэмжээ байдлаар тусгаж өгөх нь зүйтэй юм байна. 22 оноос хойш байхгүй байгаа заалтыг арай боловсронгуй болгоод заавал Засгийн газраас тогтоол, шийдвэр гарахыг хүлээхгүйгээр яг найруулгын хувьд хуульчидтай сууж байгаад хэрвээ үндэсний энэ 2 баяр маань амралтын Бямба, Ням гарагтай давхцах юм бол хойш нь шилжүүлэе гэдэг зохицуулалтыг найруулж орсон байгааг харж байгаа байх.

Эрүүл мэндийн яам болон бусад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэх зэрэг эдгээр яамнуудад холбогдох судалгаанууд байгаа гэдэгт итгэлтэй байна. Тэгэхээр яг холбогдох чиглэлээр нь бид нар бас хяналт хийж энэ дээр нь анхааруулгыг өгч ажиллах нь зүйтэй байх гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу? Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа Ер нь ингээд статистик харах юм бол авто замын осол, гэмтэл бэртэл, архидан согтуурахтай холбоотой асуудлууд, зарим төрлийн хүчирхийлэл баяр ёслолын үеэр урт амралтын үеэр бий болдог гээд бүгдээрээ мэдэж байгаа. Тийм болохоор энэ хэдийгээр бид нар баярлаж амрах нь зүй ёсны хэрэг, энэ дээрээ анхаарах хэрэгтэй боловч нөгөө талд яг энэ салбарын асуудал нь удааширчихдаг, үйлчилгээ нь хойшоо болчихдог.

Тэгэхээр энд нэг цөөхөн хэдэн хүмүүсийн хохирол үүсдэг учраас аливаа хуулийн төсөл, аливаа энэ цаглавар, өөрчлөлт, хуваариудыг ярьж байгаа бол тухайн салбарын онцгой байдал, эрүүл мэндийн салбар, гэр бүлийн салбар, хүүхдийн салбарынхан бас давхар хараа хяналтаа илүү эсрэгээрээ өндөржүүлэх ёстой гэж би боддог. Тийм болохоор энэ асуултыг асууж байгаа. Тэгээд хууль санаачилж байгаа хүмүүс болон энэ хуулийн төсөл дээр ажиллаж байгаа хүмүүс энэ дээрээ бас анхаараасай гэж хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Банзрагчийн Түвшин гишүүн.

Б.Түвшин: Энэ нийтээр тэмдэглэх баяр ёслолын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай нэг ганц нэгхэн асуулт асууя. Ер нь цагаан сар, улсын наадмын тухай энэ амралтын асуудлуудыг дэмжиж байгаа. Гэхдээ өнөөдөр бид нар нийтээр тэмдэглэх баярын өдөр одоогийн байдлаар хуульд 10 өдөр байж байгаа. Бүхэл бүтэн 10 өдөр. Тэгээд энэ нь ямар нэгэн хуулиар цаашаагаа хэдэн ч өдөр болж задрах эрсдэлтэй. Нэг талаасаа энэ өдрүүд хэтэрхий олон байна.

Нөгөө талаасаа энэ чинь Хөдөлмөрийн тухай хуульд жишээлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 109.4 дээр хэлж байгаа шүү дээ. Нийтээр амрах баярын өдрүүдэд ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг 2 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно гээд заачихсан. Бид нар энд нийтээр амрах өдрийг нэмээд байхад л нөгөө жирийн

бизнес эрхлэгчдийн хувьд нь дундаж цалин хөлс нь өсөж байдаг ч юм уу, тасралтгүй үйлдвэрлэлийн процессынх нь өртөг нь өсөж байдаг.

Энэ Хятад зэрэг ийм улсуудад ингээд бүх нийтээрээ амралтын өдрүүд нь ингээд гараад ирэхлээрээ эдийн засаг нь сэргэж байдаг. Яагаад гэх юм нь нөгөө Хөдөлмөрийн хууль нь тусдаа зохицуулалтаар явдаг. Энэ нийтээр баяр амрах өдрүүд нь төрийн албан хаагчидтай түлхүүдүү хамааралтай. Хувийн болон бизнес эрхлэгчдийн хувьд ерөөсөө тэр Хөдөлмөрийн хууль дээр байж байгаа манай монголынхоор зүйрлэх юм бол цагаан сар, улсын наадам, тэгээд амралтаа бүтэн амраах ёстой. Жилийн хагас, бүтэн сайны амралтуудаа бүтэн тооцож олгох ёстой. Бусад өдрүүд нь ажлын өдөр байхаар ингээд салгаж зохицуулдаг. Тэгэхээр манайд энэ хууль, эрх зүйн орчныг нь салган зохицуулах боломж юу байна. Хэтэрхий олон нийтээр тэмдэглэх баярын өдрүүдтэй болчихож болоод байгаа юм биш үү? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт л энэ нийтээр тэмдэглэх баярын өдрөөс цагаан сар, улсын наадмыг нь үлдээгээд бусдыг нь тэмдэглэлт өдрүүд болгочихвол яасан юм? Яг энэ ЖДҮ-лэлийнхэн, худалдаа эрхлэгчид, хөдөлмөр эрхлэгчид энэ гарч байгаа Хөдөлмөрийн хуулийн заалтынхаа дагуу энэ өдрүүдэд хохирол амсаад байгаа байхгүй юу. Салбар дэмжигдэх биш. Тэгээд энэ 2 асуултад нэг хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Уянга гишүүн.

Б.Уянга: Түвшин гишүүнд баярлалаа. Энэ нийтээр тэмдэглэх баярын хуулийг анх 1999 онд монголчууд батлаад түүнээс хойш хэрэгжиж байгаа хууль байна. 2022 онд Хөдөлмөрийн тухай хуулийг дагаад яг өнөөдрийн бид нарын одоо хэлэлцэж байгаа энэ өөрчлөлттэй холбоотой яг зохицуулалтын үндсэн заалт нь байхгүй болсныг эргэн сэргээж оруулж ирэхдээ зөвхөн наадам болон цагаан сарыг нь зохицуулалттай байя. Бусдыг нь хэрвээ амралтын өдөр давхцах юм бол тэрийг ямар нэгэн зохицуулалт байхгүй байдлаар оруулж ирж тусгасан.

Тэгэхээр яг энэ хуулийн төсөл өнөөдрийн хэлэлцэж байгаа байдлаараа болохоор энэ 2 том үндэсний хэмжээний баярын асуудлыг ярьж байгаа юм. Төрийн байгуулалтын байнгын хороогоор яг энэ хуулийн төсөл хуваарилагдаад хэлэлцүүлэгдсэн. Хэлэлцүүлэг явагдаж байх үед ажиглагдаж байсан нэг зүйл нь болохоор манай Улсын Их Хурлын гишүүд хоорондоо ер нь үзэл бодлын хувьд хуваагдаж байсан нь их онцолмоор байсан. Зарим нэр бүхий гишүүд ингэж байгаа юм хүн бол бүтээмж бүхий ажил гүйцэтгэх ёстой. Бүтээмжтэй байх ёстой. Тэрэнд амралт зайлшгүй шаардлагатай. Заавал үндэсний 2 баяраа сугалж аваад Бямба, Ням гарагтаа хэрвээ тухайн жилд давхацвал, давхцахгүй ч байж болно. Давхацвал яах вэ гэдэг нийгмийнхээ хэм хэмжээг яах вэ гэдэг зохицуулалтыг энэ хууль дээр суулгая гэж зарим нь үзэж байхад зарим нь ер нь бүх баяруудыгаа ингэвэл яасан юм бэ бид нар чинь 9 баярыг энэ хуулиар зохицуулдаг. Нийт 16 амралтын өдрийг л ярьж байгаа. Бусад улсуудтай харьцуулах юм бол энэ дунджаас доогуур үзүүлэлт юм байна. Энэтхэг жишээ нь 42 хоног, 365 хоногийн 42 хоног нь нийтээр тэмдэглэх баяр байдаг юм байна гэх жишээтэй. Гишүүд хуваагдаж байсан тэгээд олонхын саналаараа, мөн Засгийн газраас санал авсны дагуу өнөөдөр үндэсний 2 баяр наадмынхаа энэ нийгмийнхээ асуудлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр нь санал нь ороод ингээд өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг явж байна.

Ингээд эдийн засагт хүндрэл, жижиг, дунд байгууллагуудад хүндрэл учруулж магадгүй гэсэн шүүмжлэлүүд ирсэн. Олон төрлийн шүүмжлэлүүд ирснээс бас нэг өөр нэг зүйл байсан нь эерэг талдаа үйлчилгээний салбарт бас хэрэгтэй юм уу. Олон хоног дараалаад ажиллалаа гэхэд зарим нэг үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлэх иргэдийн тоо бас ихэснэ. Тэгэхээр ийм байдлаар эдийн засагт бас нэмэр, та түрүүн Хятадад нийтээрээ амрахад дотоодын эдийн засаг нь яаж дээшилдэг талаар ярьсан жишээ бүхий саналууд хүртэл ирж байсан. Энэ нийгмийн чиглэлийн хуулийн зохицуулалт юм. 2 том баяраа л авч өнөөдөр бид нар эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлж байна.

Тэгэхдээ Улсын Их Хурлын гишүүдэд бид нарт бүрэн эрх байгаа. Яг энэ 2 баярыгаа л яг энэ энэ хуулиараа авч үлдье. Бусад баяруудыг тэмдэглэлт өдрүүд болгоё оо гэсэн өөрчлөлтийг бас үзэл баримтлалын хүрээнд бэлдээд өргөн барихад бүрэн боломжтой юм.

Ж.Бат-Эрдэнэ: Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Нийтээр тэмдэглэх баяр ёслолын амралтыг зохицуулах гэж орж ирж байгаа энэ хуулийн төсөл ерөнхийд нь дэмжиж байгаа. Энэ хууль батлагдаад 22 жил болсон байна. Зохицуулагдахгүй асуудлууд амралтын өдөр 7 хоногийн ажлын өдрийн дундуур таарчих юм бол шилжүүлэх үү, шилжүүлэхгүй байх уу, амрах уу, амрахгүй байх уу гээд нэлээн асуудлууд бас үүсдэг. Үүнийг зохицуулах гэж байгаа нь сайшаалтай.

Монголчууд үндсэндээ 365 хоногийн 120 хоног орчимд нь амарч байна. 7 хоногийн хагас, бүтэн сайн өдөр, дээрээс нь нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд 10-аад өдөр. Ингээд 120 хоног. Үлдсэн хугацаанд ажилладаг. Энэ ажил, амралт, ажлын бүтээмж, амралт 2 хоорондоо бас зохистой харьцаатай байх ёстой. Энэ зохистой харьцаа алдагддаг. Дээрээс нь 7 хоногийн дундуур 1 өдөр амраад амрах, маргааш амралтын өдөр гээд, амарч ирснийхээ маргааш ажлын өдөр гээд тэр хэмжээгээр ажлын бүтээмж буурах, ажил цалгардах иймэрхүү зүйлүүд гардаг. Үүнийг зохицуулах гэж байгааг зөв гэж үзэж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол Мартын 8-н, Эх үрсийн баяр, Бурхан багш дүйцсэн өдөр, Улс тунхагласны баярын өдөр, Чингис хааны мэндэлсэн өдөр гээд энэ баяруудыг амралтын өдөр таарах юм бол дараагийн ажлын өдөр рүү нь шилжүүлэхгүй байх, ажлын өдөр таарах юм бол амралтын өдөр рүү шилжүүлэх иймэрхүү зохицуулалт зөв өө. Амралтын өдөр таарах юм бол дахиж сунгаж амрахгүй байх, ажлын өдөр таарчих юм бол амралтын өдөр рүү шилжүүлэх ийм зохицуулалт байгаад үндсэндээ энэ 7 хоногийнхоо хөдөлмөрийн бүтээмж, ажил, амралтынхаа хуваарийг бас зөв болгох нэг талдаа ийм байх нь зөв байх гэж бодож байгаа.

Тэгэхгүй юу гэдэг юм тэгээд л амраад л байдаг, байж байгаад л нэг 7 хоногийн дундуур нэг амраад л, хагас бүтэн сайнд амраад л. Ингээд байх нь хөдөлмөрийн бүтээмжид бас нөлөөтэй. Амралтыг ингэж бас хэтэрхий хавтгайруулж болохгүй байх гэж бодож байгаа.

Гол асуудал бид цагаан сар, наадам, битүүний өдөр ажлын өдөр байдаг. Ажиллаад байдаг, маргааш шөнийн юм болох гээд гэр орноо цэвэрлэмээр байдаг, бэлэг хачгаа бэлдмээр байдаг, бууз, баншаа цэгцэлмээр байдаг гээд олон асуудал үүсдэг. Гэтэл ажлын өдөр учраас ажлаа хийх ёстой. Эсвэл гэртээ ингээд тэр өдөр ажилгүй, бүтэмжгүй болчихдог. Иймэрхүү юмнуудыг бид нар битүүний өдрийг амралтын өдөр болгох, 7 сарын 10-н наадмын өмнөх өдрийг амралтын өдөр болгох, цаашлаад шинэ жил 12 сарын 31-нийг бас амралтын өдөр болгох иймэрхүү бас зохицуулалтууд бас байх ёстой байх.

Энэ зохицуулалт талаасаа бас ингээд орж ирж байгаа хуулийн төслийг дэмжиж байгаа. Ингэж бид нар бас нэгэнтээ ажилладаггүй нэр, ёс төдий ажилладаг ийм ажлын өдрүүдийг амралтын өдөр болгоод албан ёсоор ингээд нэг цагаан сараар жоохон уртхан амарчихдаг тэгээд шинийн 3 хүртэл амарна гэдэг, хөдөө гадаа явна, аав, ээжтэй золгоно гээд нөгөө шинийн гурвандаа багтаж золгох гээд л бас л бөөн л юм болдог. Яарч сандраад л хөдөө гадаа явдаг, аваар осол хийдэг. Тэгвэл жоохон сунгуухан, тайвуухан амарчихдаг байя цагаан сараараа.

Наадмаараа, бас наадмын урд өдрөөс авхуулаад бас хэдэн хоног амарчихдаг байх. Иймэрхүү зохицуулалтууд бас орж ирж байгаа нь сайшаалтай. Энэ агуулгаар энэ хуулийн төслийг ийм сайн зохицуулалтууд нь хэрэгтэй. Тийм зохицуулж чадаагүй асуудлуудыг бас зохицуулж байгаа нь сайшаалтай. Ингээд бас ингээд дэмжээд явах нь зөв байх гэж бодож байгаа.

Харин тэр 7 хоногийн дундуур амардгийг л бид нар болимоор байна. 7 хоногийн дунд дундуур амардаг. Энэ л бас бид нарын хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлж байгаа. Энийг бас анхааралдаа авах ёстой шүү л гэдгийг бас хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Бямбацогт гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийнхаа асуудалдаа орёе.

15.00 цаг

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Таныг индэр дээр урьж байна.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон баталсан.

Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа тамхины онцгой албан татварын асуудал, тамхины хэрэглээнд хяналт тавих, хэлэлцээрийн биелэлтэд 3 жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулах, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, батлуулах санал гаргасныг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул тухайн хуулийг хэлэлцэн баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх дэд заалтад тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тарифыг тэглэсэнтэй холбогдуулан нийтийн эрүүл мэнд, эдийн засаг, улсын төсөв, татварт нөлөөлөх үр дагаврын дүн шинжилгээ хийх, тамхины гаалийн татварыг нөхөх, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх тооцооллыг хийж холбогдох хууль тогтоомжийн төслийг 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, 2 дахь дэд заалтад Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад байгаа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан хэрэгжих эхлэх хүртэл хугацаанд тамхи, тамхин бүтээгдэхүүн, электрон тамхины импортын хэмжээг 2024 оны сар болгоны хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлах, 3 дахь дэд заалтад хэлэлцээрийн биелэлтэд 2 жил тутамд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Монгол Улсын Их Хуралд танилцуулахаар тусгасан.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороогоор хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир тогтоолын төсөлд тусгасан нэр томъёоны талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн тогтоолд тусгасан гаалийн тариф, онцгой албан татвартай холбоотой тооцоолол хийсэн эсэх талаар, тамхины хэрэглээг хязгаарлахтай холбоотойгоор нийгэмд сөрөг үр дагавар үүсэх эрсдэлийг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг тогтоолын төслийг агуулгын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд хэлэлцээрийн биелэлтэд 3 жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээг хийхээр тогтоолын төсөлд тусгасныг 2 жил тутамд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхээр тусгах боломжтой эсэх талаар асуулт асууж, санал хэлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

3 гишүүн нэр өгсөн байна. Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Би урьдчилсан нэр өгчихсөн байсан юм. Тэгээд өнөөдөр Байнгын хорооны хурал дээр сая танилцуулах болчихсон учраас энэ удаад алгасчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Пунсалмаа гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Ер нь энэ Евроазийн худалдааны түр хэлэлцээрийг анх Улсын Их Хурлаар зөвшилцөх гээд орж ирэхэд ийм гажуудал гарсан байна, алдаа гарсан байна гэдгийг сануулсан. Даанч засагдах боломжгүй байна гэдэг зүйлийг хэлсэн. Засгийн газар энэ дээр хэлэлцээр хийх явцдаа анзаарсан юм уу анзаараагүй юм уу мэдэхгүй, санаатай юу санаагүй юу ийм зүйл гарсан. Гэхдээ энийгээ алдаа гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа. Тамхи, тамхин бүтээгдэхүүн, ялангуяа энэ янжуур тамхины татварыг тэглэнэ гэдэг өөрөө оршуулгын газрын тэлнэ, оршуулгын газар нэмэгдэнэ л гэдэг үг гэдгийг дахин сануулж хэлмээр байна. Нийгмийн эрүүл мэнд, хүн амынхаа амь насыг тамхины хор, хөнөөлөөс хамгаалах асуудал дээр энэ нэлээн муу гэдэг юм уу маш хортой ийм үр дагавар үүсгэхээр ийм хэлэлцээрийн нөхцөл байгаа.

Гэхдээ энийг Засгийн газар өөрийнхөө алдааг засаад, засах боломжийг энэ тогтоолоор өгч байгаа юм. Тэгээд энийгээ хурдан засаад орж ирээсэй. Ялангуяа энэ дээр тэр хариуцаж байгаа сайдын манлайлал маш чухал. Эс үйлдэхүй гаргахгүйгээр идэвхтэй сайн ажиллах үүрэг Тэргүүн Шадар сайд Ж.Энхбаяр сайдад оногдож байгаа.

Тогтоолын төслийн хэрэгжилттэй холбоотойгоор уг нь 3 сарын 15 гэхэд ирэх чуулган нээгдэх үед энийг өргөн барьчхаасай гэсэн хүсэл байгаа. Хангалттай хугацаа байгаа. 90 хоног хангалттай энэ бол хавар л ярьж байсан асуудал. Энэ дээр Сангийн яам тооцоолол хийгээд ажиллаж байсан байх ёстой. Ажиллаагүй байх юм бол Засгийн газар, энэ Сангийн яам ажлаа хийхгүй байна л гэсэн үг. Тэгээд ямар юман дээр ёстой гэрлийн хурдаар юм оруулж ирж, Засгийн газрын асуудал болохоор оруулж ирчхээд яг энэ ард нийтийн цаагуураа маш их хор хөнөөлтэй, нийгмийн эрүүл мэнд хүн амтай холбоотой энэ асуудлыг цааргалж хүлээх ёстой юм гэдэг дээр одоо үйлдэл харахыг нь л бид нар хүлээж байна.

Тэгээд энийг Ж.Энхбаяр сайдад тусгайлан бас идэвхтэй үйл ажиллагаа хийж, 3 сарын 15 гэхэд энэ хууль тогтоомжийг оруулж ирээсэй л гэсэн захиас үг байна. Энийг дэмжиж байгаа. Бусад гишүүд ч гэсэн дэмжиж байгаа гэж ойлгож байгаа. Уг нь анх хэлэлцээрээ оруулж ирэхдээ л дагаад оруулаад ирэх ёстой

байсан юмыг бас эс үйлдэхүй гарсан учраас одоо Улсын Их Хурлаас тогтоол гаргаж, чиглэл өгч байгаа гэдгийг бас сануулж хэлье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дэгээр урьдчилсан нэрс өгөөд нэрсийн дагуу санал асууна. Биш байна. Намын бүлэг болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан нэрс ирсэн байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооны горимын гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтаа тэгвэл арын асуудлуудтай хамтатгаад явуулчих уу? Санал хураалтыг хойшлууллаа.

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн асуудал.

15.08 цаг

Хянан шалгах түр хорооны сонсгол, тайлан, тайлан, санал, дүгнэлт Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх.

Байнгын хороо хуралдаад дуусаагүй байна уу? Тэгвэл Хянан шалгах түр хорооны хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт Улсын Их Хурлын тогтоолын төслийг маргаашийн хуралдаан руу шилжүүллээ. Дараагийнхаа асуудалд оръё. Дараагийн асуудал.

15.09 цаг

Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох саналыг зөвшилцөх тухай асуудал.

Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Эрдэнэцогтын Одбаяр танилцуулна. Одбаяр таныг индэрт урьж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Үйлстөгөлдөр.

А.Үйлстөгөлдөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн,

1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэрийг;

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мижиддоржийн Цэнгэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг;

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларус Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларус Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг;

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхагвасүрэнгийн Саянааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмидын Баттөрийг;

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жигжээгийн Сэрээжавыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хуланг;

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Бирваагийн Мандахбилэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатарыг;

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Энхтүвшигийн Булганыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчимбуугийн Бямбадоржийг;

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Нарантунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булганыг;

9.Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баттөмөрийн Энхсүхийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжинг;

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржийн Баярхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг;

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Ганхуягийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргалыг;

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өлзийсайханы Энхтүвшинийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг;

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сосорбарамын Энхбаярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянгыг;

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гомбосүрэнгийн Мөнхбаярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэнг;

15.Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сайннямбуугийн Баатаржавыг эргүүлэн татаж, Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайваныг;

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Уламбаярын Нямхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг;

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдины Гансүхийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормааг;

18.Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Шижээхүүгийн Одонбаатарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Амгалангийн Анандыг;

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбажавын Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийтийг;

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюуг;

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөр нарыг тус тус томилох саналыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн болно.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс, олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, эрх ашиг, сонирхлыг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг ханган хэрэгжүүлэхэд шаардагдах судалгааг хийж, төр засгийн байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хоёр болон олон талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн Монгол Улсын хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй Элчин сайдын яамныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн болон дипломат албанд олон жил ажилласан мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын туршлагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан төрийн тусгай албанд ажиллах бүрэн боломжтой гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үзэж байгаа болно.

Дээрх орнуудад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшиж байгаа албан хаагчдыг хэлэлцэн зохих шийдвэр гаргаж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг танилцууллаа.

Одоо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир танилцуулна.

Д.Бум-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зөвшилцөхөөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зөвшилцөхөөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хамтатган хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Номтойбаяр нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Элчин сайдаар ажиллах хугацааны тайланг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулж тайлагнадаг байх, төрийн болон хувийн хэвшилд ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, гадаадад сургахад нь анхаарах, иргэн, хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн болон хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татах,

шинэ техник технологи нэвтрүүлэхэд анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Энхнасан Элчин сайдаар нэр дэвшигчдийг дэмжиж байгаа бөгөөд зарим нэр дэвшигчээс суугаа орны хамтын ажиллагааны хүрээнд санал, санаачилгатай ажиллахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Монгол Улсын өрсөлдөх чадварыг олон улсад таниулах, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, суугаа улсын шинэ технологийг нэвтрүүлэх, боловсролын салбарын шинэчлэл хийх, туршлага судлахад анхаарч ажиллах талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр гадаад харилцааны салбарт олон жил ажилласан мэргэжлийн туршлагатай нэр дэвшигчид байгаад талархаж байгаагаа илэрхийлээд олон улсын харилцаа, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх, суугаа улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдтэй ойр байх, иргэд, хувийн хэвшлээ дэмжих, зах зээлээ тэлэх, тухайн улсынхаа сайн жишээг хуваалцах, мэдээлэл солилцох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбат Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газарт орон тоо нэмэгдэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбүрэн гадаад харилцааны салбар ажлаа хариуцлагатай гүйцэтгэж байгаа талаар дурдаад нэр дэвшигчдэд ДНБ-ээ өсгөх, зээл, тусламжийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалт, эдийн эдийн засгийн харилцаагаа сайжруулахад анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл дипломат албанд ажилласан дадлага, туршлагатай мэргэжлийн нэр дэвшигчид томилогдож байгааг дэмжиж нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Элчин сайд нарыг эгүүлэн татах саналаар санал хураахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Элчин сайд нарыг томилох асуудлаар нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Алтанхуягийн Үйлстөгөлдөр Тамгын газрын дарга, Эрдэнэцогтын Одбаяр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх, Гадаад харилцааны яамнаас Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Бат-Очирын Болд Консулын газрын захирал, Жамбалдоржийн Соёлмаа Гэрээ, эрх зүйн газрын захирал, Баярсайханы Нямдагва

Төрийн захиргаа, хүний удирдлагын газрын дэд захирал, Батсуурийн Мөнхбаяр Бодлогын газрын Дипломат сургалт, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдаар томилогдохоор нэр дэвшигчдийн нэрсийг танилцуулъя. Гончигзэвэгийн Тэнгэр Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Доржрагийн Мөнхтөр Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Гунаажавын Байгалмаа Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларус Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Авирмидын Баттөр Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Ганбаатарын Хулан Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Жагдагийн Оюунбаатар Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Доньжчимбуугийн Бямбадорж Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Дамсрангийн Булган Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Батсүмбэрийн Мөнхжин Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Гунаажавын Батжаргал Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Дэмчигийн Тэгшжаргал Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Дуламсүрэнгийн Даваа Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Ганболдын Уянга Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Очирын Лхагвасүрэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар, Нямцэрэнгийн Энхтайван Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Цэндийн Мөнх-Оргил Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Батсайханы Болормаа Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Амгалангийн Ананд Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар, Лувсанжавын Өлзийт Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Вашагийн Оюу Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Даваахүүгийн Баттөр Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тус тус сонгогдохоор санал ирүүлсэн нэрсийг танилцууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Ирц тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэболд ирцээрээ орчихсон байх. Одоо орж байна уу?

С.Эрдэнэболд: Түрүүн байнгын хорооны, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал дээр шинээр томилогдож байгаа, томилогдох гэж байгаа элчин сайдуудад нэр дэвшигч нарт бас хандаж зарчмын байр суурь, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, түүний дагуух гадаад бодлоготой холбоотойгоор тодорхой зүйлүүдийг хэлсэн байгаа. Одоо арай ерөнхий зүйлийг хэлэхэд 21 элчин сайдын 7 нь эмэгтэй байна. Улсын Их Хурал дахь хүний эрхийн

дэд хорооны даргын хувьд бас энэ дээр бас Гадаад харилцааны сайдад онцгойлон талархал илэрхийлж байна. Жендерийн мэдрэмжтэй байна. Судлаач, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Сумьяабаатарын ном дээр бичсэнээр 1220 оны луу жил анхны эмэгтэй элчин Монголоос Солонгос руу томилогдож байсан тухай бас тэмдэглэл байдаг. Тэгээд үүнчлэн бас эмэгтэй хүн дипломат албанд, тэр тусмаа бас Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын түвшинд ажиллах дээр бас энэ мэргэжлийн яам анхаарч байгаа нь сайшаалтай гэж үзэж байна.

Үүнтэй холбогдуулаад бас энэ нийгэмд болоод байгаа асуудал дээр би ерөнхий байр сууриа илэрхийлэх гэсэн юм. Элчин сайд 21, дэд сайд 15, 6 гээд 30-аад сайдын асуудал яриад иргэд олон нийт бас энэ дээр ингээд тодорхой хэмжээнд бас байр сууриа илэрхийлж байна. Энэ дээр яг энэ гадаад бодлогын нэг цонхны хүрээнд аль болохоор яг энэ Монгол Улсаа төлөөлөн тодорхой орнуудад явах гэж байгаа элчин сайдын асуудал дээр ямар нэгэн байдлаар улс төржих нь зохисгүй байх. Харьцангуй бас туршлагатай дээд тал нь 29 жил хүртэлх дипломат албаны туршлагатай хүмүүс орж ирж байгаа. Та бүхэн нэрээ хичээгээрэй. Улс орныхоо өрсөлдөх чадварыг бас ахиулж яваарай. Ямар нэгэн цэнхэр, улаан нүдний шилээр биш Монгол гэсэн зүрхний өнцгөөс асуудалд хандаарай гэж та бүхэнд хүсмээр байна.

2 дугаарт нь хэлэх боломж олдохгүй байсан учраас микрофон ашиглаад сүүлийн 1 минутдаа нэг зүйлийг яримаар байгаа юм. Гүйцэтгэх засаглалын бүтэц, хариуцлагын тухай хууль гээд өчигдөр бас их хурал дээр энэ хаврын чуулганаар оруулахаар энэ хуулийг бас ингээд өргөн барихаар явж байгаа. Энд энэ Засгийн газар сайн засаглалын асуудлыг бас ингээд нэлээн нухацтайгаар авч үзье гэсэн. Ер нь аливаа нам хамтраагүй Засгийн газар байгуулахдаа 9 сайдтай, хамтарсан тохиолдолд 13 хүртэл сайдтай байхаар ер нь олон улсын жишгээр ингээд ийм хуулийн төсөл хэрэгтэй юм байна гээд ингээд явж байгаа юм. Энэ утгаараа яг энэ туйлшрах хэрэггүй байгаад байгаа. Жишээлбэл дэд сайдын асуудал дээр Ардчилсан намын бүлэг байр сууриа илэрхийлсэн.

Гэхдээ нөгөө талаасаа бас тэр ор үндэсгүй үгүйсгэж бас болохгүй байгаад байгаа юм. Жишээлбэл, ажлын 5 өдрийн 2-т нь чуулган болдог. Тэр 2 чуулганд нь сайд нар энд байх ёстой. болчихдог. Цаашид нь төсөвт хөтөлбөр ажлууд явах хэрэгтэй болчихдог гээд. Тэгэхээр энд энэ намын дарга нар ба бас харилцан ярилцаад хамгийн зөв шийдэл рүүгээ оруулна. Хамгийн гол нь энэ төсвийг данхайлгахгүй бүтээмжтэй байх талаас нь анхаараасай гэж хүсмээр байна. Одоо ийм нэг харилцан популизм хийж улс төрждөг байдлаа таслан зогсоомор байна. Эцэст нь хэлэхэд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэлсэн үү? 1 минут өгье Эрдэнэболд гишүүнд.

С.Эрдэнэболд: Тэгээд 1 минутдаа багтаагаад та бүхнээс нэг асуулт асуучихъя. Бид нар их тийм шууруу явж байгаа он гарах гээд, чуулганаа хаах гээд. Тэгэхдээ энэ 21 хүн байгаа. Та бүхэн 30 секундэд багтаагаад энэ протокол явж байгаа. Тухайн орондоо очоод ямар ажлыг хамгийн түрүүнд Монгол Улсын төлөө Элчин сайдынхаа бүрэн эрхийн хүрээнд хийх вэ? Энийг протоколд үлдээмээр байгаа юм. Ингээд дараад нь та бүхний бүрэн эрх дуусахад чинь энэ амандаа хэр хүрсэн бэ гэдгийг үнэлэхэд энэ протоколыг ашиглана. Хариуцлага яригдах тохиолдолд энэ протоколыг ашиглана. Ингээд та бүхнийг 30, 30-н секундэд

багтаагаад 10 минут орчим болох байх. Та бүхэн өөрийн очиж байгаа орондоо ямар хүсэл тэмүүлэл эрмэлзлээр Монгол улсын өрсөлдөх чадварыг яаж нэмэгдүүлэх гэж, юуны төлөө очиж байгаа юм бэ гэдгийг чинь ард түмэн сонсох ёстой. Энэ бол шагнал биш ажил, хариуцлага гэдэг талаас нь иргэд олон нийтэд бас зөв ойлголт өгөх үүднээс та бүхэн энэ асуултад тус бүрд нь хариулахгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Тус бүрээс нь асуусан уу? 21 хүн хариулах юм байна тээ. 30 секунд хүртэл хугацаанд хариулъя гэсэн шүү. Хэнээс эхлэх вэ? 4 номерын микрофон дээр өөрийгөө танилцуулаад товчхон хариулаад хариулаад явчих.

Ц.Мөнх-Оргил: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсаас Франц Улсад суухаар нэр дэвшигдсэн Мөнх-Оргил байна. Томилогдож ажиллах хугацаандаа Монгол Улс Франц Улсын хоорондын харилцааны түвшнийг стратегийн түншлэлийн түвшинд хүргэе л гэсэн бодолтой байгаа. Яг одоогийн байдлаар АНУ, Япон, Герман, Солонгос, Казакстан, Турк, Энэтхэг, Итали гээд 8 улстай Монгол Улс стратегийн түншлэлийн харилцаатай байгаа. Энд Франц Улсыг нэмэгдүүлж, харилцааны түвшнийг худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын түвшнийг нэмэгдүүлэх бодолтой байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх ар араасаа зогсож байгаад хариулчихъя.

В.Оюу: Миний нэр Оюу. Би Тайландын Хаант Улсад Элчин сайдаар ажиллахаар нэр дэвшсэн. Тайландын хаант улсын зэрэгцээ мөн Малайз, Мьянмар, энэ Камбож зэрэг улсад хавсран суух юм. Тэгэхээр энэ 4 улс маань дөрвүүлээ АСЕАН-ын гишүүн. Ази-Номхон далайн бүс нутгийн чухал тоглогч нар. Энэ утгаараа энэ бүс нутаг тухайлан Тайландын Ван Хаант Улстай улс төрийн яриа хэлэлцээг эрчимжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс явуулж байгаа гадаад бодлого, ялангуяа энэ сүүлийн үед энэ Төв Азид бид нар гадаад харилцаа, улс төрийн яриа хэлэлцээгээ нэлээн сайн болгож авсан. Мөн Энэтхэг, Номхон далайн бүс нутагт та бүхэн мэдэж байгаа бол энэ жил Австралийн амбан захирагч айлчилсан. Монгол Улсын Ерөнхийлөгч мөн Энэтхэг улсыг айлчилсан. Одоо зүүн Өмнөд Азийн улс орнууд тухайлбал АСЕАН-ын улс орнууд руу бас чиглэсэн бид нар идэвхтэй бодлого явуулъя гэж байгаа. Энэ бодлогыг дэмжиж ажиллана. Тайландын.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх.

Г.Батжаргал: Батжаргал Казакстанд суух Элчин сайдаар нэр дэвшиж байгаа. Юуны өмнө Казахстан Улстай Монгол Улс стратегийн түншлэлийн харьцаанд хүрсэн. 2 орны улс төрийн харилцаа маш сайн байж байгаа. Мэдээж эдийн засгийн харилцааг цаашид нь өргөжүүлэх, худалдааг нэмэгдүүлэх тийм шаардлага бий. Энэ талаар 2024 онд Казахстан Улсын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлахдаа өнөөгийн байгаа худалдааны хэмжээг 500 сая долларт хүргэх тийм тохиролцоонд хүрсэн байгаа. Монгол Улс Евроазийн эдийн засгийн холбоонд гишүүнээр элсэж байна. Энэ 3 жилийн түр чөлөөт худалдааны хэлэлцээрийг ажил хэрэг болгох чиглэлээр юуны өмнө Казакстаны парламентаар түүнийг соёрхон батлуулах, түүнийг ажил хэрэг болгох чиглэлд би анхаарна. Казакстан Улс төв азидаа маш тийм нөлөө бүхий улс байгаа. Тийм учраас төв азийн орнуудтай Монгол Улсын бодлогыг чамбайруулах дээр би анхаарч ажиллана.

Ж.Бат-Эрдэнэ: Даргаагийнх нь.

Д.Баттөр: Эрхэм хүндэт гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая. Даваахүүгийн Баттөр. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад Элчин сайдаар явахаар горилогдож байна. Манай 2 орны харилцаа харилцан бие биеэ дэмжсэн найрсаг хамтын ажиллагааны зарчим дээр үндэслэгдсэн байдаг. Миний хувьд тодорхой яг хийгдэх ажил нэн тэргүүнд харагдаж байгаа юм ложистикийн асуудлыг анхааръя гэж бодож байгаа. Ардчилсан Лаос Ард Улс хойд талаараа БНХАУ-тай төмөр замын томоохон боомттой юм байна лээ. Тэгэхээр үндсэндээ манай улс руу Хятад Улсаар дамжаад ачаа бараа тээвэрлэх ийм бололцоо өргөжүүлнэ гэсэн ийм бодолтой байна. Транзит тээвэр хөгжүүлэх. Энэ бол хувийн хэвшил, хувийн хэвшлийнхэнд бас бараа таваараа тэдний зах зээл дээр гаргах, тэндээс манай руу ирэх бололцоог хөнгөвчилнө гэж үзэж байна.

Нөгөө талаас иргэдийн хувьд 2 улс агаарын харилцааны хэлэлцээртэй. Энэ хүрээнд наад зах нь манай иргэд тэр улсад очиход, тэндээс наашаа ирэхэд ачаа бараагаа Хятадын аль нэг нисэх буудал дээр авахгүй.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх цагтаа амжиж хариулъя.

Н.Энхтайван: Унгар Улсад нэр дэвшигч Нямцэрэнгийн Энхтайван байна. Миний бие Унгар Улсад ажиллах ийм үүргийн дагуу Унгар Улсынхаа талаар бас тодорхой судалгааг хийсэн. Үүн дотор юуны өмнө Унгар Улсад Монгол Улсаас нийт 6 мянга гаруй иргэд байгаа. Иргэд рүүгээ хандсан үйл ажиллагааг илүү идэвхжүүлэх, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах ажил дээр онцгой анхаарах шаардлагатай байна гэж харсан.

2 дахь зүйл худалдаа, эдийн засгийн харилцаа. Худалдаа, эдийн засгийн харилцаа өнөөдөр харахад харьцангуй чамлалттай байгаа. Энэхүү тоо хэмжээг одоо байгаа хэмжээнээс нь наад зах нь 2 дахин нэмэгдүүлэх ийм хүсэл зорилготой байгаа.

3 дахь барьж байгаа том чиглэл бол боловсрол, соёлын чиглэл. Манай улс түүхэндээ Унгар улстай боловсролын чиглэлээр, соёлын чиглэлээр өргөн хүрээтэй харилцаж эхэлсэн. Энэхүү үйл ажиллагааг илүү өндөр чиглэлд өндөр идэвхтэй явуулах ийм зорилготой байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

О.Лхагвасүрэн: Сайн байцгаана уу. Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн илрэхэд Элчин сайдаар нэр дэвшиж байгаа Очирын Лхагвасүрэн байна. Миний хувьд Бүгд Найрамдах Турк Улстай хамтын ажиллагаа, Монгол Улсын стратегийн түншлэлд хүрсэн энэ хамтын ажиллагааг бодит хэрэгжилт дээр хамгийн чухал ач холбогдол өгч ажиллах ёстой байх гэж бодож байгаа. Сая энэ 2025 оны 1 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд Найрамдах Турк Улсад өндөр хэмжээний ийм төрийн айлчлал хийсэн. Ингээд энэ айлчлалын үр дүнд буцаад Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч 2026 онд бас айлчлах ёстой. Энэ айлчлалыг зохион байгуулах хүрээндээ 2 орны худалдааны энэ тэнцвэргүй байдлыг арилгах чиглэл дээр хамгийн гол анхаарлаа хандуулах юм байна.

Өнөөдөр бол Турк Монгол Улсын хооронд худалдааны эргэлт нийтдээ 120-130 сая ам.доллар байгаа. Ихэвчлэн худалдаа явж байгаа. Хөрөнгө оруулалтын чиглэл маш бага байгаа. Тэгэхээр цаашдаа бол.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь.

Б.Болормаа: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Би Бүгд Найрамдах Чех Улсад Элчин сайдаар нэр дэвшиж байгаа Батсайханы Болормаа байна. Бүгд Найрамдах Чех Улс бол манай улсын маш чухал түнш. Энэ онд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой тохиож байгаа. Уламжлалт найрсаг харилцаатай явж ирсэн. Энэ онд Монгол Улсын Ерөнхийлөгч Чех Улсад төрийн айлчлал хийгээд айлчлалын үеэр харилцааны түвшнийг уламжлалт найрсаг харилцаанаас шат ахиулж иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэсэн. Хамгийн гол анхаарах асуудал гэж асуусан учраас би 2 асуудлыг онцлон хэлмээр байна. Иж бүрэн түншлэлийн түвшинд хүрсэн хэдий ч манай худалдаа эдийн засгийн харилцаа маш хоцронгуй явж ирж байгаа. Худалдаа 2024 онд жишээлбэл 18 сая ам.долларт хүрснээс манай экспорт 300 мянган ам.доллар байсан энэ зөвхөн ноос, ноолууран эдлэлийн экспорт байсан. Тэгэхээр би юуны түрүүнд худалдааг нэмэгдүүлэх, ялангуяа Монголын экспортыг нэмэгдүүлэх бүх боломжийг эрэлхийлж ажиллана.

2 дугаар асуудал бол иргэдийн асуудал байгаа. Чех улсад 15 мянга орчим Монгол ир.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх Эрдэнэболд гишүүн 50 секундэд гэсэн байх аа.

Д.Булган: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Миний бие Дансрангийн Булган Бүгд Найрамдах Итали Улсад суух элчин сайдаар нэр дэвшсэн хүн байна. Итали улс нь Европын Холбооны улсдаа аж үйлдвэрлэл болон машин механизм, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдгээрээ шилдэг тэргүүлэгч орнуудын нэг байдаг. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНИУ-д хийсэн айлчлалын хүрээнд 2 орон стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон. Энэ хүрээнд Стратегийн түншлэлийн хүрээнд нийт 14 тодорхой асуудлуудыг бас хөгжүүлэхээр хоёр тал харилцан тохиролцсон байгаа. Хугацаа бага байгаа учраас би товчлоод улс, төр эдийн засгийн харилцаанаас гадна шинжлэх ухаан, боловсрол, соёлын салбарын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх ийм өргөн боломж байгаа гэж үзэж байна. Энэ чиглэлд түлхүү анхаарч ажиллана. Мөн 500 гаруй иргэд сурдаг юм.

Г.Байгалмаа: Сайн байцаана уу? Би Гунаажавын Байгалмаа байна. Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар нэр дэвшсэн. Монгол Улс Беларусь Улс уламжлалт найрсаг харилцаатай улс. Манай 2 улсын хооронд хамтын ажиллагааны эрх зүйн орчин бүрэн бүрдсэн, хамтын ажиллагааны механизмууд сайн ажилладаг. Тухайлбал 2 улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замын зураглалыг Монгол Беларусын хооронд 3 жил тутам байгуулж, тэгээд 3 жил тутам энэ замын зураглалынхаа дүгнэлтийг хийж, цаашдынхаа зорилтыг дэвшүүлж ирсэн байгаа. Хэрэв Элчин сайдаар томилогдох юм бол хамгийн түрүүнд хийх ажил бол Монгол Улс Евразийн эдийн засгийн холбоотой байгуулсан түр хэлэлцээрийг Беларусын талаар бас батлуулах тал дээр хүчин чармайлт гаргаж ажиллана. Энэ хэлэлцээр хүчин

төгөлдөр болсноор манай Монгол Улсын Беларус Улсад гарах бараа, бүтээгдэхүүний нэр төрөл оршино. Мөн хэмжээ нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

2 дугаар гол асуудал бол хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллана. Яагаад гэвэл Беларус Улс.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх.

Д.Бямбадорж: Сайн байна уу Бямбадорж байна. Арабын Бүгд Найрамдах Египет Улсад Элчин сайдаар нэр дэвшиж байгаа. Кайр дахь ЭСЯ маань зөвхөн Египетээс гадна 6 ойрх Дорнодын болон Африкийн улсад хавсран хариуцдаг. Энэ үүднээс хамгийн түрүүнд очоод эдгээр улсуудтай улс төрийн яриа хэлэлцээг идэвхжүүлэх, Гадаад харилцааны яам болон бусад түвшний зөвлөлдөх уулзалтуудыг 1 дүгээрт хийх, 2 дугаарт бизнес эрхлэгч, 2 талын бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн харилцаа тогтоох хамтын ажиллагааг эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх. Би Тү Би 2 талдаа сурталчилж ажиллахаар төлөвлөж байна. Мөн Монгол Улсыг бүс нутагт сурталчлан таниулахад тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөж байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх.

Г.Оюун: Эрхэм гишүүд энэ өдрийн амгаланг эрье. Миний бие Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Ганболдын Оюун гэж хүн байна. Бүгд найрамдах Сингапур Улсаас гадна Бурнейг, Дарамсалам Улсыг хавсран суудаг. Энэ 2 улс маань хоёулаа найрсаг хамтын хамтын ажиллагаатай ийм 2 улс байгаа. Миний бие Улсын Их Хурал болон Засгийн газрын өгсөн үүрэг даалгаврыг нэг бүрчлэн биелүүлэн ажиллах болно. Мөн үе үеийн Элчин сайд нарын хийж гүйцэтгэсэн ажлуудыг үргэлжлүүлэн бэхжүүлж, хамтын ажиллагааг нь дэмжиж ажиллах бүх бүх талын дэмжлэгийг салбарын яамнуудаа холбох гүүр нь болж ажиллахыг хичээнэ.

Мөн түүнчлэн Сингапур улс маань өөрөө бага, дунд боловсрол болон дээд боловсролын чанарыг зэрэг хангаж чадсан тэргүүлэгч орны нэг. Ийм болохлоор би энэ нау хауг нь Монголынхоо тухайн салбар байгууллагуудтай холбож ажиллах гүүрийг иргэдийнхээ, иргэд төвтэй ийм эерэг.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч 3 номерын микрофон дээр.

Ж.Оюунбаатар: Эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Миний бие Жагдагийн Оюунбаатар. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Элчин сайдаар горилж байгаа. Герман Улс бол манай Монгол Улсын хувьд Европын Холбооны бүс нутагт хамгийн онцлох түнш. Монгол Улстай найрамдал хамтын ажиллагаа стратегийн түвшинд хүрсэн ийм улс байгаа. Тэгээд би ингээд батлагдаад очих юм бол хамгийн түрүүнд анхаарч ажиллах зүйл бол гадаад харилцааг эдийн засагжуулах энэ агуулгын хүрээнд 2 орны хооронд явагдаж байгаа худалдааны эргэлт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллана. Одоогийн байдлаар 2 улсын хооронд явагдаж байгаа худалдааны эргэлт бол 262 сая ам.долларын хэмжээнд эргэлдэж байгаа. Хөрөнгө оруулалтын хувьд 279 сая ам.долларын хэмжээнд явж байгаа. Энэ асуудал дээр бодитой ахиц гаргахын төлөө анхаарч ажиллана.

Дараагийн асуудал дээр Монгол Улсынхаа.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

Г.Хулан: Сайн байцгаана уу Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад нэр дэвшигч Ганбаатарын Хулан байна. Вьетнам улс нь манай Зүүн Өмнөд Ази дахь чухал түнш байгаа. Иж бүрэн түншлэлийн харилцаатай. Өнгөрсөн онд 2 улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тэмдэглэсэн байгаа. Цаашид 2 улсын харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулах, 2 улсын нөөц бололцоо давуу тал бүхий бараа, бүтээгдэхүүнийг харилцан нийлүүлэх тал дээр анхаарах болно. Үүний дотор хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт түлхүү анхаарч, 2 улсын хамтын ажиллагааны тулгуур багана болоход анхаарах болно.

Ялангуяа Вьетнамын зах зээлд манай мах, махан бүтээгдэхүүнийг ихэд сонирхож байгаа. 2 улс өнгөрсөн онд мал эмнэлгийн гэрчилгээг харилцан тохирсон. Энэ чиглэлд манай аж ахуйн нэгжүүдийг, ЖДҮ-лэлийг баялаг бүтээгчдийг дэмжих тал дээр түлхүү анхаарч ажиллах болно.

Мөн аялал жуулчлалын салбарыг дэмжихэд бас анхаарч ажиллах болно. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Дараагийнх нь.

А.Ананд: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Амгалангийн Ананд Арабын Нэгдсэн Эмират Улсад томилогдохоор нэр дэвшиж байгаа. Арабын Нэгдсэн Эмират Улс бол эдийн засаг, хөгжлөөрөө бүс нутаг төдийгүй дэлхийд тэргүүлж байгаа улсын нэг. Ирэх жил манай улс дипломат харилцаа тогтоосны 30 жилээ бас тэмдэглэнэ. Ирээдүйн 2, 3-н жилд төсөөлөгдөж байгаагаар хамгийн гол нь Монгол Улсын, 2 улсын бизнес хэлхээ холбоог сайжруулах, бизнес хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нэгд.

Хоёрт мэдээж манай улсын бүтээн байгуулах шаардлагатай байгаа төслүүдэд бас хөрөнгө оруулалт татах боломжтой гэж үзэж байгаа. Тэгээд 3 дахь нь мэдээж хүний хөгжил дээр анхаарч ажиллана. Яагаад гэвэл энэ уулсаас суралцаж явах, туршиж суралц суралцах маш их олон боломжууд байгаа гэж харж байна. Баярлалаа.

А.Баттөр: Миний бие Авирмэдийн Баттөр Болгар Улсад Элчин сайдаар нэр дэвшиж байгаа. Би энэ Болгар, Монголын угаасаа түүхэндээ хамтын ажиллагааны өргөн түүхтэй ийм 2 улс юм байна. Тэгэхээр харилцааг мэдээж хэрэг хуримтлуулсан туршлага дээрээ үндэслээд бүх салбарт, бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө чаддаг, мэддэг бүхнээ зориулна гэж ингэж бодож байгаа юм. Ер нь энэ Европын холбооны улсуудад суух гэж байгаа манай Элчин сайд дээр ч гэсэн бас энийг анзаарах нь зүйтэй гэж бодож байгаа. Яагаад гэвэл Европын холбоо гэдэг бас нэгдсэн 1 гадаад бодлоготой. Тэгэхээр тухайн улстай харилцаа мэдээж хэрэг хөгжүүлж таарна. Гэхдээ энэ бүгдийг Европын холбооны гадаад нэгдсэн бодлогын хүрээнд бид нар бас авч үзэхгүй бол болохгүй ийм юм байгаа.

Тэгэхээр Европын Холбооны гадаад бодлого дотор өөрийн улсын лоббиг улсуудыг бий болгож тэр удаа Европын холбоогоор дамжуулж асар олон юм хийх ийм боломж байдаг. Би бас Брюссельд ажиллаж байсан.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх.

Д.Даваа: Эрхэм гишүүдийн амрыг эрье. Миний нэр Дуламсүрэнгийн Даваа. Оросын Холбооны Улсад Элчин сайдаар нэр дэвшиж байгаа. Оросын Холбооны Улс бол манай уламжлалт сайн хөршийн харьцаатай, гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болсон ийм улс. Тэгээд иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээтэй. Сүүлийн жилүүдэд манай 2 орны өндөр, дээд түвшний айлчлалын давтамж ихсэж, итгэлцэл нэлээд бэхэжсэн. Энийг үргэлжлүүлээд идэвхжүүлж энэ ажиллахад гол анхаарлаа хандуулна. Энэний үр дүнд гэхэд хамгийн сүүлд 9 сарын 2-нд Бээжинд болсон 3 улсын Ерөнхийлөгчийн уулзалтын үеэр олон жил яригдаж, төлөвлөгдөж байсан газрын олон асуудлыг Монголын нутгаар тавихаар болж шийдвэр гарсан байна. Энэ чиглэлд дэмжих, энийг идэвхжүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллана.

Дээрээс нь Оросын Холбооны Улстай манайх гадаад худалдааны хувьд алдагдалтай.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх.

Л.Өлзийт: Сайн байцгаана уу? Миний нэр Лувсанжавын Өлзийт Энэтхэг Улсад элчин сайдаар горилж байгаа. Би Дели дэх Элчин сайдын яамны элчин зөвлөх хийдэг. Миний Элчин сайд болоод хамгийн түрүүнд хийх ажил бол мэдээж газрын тосны асуудал. Газрын тосны үйлдвэрийг 2028 оны 1 сард дуусна гэсэн гэрээтэй байгаа боловч би үйлдвэрийг хугацаанаас нь өмнө нь дуусгах бодолтой байгаа 1 дүгээрт.

2 дугаарт тодорхой яривал шууд нислэгийн асуудлыг хийнэ гэж бодож байгаа. Манай Монгол Улс Энэтхэг Улсын хооронд шууд нислэг байхгүй байгаа. Тэр нислэгийг хийнэ. Боловсролын систем дээр Ай Си-оор гээд Энэтхэгийн Соёлын соёлын яамны хүрээнд явдаг байгууллагад оюутнуудын тоог нэмэгдүүлнэ гэж бодож байгаа. Дээр нь нэмээд хэлэхэд 2 улсын хоорондын худалдааг нэмэгдүүлэхийн тулд.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь.

Д.Тэгшжаргал: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар нэр дэвшиж байгаа Дэмчигийн Тэгшжаргал байна.

Миний хувьд Элчин сайдаар ажиллах хугацаандаа 3 зүйл дээр онцгой анхаарч ажиллая гэж бодож байна. Монгол Улсын, төв Азийн нутгууд руу чиглэсэн гадаад бодлого сүүлийн жилүүдэд эрчимтэй маш идэвхтэй өрнөж байгаа. Өнгөрсөн 7 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал хэрэгжсэн. Хамгийн тэргүүн зэрэгт Евроазийн эдийн засгийн холбоотой байгуулсан түр хэлэлцээрийг соёрхон батлуулах асуудлыг очингуутаа хийнэ гэсэн ийм бодолтой байна.

2 дугаарт тээвэр, логистикийн асуудал байна. Тэгэхлээр Бишкек-Урумчи-Улаанбаатар гэсэн энэ 3 талт хэлэлцээрт Киргиз Улсыг нэмэлтээр оруулах, дөрөвдөгч талаар оруулах асуудлыг хөөцөлдөж ажиллая гэсэн ийм бодолтой байна.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь. Та хэдийн 30 секундэд асуудлаа багцалж өгч чадаж байна уу гэдгийг чинь шалгаад байгаа юм биш үү.

Д.Мөнхтөр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Элчин сайдаар нэр дэвшигч Доржраагийн Мөнхтөр. Австри Улс бол Европын холбооноос анхлан манай улсад дипломат харилцаа тогтоосон үнэт зүйл 1-д, гуравдагч хөрш. Гуравдагч хөршийн бодлогыг эдийн засгийн агуулгаар баяжуулах шаардлага бий. Тэгэхээр Австри Улсын эдийн засгийнх нь өөрсдийнх нь давуу тал болсон сэргээгдэх эрчим хүч, аялал жуулчлал, ЖДҮ-лэлийн тоног төхөөрөмжийг Монгол Улсад энэ чиглэлээр хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

Австри Монгол Улсын гадаад худалдааны нийт баланс 40 сая орчим доллар. Үүнээс 35, 5 буюу 7, 1 гэсэн харьцаатай байгаа. Тэгэхээр энэ зөрүүг багасгах, үүндээ хамгийн гол нь хувийн хэвшлийнхээ оролцоо, аж ахуйн нэгжүүдээ дэмжиж ажиллана гэж бодож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Австри Улсын Ерөнхийлөгч төрийн айлчлал хийж энэ хамтын ажиллагааны суурь тавигдсан. Айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарсан байгаа. Тэгэхээр энэ төлөвлөгөөгөөр хийх ажил маш их тодорхой бөгөөд нэлээд зүйл бий. Баярлалаа .

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх.

Б.Мөнхжин: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Элчин сайдаар нэр дэвшиж байгаа Батсүмбэрийн Мөнхжин байна. Британи бол манай бас чухал гуравдагч хөрш. Тэгэхээр харилцаа хамгийн түрүүнд анхаарах ёстой гол юм бол харилцааны түвшнийг ахиулах шаардлага байгаа юм билээ. Тэгэхээр энэ хүрээндээ ер нь бусад ажлууд нь энэ том малгайн дундаа ороод явчих байх гэж бодож байна.

1 дүгээрт улс төрийн харилцаа. Айлчлалын давтамж нэмэгдэх шаардлага байна.

2 дугаарт парламент хоорондын хамтын ажиллагаа, 2 парламентын хамтын ажиллагаа энэ бас идэвхжих нь Монголын парламентын хөгжилд бас их чухал гэж би боддог.

2 дугаарт Монгол бизнесийг Британид сурталчлах, үйл ажиллагааг нь дэмжих, зөв контакттай нь холбож өгөх энэ чиглэл бас чухал ажил гэж би боддог. Баярлалаа.

Г.Тэнгэр: Эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая. Австралийн Холбооны Улсад Элчин сайдаар нэр дэвшигч Гончигзэвэгийн Тэнгэр байна. Хавсран суух улс маань Шинэ Зеланд байгаа.

Би юуны түрүүнд бас Байнгын хороон дээр хэлсэн 2 жилийн дараа 2 улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ой болно. Үүнийг угтаж төрийн өндөр дээд хэмжээний айлчлалыг чанартай зохион байгуулахад анхаарна.

Хоёрт нь одоо ажил хэргийн шугамаар бэлтгэгдээд 2 талд тохирсон 2 хэлэлцээр байгаа. Нийгмийн хамгааллын хэлэлцээр, Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгаа. Энэ хэлэлцээрийг албажуулах ажилд анхаарна.

3-д нь Австрали Улс бол Монголчуудын хамгийн ихээр амьдардаг 3 дахь орон байгаа. БНСУ, АНУ-ын дараа. 22 мянган гаруй иргэн маань Австралид ажиллаж, сурч, амьдарч байгаа. Тийм учраас Консулын үйл ажиллагааг цогцоор нь иргэддээ үзүүлж, нээлттэй эдийн Элчин сайдын яам байх дээр анхаарч.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Болсон байна. Та ч хангалттай тодрууллаа л даа. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхэд талархаж байна. Баярлалаа. Батцэцэг сайдад баярлалаа. Би өмнөх сайдуудын томилгоо дээр бас үг хэлэхдээ Элчин сайдуудаа нууцлаач гэж хэлж байсан. Энэ нь бид нууцаар хэлэлцэх асуудал огт биш. Бид нарт өргөн мэдүүлэхээсээ өмнө, засгаар орохоосоо өмнө нийгэмд тэр сайдаар болох гэнэ гэдэг шүүмж аваад тэгээд тэр хүнийгээ харлуулах ийм ажиллагаа яваад энэ нь сүүлдээ нөгөө хүлээж авах улс нь өөрөө эргэж татгалзаад Монгол Улсын нэр хүндэд маш сөргөөр нөлөөлж байсан учраас нууцалж байгаад тэгээд оруулж ирээч гэдэг ийм асуудлыг дэвшүүлж байсан. Энэ бол Батцэцэг сайд, Гадаад хэргийн яам мэдээлэл алдаад байна гэхээсээ илүүтэй ямар нэгэн байдлаар л энэ нийгэмд сөрөг мэдээллүүд явж байсантай холбоотойгоор нууцлаач гэсэн хүсэлт гаргаж байсан. Энэ удаад яг л тэгж орж ирлээ.

Тэгээд Элчин сайдууд дандаа мэргэжлийн хүмүүс байна. Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан хүмүүс байна. Гадаад хэргийн дэд сайдаар ажиллаж байсан хүмүүс байна. Газрын дарга нараар ажиллаж байсан хүмүүс байна. Үнэхээрийн маш мерит, мэргэжлийн маш мундаг томилгоо байна. Баярлалаа. Баяр хүргэе.

Нэн ялангуяа бас 7 эмэгтэй Элчин сайдыг оруулж ирж байгаад үнэхээрийн бас баярлаж байна. Батцэцэг сайд өмнө нь бас 6 эмэгтэй Элчин сайдыг оруулж томилж байсан. Одоо дахиад 7 эмэгтэй Элчин сайдыг оруулж ирж байна. Дандаа дипломат албанд ажиллаж байсан эмэгтэйчүүд. 30 жил, 29 жил, 26 жил, 19 жил, 18 жил 17 жил дипломат албанд ажиллаж байсан хүмүүс одоо л Элчин сайдаар томилогдох ийм томилгоо болж байна. Ийм учраас баярлалаа. Цаашдын ажилд нь бас амжилт хүсье.

Би Даваа сайдаас өнөөдөр манай нийгэмд тулгамдаж байгаа хамгийн гол асуудлыг асуумаар байна. Та ОХУ-ын Элчин сайдаар өмнө нь ажиллаж байсан. “Эрдэнэс газр”-ын бас төлөөлөгчөөр ажилласан тээ. Энэ шатахуунтай холбоотой, түлшний хомсдолтой холбоотой нөхцөл байдал ямар байна вэ? Тулгамдаж байгаа асуудал юу байна вэ? Улсын Их Хурлын зүгээс юунд анхаарах вэ? Газрын талаар газ дамжуулах хийн хоолой Монгол улсаар дамжих энэ төсөл маань хэрэгжих нь үү

үгүй юу? Ер нь бид яг энэ тулгамдаж байгаа асуудлыг ойрын хугацаандаа болон урт, дунд хугацаандаа хэрхэн, яаж шийдвэрлэх вэ гэдэг тал дээр, хэрхэн яаж та ажиллах вэ гэдэг талаар асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Даваа нэр дэвшигч.

Д.Даваа: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Надаас 2 асуулт асуулаа гэж бодож байна. Тэгээд хоёрдугаархаас нь эхлээд явчихъя. Би ОХУ-д Элчин сайдаар ажиллаж байгаад 21 оны сүүлээр татагдаж ирсэн. Ингээд Ерөнхийлөгч Хүрэлсүх бол энэ маш чухал төсөл байгаа. Энэ газын хоолойн төслийг таныг урагшлуулаад ажил хэрэг болгоход онцгойлон анхаарч ажиллаач гэж ийм үүрэг, даалгавар өгч татаж авчирсан. Ингээд үүрэг өгч байсан. Тэгээд би энэ 3 жил гарангийн хугацаанд “Эрдэнэс газ” гээд газын хоолойн төслийн удирдагч гэдэг ийм албан тушаал дээр одоог хүртэл ажиллаж байна. Энэ хугацаандаа энэ газын хоолойн төслийн төлөвлөлтийг бүгдийг нь хийж дууссан. Тэгээд үндсэндээ өнөөдөр товчхондоо хэлэх юм бол барилга, бүтээн байгуулалтын ажил эхлэхэд бэлэн болсон гэсэн үг. Зураг төсвийг нь хийгээд экспертизээр батлуулаад газын хоолой явж өнгөрөх газрыг төрийн тусгай хэрэгцээнд авсан байгаа.

Энэ хоолой маань хэрэгжих болсон бодитой шийдвэр нь сая би түрүүн хэлсэн үгэндээ хэлсэн 9 сарын 2-нд тодорхой шийдвэрүүд гарсан. 9 сарын 2-нд ОХУ-ын “Газпром” компани БНХАУ-ын “Си Эм Пи Си” групп 2 бол хууль, эрх зүйн хариуцлага хүлээх “меморандум” гэдэг тийм бичиг баримтад гарын үсэг зурсан. Энэ бичиг баримт дээрээ газраа хүлээж авах хугацаа жишээлэх юм бол 31 оны 1 сарын 1-нд Монголын урд хил дээр газ хүлээлцэнэ гэдэг юм уу, 30 жилээр гэрээ хийнэ, жилийн дотор худалдах, худалдан авах гэрээгээ үзэглэнэ гэх мэтчилнээр маш чухал чухал заалтуудыг хугацаатай нь, хэмжээтэй нь ингээд заасан ийм чухал бичиг баримт байсан.

Ийм учраас энэ төсөл маань ойрын үед улам идэвхжиж, барилга, бүтээн байгуулалтын ажил эхлэх ийм боломжууд нь бүрдэж байгаа. Ингээд би бол ОХУ-д томилогдох Элчин сайд. Хэрвээ томилогдсон тохиолдолд би энэ чиглэлээрээ үргэлжлүүлж энэ ажлыг урагшлуулахад элчин сайдын хувьд нэлээн идэвх чармайлт гаргаж өөрөө хийж энэ төсөлдөө ажиллаж байсан хүний хувьд, мэдэх хүний хувьд нэлээн шаргуу ажиллая гэж бодож байгаа.

2 дахь асуудал энэ бензин, шатахууны асуудал. Бензин, шатахууны асуудлыг би нэлээн судалж үзсэн. Угаасаа намайг Элчин сайд байх үед манай Монгол Улсын хэрэглэж байсан хэрэглээнээс одоо бол жил болгон ингээд өсөөд байгаа юм байна лээ. Захиалгууд болохоороо зэрэг хуучнаараа яваад. Энэ нь юутай холбоотой юм гэхээр зэрэг энэ уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, тээвэрлэлт, бусад аж ахуйн ажил, энэ бүтээн байгуулалтын ажлууд энэ юмтай холбогдуулаад шатахуун, шатах тослох материалын хэмжээ жилээр, сараар ингээд өсөөд байгаа юм байна лээ. Би сүүлийн Элчин сайдынхаа ажлыг өгсний дараах энэ 4 жилд ч гэсэн бараг л бүх Засгийн газар хоорондын хэлэлцээрт ямар нэгэн байдлаар яг өөрийнхөө ажлын чиглэлээр оролцож энэ талаар сонсож байсан мэдээлэлтэй. ОХУ-аас ямар ч байсан энэ бензин, шатахууны асуудлыг бид нар таслахгүй, танай захиалгын дагуу өгнө, танайх харин хадгалах ийм нөөц савныхаа асуудлыг шийдээч гэж удаа дараа ярьж байсан. Саяхнаас Засгийн газар, Улсын Их Хурал дээр энэ савны асууд л яригдаад явж байгааг би аягүй зөв зүйтэй

асуудал байна. Ингээд энэ юм нь шийдчих юм бол тодорхой хэмжээний нөөцтэй болчих юм бол энэ тасалдлууд нь байхгүй болох юм байна лээ. Түүнээс тэр талаасаа өгөхгүй ч гэдэг юм уу, тэр нь бүтэхгүй байгаа ч гэдэг юм уу тийм.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Оройн амар амгаланг айлтгая. Монгол Улсыг төлөөлж гадаад улс орнуудад элчингээр суухаар нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдэд амжилт хүсье.

Гуравхан зүйл байна. Тухайн улс орнуудад амьдран суугаа иргэдийнхээ эрхийг хангах, төрийн үйлчилгээ үзүүлэх чиглэл дээр бид нэлээн онцгой анхаарах шаардлага байгаад байна. Нэг энэ асуудал байна.

Хоёр. Олон жил ярилаа энэ дипломат байгууллагууд харилцааг эдийн засагжуулах, худалдаажуулах, Монголын эдийн засгийн тэлэлт, хөгжлийг хангах талаар онцгой анхаарч ажиллая бараг л бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийе гэцгээж ярьцгаасан. Нэг ч их хүссэн хэмжээнд очоогүй болов уу. Би тэгж бодоод байдаг юм. Тэгэхээр энэ тал руугаа нэлээн сайн анхаармаар байна. Дан дамаа энэ үйлдвэржилт хөгжчихсөн улс орнуудад хүлэмжийн хийн чиглэлээр тодорхой хэмжээний хөрөнгүүд байгаад байна. Энийг шингээх чадвар нэмэгдүүлнэ гэдэг байдлаар юм уу энэ Монголын цөлжилтийг бууруулна гэдэг чиглэлээр үндсэндээ бараг дүйцүүлэн хамгаалалтын чиглэлээр хөрөнгө Монгол руу ороод ирэх бололцоо байгаад байгаа юм байна лээ. Энэ мэтчилний асуудлууд руу нэлээн гол анхаарал хандуулж нэлээн сайн ажиллах хэрэгтэй байна гэдгийг нэг хэлчихмээр байна.

Гурав дахь зүйл 2 хөршөөс авхуулаад бас дэлхийн гуравдагч хөршүүдтэй томоохон томоохон төслүүд хамтарч хэрэгжүүлж байгаа. Энэ том төслүүдийн бүтээн байгуулалтыг үр дүнтэй явуулах бас тодорхой бүтээгдэхүүн 100 хувь нэг улс орноос хамааралтай импортлогдож байна. Энэний тасалдалгүй байх энэ тэр гээд энэ зүйлүүд дээр гол анхаарал тавигдах ёстой. Даваа Элчин сайд ер нь энэ нефть бүтээгдэхүүн, газрын хоолой, Монголын бас арай хямд өртөгтэй эрчим хүч ашиглая гэвэл тэр УЦС-уудтай холбоотой хойд хөршийн хязгаарлалт яригдаад байдаг үүнийг зөөлрүүлэх, бас зөвшөөрлийн түвшинд хүргэх тал руу анхаарал нэлээн сайн төвлөрөх ёстой болов уу. Ингэж байж хэдүүлээ хамтдаа энэ улс орны хөгжлийг түргэтгэх чиглэл рүү бас нэлээн зохих үр дүн гарах болов уу гэсэн ийм бодол байна. Тэгээд та бүгдэд ажлын амжилт хүсье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн.

М.Мандхай: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд орж ирж байгаа нийт Элчин сайдаар томилогдох гэж байгаа та бүгдэд бас ажлын амжилт хүсье. Тэгээд би бас яг адилхан Батцэцэг сайдад бас талархсанаа илэрхийлмээр байна. Энэ удаагийн орж ирж байгаа Элчин сайдууд бүгд мэргэжлийн, өмнө нь энэ салбартаа ажиллаж байсан туршлагатай, олон улсыг бас төлөөлж ажиллаж байсан ийм туршлагатай хүмүүс орж ирж байгаад бас үнэхээр бас талархаж хүлээж авч байгаа.

Тэгэхдээ нэг өмнө нь болж байсан олон бас кэйс, асуудлууд албаны ч бай, албан бус ч бай томилогдож очиж байсан бас асуудлууд үүсэж үүсдэг. Тэгэхдээ энэнтэй холбоотойгоор бас та бүгдэд нэг анхааруулаад нэг зүйлийг бас хэлэхгүй болохгүй байх гэж бодож байна. Энэ нь өөрөө элчин сайдын албан тушаал нь өөрөө төрийн нууц, албаны мэдээлэл, ёс зүй, ялангуяа энэ хувийн ёс зүйн өндөр хариуцлагатай байх ёстой. Тэгэхээр энд бас зарим нэг хүмүүс бас өөр өөр салбарт ажиллаж байгаад бас яг энэ гадаад харилцаанд бас үүрэг гүйцэтгээд ингээд явсан туршлагатай хүмүүс бас байгаа. Тэгэхлээр ер нь албан үүргийн энэ явцад хууль, ёс зүйн зөрчлийг гаргахгүй байх, ашиг сонирхлын энэ эрсдэл үүсэх аливаа нөхцөлд аль болох орох орохгүй байх, нэн даруй яамандаа бас мэдэгддэг, заавар, чиглэл бас авдаг энэ үүрэг, хариуцлагаа маш сайн биелүүлээсэй гэж бас хүсэж байна.

Мөн Элчин сайд ганцхан өөрөө албан ёсны төдийгүй гэр бүлийнхээ бас энэ гишүүдийнхээ үйл ажиллагаанд хүртэл энэ хариуцлагатай хандах ёстойг бас анхааруулж хэлье гэж бодож байна. Тэгээд та бүгдэд бүгдэд нь амжилт хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Дуламын Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд баяр хүргэж, амжилт хүсье. Би нэг элчин сайдууддаа мэдээлэл хүргэх гэсэн юм. Энэ ямар мэдээлэл вэ гэхээр хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл гэж байгууллага байгаа. Энэ байгууллагатай та бүхэн маань хамтарч ажиллаарай. Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлөөс манай Их Хуралд хүсэлт ирүүлсний дагуу яг өнгөрсөн жил буюу жилийн өмнө 24 оны 12 сарын 20-нд Монгол бол Улсын Их Хурал дээр Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах дэмжих бүлэг гэдэг бүлэг байгуулагдсан шүү. Лобби бүлэг гэж бид нар нэрлэсэн, нэрлэдэг. Энэ бүлгийг одоогийн байдлаар миний бие ахалж ажиллаж байгаа юм. Тийм учраас энэ хилийн чанад дахь Монгол иргэдийнхээ асуудлаар та бүхэнтэйгээ бас цаашид хамтарч ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлмээр байна. Энэ би ганцаараа байгаа биш манай Их Хурлын 19 гишүүн гарын үсэг зурсан. Манай Батцэцэг сайд жишээ нь энэ дотор байх жишээтэй. Ийм лобби бүлэг байдаг юм шүү. Тэгээд энэ лобби бүлэгтэйгээ та бүхэн маань хамтран ажиллаарай. Хилийн чанад Монголчуудын зөвлөлтэйгөө хамтран ажиллаарай гэж хүсэж байгаа юм.

Энэ “Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл”-өөс ирдэг түгээмэл хэдэн асуудлууд байдаг юм. Энийг би бас та бүхний сонорт хүргэчихье гэж бодож байна. Нэг нь юу вэ гэхээр энэ төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа E-Mongolia, түүнчлэн сонгуульд цахимаар оролцох хүсэлт зүйл үед маш их ирж байгаа. Яг энэ хүсэлтийг эрэлт хэрэгцээг нь үндэслээд бид нар Их Хурал дээр E-Mongolia-гийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сонгуульд цахимаар оролцох боломж, бололцоог судалж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Миний бие бас яг энэ ажлын хэсгийг ахлаад ажиллаж байгаа. Санал, дүгнэлт нь бараг бэлэн болчихсон удахгүй танилцуулагдахаар байгаа гэдгийг хэлмээр байна.

Дараагийн нэг асуудал энэ нийгмийн даатгал болоод цалин тэтгэврийн тухай асуудал байдаг. Энийг та бүхэн мэдэж байгаа. Ер нь 2 орны Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нэлээд их шийдэгддэг. Манай улс одоогоор 7, 8

улстай бараг Засгийн газрын хэлэлцээр хийчихсэн байгаа байх. Энэ асуудлыг та бүхэн маань бас анхаарч ажиллаарай.

Бас нэг 3 дахь та бүхэндээ захих зүйл байна. Ялангуяа олон Монголтой улс орнуудад сая дурдсан Солонгос байна, Чех байна, Австрали байна, Англи байна, Франц, Герман байна. Энд Монгол хүүхдүүдийнхээ хэл соёлын асуудлыг хариуцсан тийм сайн дурын гэж хэлж болох энэ сургалтын төвүүд байдаг юм. Энэ сургалтын төвүүдийг ажиллуулж байгаа багш болоод иргэд маань дэмжлэг их хүсдэг юм шүү. Энийг гадаад яамтайгаа хамтраад ЭСЯ-дууд маань энэ хүмүүсээ дэмжиж ажиллаарай. Энэ хүмүүс маань тэнд өсөж, бойжиж байгаа хүүхдүүдээ Монгол хүн болгохын төлөө хүчин чармайлт гаргаж ажиллаж байдаг.

Дараагийн нэг зүйл болохоор гадаадад ажиллаж байгаа бизнес эрхлэгчид маш их дэмжлэг хүсэж байгаа. Энэ дээр та бүхэн маань анхаараарай.

Бас нэг зүйл тэнд наадам болдог, цагаан сар болдог, бөх барилддаг, сур харвадаг. Энэ тамирчид маань улсын наадмын цол зэрэгтэй болох тухай хүсэлтийг бас уламжилдаг. Ийм зүйлс байгаа гэдгийг онцлон дурдмаар байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбүрэн гишүүн.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе. Манай гадаад харилцаа сайн байгаа. Ялангуяа өндөр дээд хэмжээний айлчлалууд харилцан айлчлалууд их олон хийгдэж байна. Үр дүнтэй болж байгаа. Гадаад харилцаа, гадаадын дипломат төлөөлөгчийн газруудын хувьд ч гэсэн өмнө нь их сонсогддог байсан янз бүрийн хууль зөрчсөн муу муухай зүйлүүд их яригддаг байсан. Сүүлийн жилүүдэд чимээгүй болсон.

3-д энэ удаагийн томилгоо маш сайн, мэргэжлийн томилгоо болж байна гэж хүн болгон ярьж байгаа. Бүгдээрээ урамтай, баяртай байна. Хоёрхон зүйл хэлэх гэсэн юм.

1 дүгээрт бид нар Элчин сайд нар ч гэсэн заагаад бусад манай Засгийн газрын гишүүд ч гэсэн байнга л ярьж байгаа нэг зүйл бол очиж яриад энэ улсыг визгүй болгох гэж байгаа гээд л ярьцгаадаг. Ялангуяа Солонгост визгүй болгохын тулд ийм яриа хийж байна, тийм яриа хийж байна гээд ингээд яваад байдаг. Тэгээд бид нар нэг л зүйлийг ойлгох хэрэгтэй юм билээ. Тэр нэг хүнд ноогдох ДНБ-ээ дор хаяж 10 мянган доллар болгож байж энэ улсууд чинь манай улсад иргэдийг визгүй болгох юм билээ. Тэрнээс их сайн хүн очоод эд нар визгүй болгочихдог тийм зүйл байхгүй юм билээ шүү гэдгийг бүгдээрээ ойлгох хэрэгтэй.

Тийм учраас бид нар хөрөнгө оруулалт яаж олж ирэх вэ гэдэг зүйл дээр л дотно, гаднагүй бүгдээрээ анхаарч нэг ойлголттой болж ажиллах шаардлагатай болчихоод байгаа. Одоо бид нар баахан энд тэндхийн Засгийн газартай хэлэлцээр хийгээд зээл авчихсан, зээлээ хэрэгжүүлж чаддаггүй хий хүү төлөөд явж байгаа олон төсөл, хөтөлбөрүүд байгаа. Тийм учраас энэ томилогдож байгаа Элчин сайд нар тэр тухайн тухайн оронтой хийсэн зээлийн хэлэлцээрүүдийн араас тэр их сайн явах шаардлагатай гэж ингэж бодож байгаа.

Дахиад ийм мэргэжлийн хүмүүс орж ирж байгаад их баяртай байна. Ялангуяа би энэ Туркт томилогдож байгаа Элчин сайд үнэхээр бас энэ олон жил энэ нөгөө хөрөнгө босгох чиглэлээр, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан хүн байгаа Лхагвасүрэн гэж. Хөрөнгө оруулалт ерөөсөө маш муу байгаа Туркээс. Тийм учраас энэ чиглэлээр их ажил хийгдэх байх гэж итгэж, найдаж, хүлээж байгаа. Тэгээд бүгдэд нь ажлын амжилт хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Сархадын Зуллхар гишүүн алга байна. Жигжидийн Чинбүрэн гишүүн алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Нэр дэвшигч нарыг дэмжиж байгаа гэдэг зүйлээ хэлье. Яг бүгдээс нь асуулт асууна гэхэд бас олон хүн байгаа учраас ерөнхий бас 2, 3 зүйл дээр бас Батцэцэг сайдаас бас анхаараач гэж хүсэж байгаа юм.

1 дүгээрт ер нь цаашдаа энэ элчин сайдын энэ томилгооны асуудлыг ярихаасаа өмнө өмнөх элчин сайдын тайланг ерөнхий байдлаар ч гэсэн сонсдог болмоор байна. Юун дээр анхаарах, ямар ажлын үр дүнгүүд гарсан юм, ингэж байж бас дараа дараагийн бас юу гэдэг юм энэ асуудлууд дээр их бодитой санал, шүүмжээ хэлэх болов уу гэж би бодож байгаа юм.

Тэгэхээр энэ аливаа нэг томилгоо болоод, энэ ажил хүлээлцэх, дараагийн хүн томилогдох энэ үе шатууд дээрх дундын энэ процесс ер нь байхгүй болчихоод байгаа. Бид хэд хэдийгээр зөвшилцөх энэ асуудал дээр байгаа боловч тодорхой түвшинд бас өмнөх хүмүүсийн бас ажлын тайлан, хийсэн зүйл, цаашид бас анхаарах зүйлсийг бас яг бодитойгоор сонсдог болмоор байна. Энийг бас цаашдаа бас аль хууль дээрээ байх ёстой юм үе шатууд дээр бас оруулж өгөөч. Магадгүй яг ажлаа өгөхөөс өмнө байж болно, ажлаа өгсний дараа энийг зохион байгуулж болно. Нөгөө хүмүүс, Элчин сайдууд маань эргүүлэн татагдаж ирээд бас тодорхой ийм мэдээллүүдээ өгдөг. Угаасаа энэ чинь нэг л төрт улс байна. Цаашдаа шинээр томилогдсон хүндээ мэдээж ажлын протоколын хувьд захиx юмаа хэлж байгаа байх гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ нэг үе шатыг бас нэг анхаарч оруулж ирж өгөөч гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт, би энэ Элчин сайдуудын томилгооны энэ асуудлыг уг нь Улсын Их Хурал хаалттай хэлэлцэх ёстой л гэж бодоод байгаа юм. Тэгээд энэ удаад харьцангуй мэргэжлийн хүмүүс орж ирж байгаа учраас их тайван амгалан байна. Ер нь тэгээд үе үе энэ Элчин сайдуудын томилгооны асуудал дээр ингээд улс төр болдог, болсон болоогүй ингээд янз бүрийн худал мэдээллүүдийг өгдөг. Энэ чинь олон нийтэд нээлттэй байгаа. Нөгөө хүлээж авагч улсын маань тодорхой этгээдүүд энийг чинь хараад сууж байгаа байхгүй юу. Тэгээд ингээд нэр дэвшиж томилогдох хүнээ анхнаас нь эвгүй байдалд оруулчихдаг ийм зүйлүүд байна. Худал, үнэн мэдээллээр.

Тэгэхээр уг нь захиас, даалгавраа ч гэсэн бас чөлөөтэй хэлэхэд уг нь энэ процессыг нэг их олон нийтээс нуух гээд байгаа зүйл биш. Ер нь бас нэг хаалттай хэлэлцэх энэ горим байвал уг нь их зүйтэй юм болов уу гэж хувьдаа боддог оо гэдэг зүйлийг хэлмээр байна.

Түрүүн аль нэр дэвшигч рүү хариулав эдийн засгийн асуудлыг нэлээн чухалчилна гээд. Бүх Элчин нэр дэвшигч нар маань энийг анхаарч өгөөч. Эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг. Монголын энэ дотоодын үйлдвэрлэгч Монголын зах зээлээс энэ тус улсад та бүгдийн очиж байгаа улс дээр л тодорхой түвшинд Монголд үйлдвэрлэсэн энэ бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ гардаг, эсвэл тэр улсаас манайд хөрөнгө оруулалт орж ирдэг, технологи орж ирдэг бид суралцмаар байна, бид хамтарч хөгжмөөр байгаа. Тэгэхээр энэ рүү чиглүүлж илүү анхаараач гэдэг зүйлүүдийг бас хүсэж байна. Энэ.../минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

П.Сайнзориг: Гадаад паспортыг хүчин чадлыг нэмэгдүүлэх буюу “Global passport power rank” дээр манайх 62-т байна. Визгүй зорчдог 38 улс виз, хил дээр виз авах боломжтой 40 улс, 120 улсыг бид нар заавал виз авч байж зорчихоор байна. Тэгэхээр энэ асуудал дээр Монгол Улсын иргэдийн зорчих асуудал дээр бас тодорхой түвшинд ахиулах ажлыг Элчин сайдууд маань бас анхаарч өгөөч гэдэг зүйлийг бас хүсэж байна.

Хамгийн сүүлд Австрали Улсад Монголчууд бас нэлээн олноор байна. Энэ дээр бас анхаарах зайлшгүй шаардлагууд байна. Харилцан тэр тэтгэврийн асуудлууд байж болно, эргээд тэнд төрж байгаа хүүхдүүдийн бас харьяалал, үйлчилгээ авахаас эхлээд олон зүйлүүд тулгамдаж байгаа. Тэгээд би бас Франц болон Итали улсад нэр дэвшиж байгаа 2 эрхмийг хувийн эрх зүйн чиглэлд зөвхөн худалдаа, эдийн засгаасаа гадна Франц болон Италид маш олон тэр олон улсын байгууллагын төвүүд байгаа. Энэ дээр хувийн эрх зүйн чиглэлд ахиц дэвш.../минут дуусав./

Н.Учрал: Хэн хариулах вэ? Франц, Итали нэр дэвшигчид хариулах уу? Мөнх-Оргил сайд. Мөнх-Оргил сайд 4 дүгээр микрофон.

Ц.Мөнх-Оргил: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Монгол улс Их газрын эрх зүйн тогтолцоотой учраас ер нь Франц, Германы эрх зүйн тогтолцоотой их ойролцоо. Бид ч гэсэн ер нь эрх зүйн шинэчлэлээ хийхдээ Герман, Францын эрх зүйн туршлагаас нэлээн туршлага судалж ажилласан л даа. Энэ утгаараа эрх зүйн тогтолцоонууд нэлээн дөхөмтэй. Тэгээд Сайнзориг гишүүний хэлж байгаа энэ худалдааны эрх зүй, ялангуяа энэ хувийн эрх зүйн салбарыг хөгжүүлэхэд анхаарч ажиллая. Энэ дээр ялангуяа манай Хууль зүй, дотоод хэргийн яам, Хуульчдын холбоо, Шүүгчдийг давтан сургах төв, Прокуроруудыг давтан сургах төв гээд энэ мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах асуудал дээр анхаарч ажиллана.

Н.Учрал: Сайнзориг гишүүн тодруулъя. 4 дүгээр микрофон. Итали нэр дэвшигч Хулан.

Г.Хулан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Итали Улсад суугаа Элчин сайдын яам маань НҮБ-ын бас Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын байгууллагатай хариуцан ажилладаг. Энэ 26 оныг Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил болгон тэмдэглэхтэй холбогдуулаад Монгол Улсын Засгийн газар 24 оны 10 сарын 30-ны өдөр тогтоол баталсан. Энэ хүрээнд бас бид идэвхтэй

хамтран ажиллах ёстой. Тогтоолд үндсэндээ 61 улс хамтран зохиогчоор нэгдсэн байгаа. Энийг бас анхаарч ажиллана.

Мөн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хүрээнд хэрэгжүүлж байгаа тодорхой төсөл, хөтөлбөрийн хүрээнд холбогдох байгууллага, яамтай хамтран ажиллах болно.

Н.Учрал: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Нэр дэвшигч нар бас амжилт хүсье. Ялангуяа би Франц, Италид нэр дэвшиж байгаа хүмүүс маань туршлагатай хүмүүс байна. Зөвхөн худалдаа, эдийн засгаасаа гадна энэ хувийн эрх зүйг хөгжүүлэхэд маш тус дөхөм болох олон улсын томоохон байгууллагуудын төвүүд ажиллаж байгаа. Ялангуяа Италид олон улсын хувийн эрх зүйн байгууллага байгаа. Энэтэй бас Хууль зүй, дотоод хэргийн ийм харилцаагаа өргөжүүлэх гэж хичээж байгаа. Маш олон том дата баазууд байдаг. Боловсон хүчнийг чадавхжуулах чиглэлд бүрэн боломжтой байна. Цаашдаа бид нар бас энэ арилжааны шүүхийг байгуулах асуудал дээр илүү их анхаарахад та бүгдийн бас оролцоо чухал байгаа шүү гэдэг зүйлийг бас энэ ташрамд хэлье.

Тэгээд Тайланд мөн адил. Яагаад гэхээр Азийн энэ улсад маш олон олон улсын байгууллагууд байгаа. Идэвхтэй ба харилцааг өргөжүүлэх чиглэлд бас анхаарч өгөөрэй гэдэг зүйлийг хүсье. Тэгээд Батцэцэг сайдыг ерөнхийд нь энэ тайланг сонсох ажлыг цаашдаа бид нар ямар байдлаар зохион байгуулбал илүү их бодитой ажил хэрэгч болох вэ гэдэг дээр бас дараа дараагийн удаа бодооч гэдэг зүйлийг бас хэлж байна. Хэлмээр байна.

Н.Учрал: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн алга байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Л.Энх-Амгалан: Монгол Улсаас Элчин сайдаар томилогдохоор орж ирж байгаа Элчин сайд нартаа амжилт хүсье. 1 дүгээрт.

2 зүйлийг хэлье гэж бас бодож байна. 1 дүгээрт нь сүүлийн 3-4 жилд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн гадаад бодлого, гадаад улс орнууд дээр маш их идэвхтэй бодлого явуулсан. Маш их идэвхтэй бодлого явуулсан. Олон ч улс оронд амжилттай айлчлалтай олон ч улс орнуудын төрийн дээд хэмжээний айлчлалыг Монгол Улс зохион байгууллаа. Бас Батцэцэг сайдад бас талархах ёстой гэж би бодож байна. Тэгээд одоо цөмөөрөө жаахан ажил хийдэг ард түмэн болох ёстой. Ажил хийдэг. Энэ Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр хийгдсэн энэ бүх гэрээ, хэлэлцээрүүдийг бид нар ажил хэрэг болгох ёстой. Ингэж байж Монгол Улс эдийн засгийн хувьд тусгаар тогтносон улс болно оо бодитойгоор.

Тэгэхээр нэг талаасаа их тийм азтай Элчин сайд нар томилогдож байна гэж бодож байна. Яагаад гэвэл цоо шинэ юм хайгаад байх ерөөсөө шаардлага алга та нарт. Гадаадын хөрөнгө оруулалтыг Монголд ихэсгэх, ингээд энэ томоохон мега төслүүдийг эхлүүлж байгаа улс орнууд дээр Элчин сайд нар томилогдож байна. Францад Мөнх-Оргил сайд маань “Орано”-гийн гэрээ, Энэтхэгт томилж байгаа Элчин сайд маань мэдээж энэ газрын тосны үйлдвэр, Орост сууж байгаа Элчин

сайд маань энэ газрын хоолой гээд энэ 3 төслийг л бид нар хөдөлгөхөд Монголын GDP даруй 1, 2 дахин өсөх ийм бодитой бололцоо бас байгаа. Ажил нь эхэлчихсэн. Ингэж чадах юм бид нар ДНБ-д 1 хүнд ноогдох ДНБ-ээ 8, 9 мянган доллар хүргэчих, жинхэнэ утгаараа эдийн засгийн тусгаар тогтнолыг авах ийм бололцоонууд бас байна Элчин сайд нар аа. Энийг та бүхэн бүүр онцгойлон анхаарах ёстой гэж бодож байна.

2 дугаар асуудал өмнө хийсэн гэрээ, хэлцлүүдээ ажил хэрэг болгомоор байна. Европын холбооны улсуудад гол гол улсуудад Элчин сайд нар томилогдож байна. Франц, Герман, Болгар гээд. Нөгөө Европын холбоотой хийсэн бид нар чинь 7 мянга гаруй бараа, бүтээгдэхүүнүүдийг татварын хөнгөлөлттэйгөөр Европын холбоонд гаргана гэсэн. Хэчнээн жил болж байна? 15, 16-н жил болж байна. Энэ ерөөсөө амилдаггүй ийм гэрээ байгаад байдаг. Маш их том бололцоо би байх ёстой гэж харж байгаа. Нэг үеэ бодох юм бол Монголын баялаг бүтээгч нар, үйлдвэрлэгч нар бас харьцангуй бүтээгдэхүүнүүд нь олон улсын Европын стандартад нийлэх ийм бүтээгдэхүүнүүдийг гаргасан. Энийг ажил хэрэг болгох ёстой.

2 дугаарт нь дөнгөж сая Улсын Их Хурлаар батлагдсан Евроазийн гэрээ 200 тэрбум долларын эдийн засаг руу алхах, орох ийм томоохон хаалга нээгдэж байгаа. Тийм учраас энэ Төв Азид гол гол улсуудад томилогдож байгаа Элчин сайдуудын хүлээх үүргүүд би маш их чухал ийм хариуцлагатай цаг үед та бүхэн томилогдож байна. Энийгээ ажил хэрэг болгох ёстой.

Ер нь цаашдаа жил бүхэн энэ Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороон дээр энэ Элчин сайд нарынхаа тэр тусмаа энэ мега төсөл хэрэгжүүлэх гэж байгаа улс оронд томилогдож байгаа Элчин сайд нарынхаа асуудлуудыг Батцэцэг сайд бас оруулж ирж ажлынх нь нөхцөл байдал, тулгамдаж байгаа тулгамдаж байгаа асуудлуудыг бас хэлэлцдэг, ярьдаг, дүгнэлт хийдэг нэг ийм тогтолцоо нэг ийм механизмыг бид нар зайлшгүй бий болгох ёстой гэж харж байгаа юм. 1 минутаа нэмээд авчих уу.

Н.Учрал: 1 минут нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Тийм учраас одоо бас Улсын Их Хурлаас та бүгдийг дэмжлэг авна гэж бодож байна. Та бүгдийн ажил бол оччихоосоо илүү өнөөдөр энэ танхимаас та бүгдийн ажил эхлэх ёстой гэж ойлгож байгаа. Тэгээд үнэхээр та бүгдийн энэ Элчин сайд байх үед энэ ажлууд маань бодитой ажил хэрэг болгож магадгүй Монгол Улсын хувьд бид нар GDP-гээ 2 дахин өсгөх та бүгдийн Элчин сайдаар томилогдож байгаа хүмүүсийн хувьд бас нэг Элчин сайдаар ажилласан өв үлдээх, Iedasy үлдээх ийм түүхэн боломжууд бас байгаа шүү гэдгийг бас та бүхэн онцгойлж анхаар.

Эцэст нь хэлэхэд энэ гадаадын хөрөнгө оруулалтууд Монголд их буурч байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтууд. Зөвхөн уул уурхайн салбарт л нийт гадаадын хөрөнгө оруулалтын 70-80 хувь нь байна. Энэ үндсэндээ ширгэж байгаа. Тийм учраас энэ чиглэл рүү та бүгдийн онцгойлж ажиллах ажиллах, анхаарлаа хандуулж ажиллах салбар бол энэ. Уул уурхай босож байж, гадаадын шууд хөрөнгө оруулалтууд бий болж байж Монгол Улс бас эдийн засгийн тусгаар

тогтнолоо олох ёстой юм гэж ингэж харж байгаа. Ингээд та бүгдэд бас ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Н.Учрал: Энх-Амгалан гишүүн үг хэллээ. Батсуурь гишүүн байна уу? Байхгүй байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Элчин сайдуудад нэр дэвшигч нарт амжилт хүсье. Монгол Улсын бас гадаад бодлого сүүлийн хэдэн жил маш их идэвхтэй байгаа. Үүнийг байгуулсан гэрээ, улс хоорондын авч хэрэгжүүлэхээр тохирсон яриа, хэлэлцээрүүдийг ажил хэрэг болгоход та бүгдэд бэлэн гарын авлага, бэлэн хөрс суурь байгаа гэж би ойлгож байгаа. Тийм учраас энэ тал дээр нэлээн идэвх чармайлттай ажиллаарай.

Гадаадын Элчин сайдуудыг Монголд, ер нь энэ Элчин сайдуудыг харж байхад 2 зүйл дээр л онцгойлон анхаардаг юм байна лээ.

1 дүгээрт нь тухайн орныхоо бизнес, хөрөнгө оруулалтын асуудлыг дэмжих тал дээр шууд ил, тод ярьдаг болсон. Энэ чиглэлээр та бүгд маань их идэвх санаачилга гаргаж, манай ихэнх орнууд худалдааны хувьд бас алдагдалтай байгаад байгаа. Энийг тэнцүүлэх асуудал их чухал байгаа.

2 дугаарт ажиллах хүчний асуудал дээр бас их анхаарал хандуулдаг. Ялангуяа манай улс гадаадад ажиллах хүч гаргадаг улсын хувьд тэндэх ажиллах хүчээ 1 дүгээрт хамгаалах, дэмжих ийм асуудал чухал.

2 дугаарт тэнд байгаа хүмүүсийг буцааж Монголд авчрахад ялангуяа манайд хүний нөөцийн дутагдалтай томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхэд хүний нөөц хүчин дутмаг байгаа энэ үед төр, засаг мөн бизнес эрхлэгчдийг холбож ажиллах тал дээр идэвх санаачилгатай ажиллаарай. Олон улсын хөдөлмөрийн эрх зүй, тухайн орны ажил хөдөлмөр эрхэлж байгаа маш олон цагаач ажилчдын асуудал олон улсад нэлээн хүчтэй яригдаж байгаа. Зөвхөн саяхан манай Монгол Улс л гэхэд л 1 иргэний амь настай холбоотой асуудал дээр нийгэм даяараа л донсолж байна шүү дээ.

Тэгэхээр манай маш олон иргэд маань гадаадад бас тэр болгон Элчин сайдын яамандаа очихгүй ч гэсэн энд тэнд хувиараа очоод ажил хөдөлмөр эрхлээд, хохироод, амь, нас эрүүл мэндээрээ хохирсон олон хүн гардаг. Энэ тал дээр та бүгд маань хууль, эрх зүйн дэмжлэг дэмжлэг болон мөн нөгөө талаас тэндээс очиж байгаа иргэдэд анхааруулга, янз бүрийн хүний наймаа, бусад төрлийн гэмт хэргүүдэд холбогдох эд нар зүйл дээр бас маш их идэвхтэй ажиллах шаардлага байна.

Оюуны хөрөнгө оруулалт тал дээр ялангуяа нэлээн анхаарал хандуулах дээр дэмжиж ажиллаарай гэдгийг хэлмээр байна. Тухайлбал, тухайн улсын хууль, эрх зүйн орчин, онц өндөр хөгжчихсөн энэ геополитик, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үед улс орнуудын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ. Үүнийг энэ манай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход маш их дэм болдог.

Тухайлбал, Герман гэхэд сая манай Өргөдлийн байнгын хорооны ажиллах журам бараг 1945 оноос хойш бэлэн кэйс байж байгаа. Тэрийг бид нар авчирч

ирээд ингээд ажиллахад ямар ч асуудал байхгүй ингээд ажиллаад явж байдаг. Түүн шиг манай хууль, эрх зүйг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг харж байгаад түүнтэй холбоотой парламентын бүлгийн гишүүд байгаа тэд нартайгаа маш их идэвхтэй ажиллаарай гэдгийг бас захиж хэлмээр байна.

Ингээд бас Элчин сайдуудын тэр тайлан, мэдээлэл гэдгийг явцын дунд нь бас асуугаад, яриад явах болов уу гэж би Байнгын хороон дээр яригдсан гэж ойлгосон учраас асуулт асуухаа больё. Тэгээд бүгдэд нь амжилт хүсье.

Н.Учрал: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн. Даваасамбуугийн Ганмаа гишүүн. Энэ байхгүй гишүүдийг хасаарай. Орж ирээд дараа нь олон юм яриад байдаг юм.

Д.Ганмаа: Өнөөдөр бид Монгол Улсын гадаад ертөнцөд төлөөлөх төрийн бодлого, үндэсний ашиг сонирхол, олон улсын тавцанд хамгаалах чухал үүрэг бүхий Элчин сайдуудыг хэлэлцэж байна Улсын Их Хурлаар. Юуны түрүүнд нэлээн олон гишүүд ч хэллээ. Энэ хүрээнд нэр дэвшигчдийг мэрит зарчмаар ажилласан, олон жил туршлага хуримтлуулсан ёс зүйтэй, салбартаа ер нь танигддаг, мэддэг ийм сайн candidate-уудыг оруулж ирсэнд талархаж байна. Баяртай байна, дэмжиж байна.

Энэнтэй холбоотой бусад гишүүдтэй давхардахгүйгээр 2 зүйл хэлмээр байгаа нь одоогийн энэ эрүүл мэндийн асуудлууд нь юу гэдэг юм манай Монгол Улсын ялангуяа энэ гадаад бодлогын зайлшгүй хэсэг болчихсон энэ бүх улс орноороо хүлээн зөвшөөрөгдсөн тэр байтугай эрүүл мэндийн дипломат бодлого гэдэг нэр нэршил явдаг. Тэрэнтэй холбоотой юу гэсэн үг вэ гэхээр Гадаа харилцааны яам өөрийнхөө бүх “channel”-ийг ашиглаад тухайн улсынхаа эрүүл мэндийг яаж бодох вэ, яаж бодлогыг нь тусгах вэ, хэрэгжилтээ яах вэ, тэнд сууж байгаа бүх дипломатуудаа ашиглаад хүний нөөц эдгээр асуудлуудыг бүгдийг нь эм хэрэглэл, аюулгүй байдал, хариуцлагын тогтолцоо гэх мэтийн бүх асуудалд ханддаг. Эдгээр ажил дээр энэ эрүүл мэндийн дипломат бодлогыг манайд өнөөдөр томилогдох гэж байгаа Элчин сайдууд маань бүүр бүтэн анхаарч ажиллаач гэж хүсэж байна. Бид нар их эдийн засаг ярьдаг, уул уурхай ярьдаг, мөнгө төгрөгөө нэмэх тухай ярьдаг боловч эцсийн эцэст Монгол Улсын хамгийн том капитал болох Монгол хүн, тэр дотроо Монгол хүний эрүүл мэнд, боловсрол гэдэг асуудал чинь эдийн засгийн хамгийн том нөлөөлөх хүчин зүйл гэдгийг санаж байх ёстой.

Тэр утгаараа яг Монголтой холбоотой хамгийн их хамтарч ажиллаж байгаа гэх үү дээ гадагшийгаа хүмүүсээ явж их эмчлүүлдэг улс орнуудынх Турк байна, Сингапур байна, Тайланд байна, Энэтхэг байна, Герман байна. Саяын нэрлэсэн улсуудаас. Эдгээр улсуудад томилогдож очиж байгаа хүмүүс маань яг энэ эрүүл мэндийн дипломат бодлого нь ямар байх вэ, ямар зарчим баримтлах вэ, одоо нөхцөл байдал ямар байгаа юм, энийг яаж сайжруулах вэ гэдэг ийм тусгайлсан бүүр тийм шалгуур үзүүлэлт бүх ийм бодлоготойгоор асуудалд хандаж холбоотой, харилцаатай ажиллаасай гэж үнэн сэтгэлээсээ хүсэж байна. Би энийг бас мартахгүйгээр та хэдэд сануулж ярих болно.

2 дахь асуудал нь болохоор Арабын Нэгдсэн Улс, Египет Улс Франц Улсад эдгээр улсуудтай жишээлбэл Харвардын их сургуульд гэхэд эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээ нөөц, хүмүүсийг яг энд бэлддэг байсан тусгайлан бүр. Тусгайлан бэлдсэний хүч дээр энэ хүний нөөцийгөө маш сайжруулж авсан. Тэгэхлээр энийг бас туршлага болж манайхан хэрэгжүүлээсэй гэж зайлшгүй хүсэж байна. Даргаа минутаа авчихъя нэмээд нэгмөсөн ярьчихъя.

Н.Учрал: Ганмаа гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Д.Ганмаа: Жишээлбэл Франц Улсад тэр Леондонд Глобакан юм уу эсвэл Айр Ки гээд бүүр хавдрын маш том тандалт судалгаа хийдэг олон улсын бүх улсын бараг төлөөллүүдийг оруулсан том төв байдаг. Энэ дээр Монгол Улсын энэ хавдрын өвчлөл, хавдрын нас баралттай холбоотой мэдээ, мэдээлэл дээр бүрэн бүтэн сайн ажиллаж өгөөсэй гэж туршлагатай Мөнх-Оргил гишүүнээс хүсэж байна. Египетэд болохоор чинь хүний нөөц, эм, эмийн аюулгүй байдал, хэрэгсэл эдгээр дээр бас маш олон жилээр ингээд хамтарсан олон төрлийн ажлууд хийгдсээр байгаад чадавхаа маш сайжруулчихсан. Эдгээр дээр мөн яг Монголдоо энэ туршлагыг нь яг аваад Монголынхоо хөрсөнд тааруулсан энэ бодлогыг хэрэгжүүлэхэд бас туслаасай гэж үнэн сэтгэлээсээ хүсэж байна.

Герман, Туркт Монголын эмч нар маш их ажилладаг. Өөрийн гэсэн эмнэлгийг байгуулчихсан. Эдгээрийг бас Монгол Улстайгаа хамтарч expert-уудаа татах ажлуудыг сайн хэрэгжүүлээрэй. Баярлалаа.

Н.Учрал: Ганмаа гишүүн санал хэллээ. Чинбатын Номин гишүүн байхгүй байна. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Би асуулт асуухгүй тодорхой санал хэлэх гэсэн юм. Энэ бол бараг энд байгаа бүх Элчин сайдуудад бүгдэд хамаатай. Ялангуяа Батцэцэг сайдыг бас онцгой анхаарч сонсоорой гэж хүсэж байна. Та бүгд очоод Гадаад харилцааны ямаар дамжуулаад нэг тодорхой асуудлаар бид нарт дэлгэрэнгүй мэдээллийг явуулах хэрэгтэй байна. Энэ ямар асуудал вэ гэхээр удахгүй Улсын Их Хурлаар Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх тухай хууль өргөн баригдах гэж байгаа. Тэгэхлээр мэдээж та хэд яваад очоод ажилдаа орох хугацаа хэрэгтэй. Ер нь хаврын чуулганаар энэ асуудал өргөн баригдаж хэлэлцэгдэх учраас хагас жилдээ багтаагаад энэ чиглэлийн мэдээллийг маш дэлгэрэнгүй ирүүлээч гэж би хүсэж байна.

Энд юу байх ёстой юм бэ гэхээр энэ гадаад орнуудын энэ хар тамхи, мансууруулах бодистой тэмцдэг энэ хууль, эрх зүйн орчин нь ямар байдаг юм, алдаа оноо нь юу байсан юм, ямар сургамж гарсан, юм сайн туршлага нь юу байсан юм. Энэ зүйлийг бид нарт бид нар мэдэх нь их чухал байна. Яг үнэндээ хэлэхэд одоо ингээд Улсын Их Хурлаар хууль өргөн баригдана, ажлын хэсгийн хэдэн гишүүн ажиллана. Бидэнд энэ талын нарийн мэдлэг, мэдээлэл, туршлага их хомс байгаа.

Тийм учраас бид энэ гадаад орнуудын мэргэжилтэй боловсон хүчнээ яаж бэлдэх юм, сэтгэл зүйчдээ хэрхэн яадаг юм, алийг нь яг гэмт хэрэг гэж үздэг юм, алийг нь донтолт гэж үзээд эмчилдэг юм, энэ өсвөр насны залуусаа хэрхэн эндээс хамгаалдаг юм, урьдчилан сэргийлдэг юм, зөв мэдлэг, мэдээллийг нийгэм нь яаж одоо энэ төр засаг нь яаж анхаардаг юм гэдэг мэдээлэл маш хэрэгтэй байна. Энэ өмнө нь энэ БНСУ-д ажиллаж байсан одоо энэ Германд суухаар нэр дэвшиж

байгаа Оюунбаатар гуай надад Солонгосын мэдээллийг тухайн үед маш сайн ирүүлж байсан. Энэ бас их тухайн үедээ хэрэг болсон. Үүнээс гадна мэдээлэл ирүүлэхээс гадна тухайн орныхоо холбогдох байгууллагуудтай бас хамтарч ажиллахад бид нар онцгой анхаар хэрэгтэй байна. Өмнө нь Вьетнам, Лаосод сууж байгаа Элчин сайдын яамнууд бас холбогдох байгууллагуудтай хамтрах ажиллах энэ зүйл дээр нэлээд дэмжлэг үзүүлээд бас амжилттай ажилласан.

Ялангуяа Турк, ОХУ-д сууж байгаа Элчин сайдуудыг би онцгой анхаараасай гэж хүсэж байна. Энэ талын чиглэлийн бодисууд орж ирдэг яг хар тамхинд мансууруулах бодис гээд хэлэхэд хэцүү. Тэгэхээр энийг бусад орнууд яаж тодорхойлдог юм, тэгээд манайх чинь юмандаа их удаан ханддаг бүгдийг нь хуульд суулгачихдаг. Гэтэл тэнд ингээд Засгийн газар нь дор нь дор нь ингээд л энэ энэ хориотой гээд ингээд олон улсууд хоорондоо сүлжээ болчихсон ингээд гарч ирээд байгаа. Тэгэхээр энэ чиглэлийн зүйлүүдийг сайн хэлж өгөөч.

Н.Учрал: Одонтуяа гишүүн санал хэллээ. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн байхгүй байна. Цэндийн Баатархүү гишүүн байхгүй байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн байхгүй байна. Далайн Батбаяр гишүүн байхгүй байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн байхгүй байна. Жудгийн Баярмаа гишүүн байхгүй байна. Ганбат гишүүн байхгүй байна.

Гишүүд асуулт асууж хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Элчин сайдыг эгүүлэн татах асуудлаар санал хураалт явуулна. Их Хурлын гишүүд танхимд цуглая. Гишүүд танхимд цуглая. Үг хэлж, санал хэлж, асуулт асууж, хариулт авч дууслаа.

Их Хурлын гишүүд танхим цуглая. Бүлгийн дарга нар Батжаргал дарга гишүүдийг дууд. Цогтгэрэл дарга яасан. Гишүүд танхим цуглая. Санал хураалт явууллаа. Үг хэлж, асуулт асууж, хариулт авч дууссан. Энэ чинь Их Хурал чинь тусдаа дэгтэй. Тэгээд дэгийнхээ хуулийн дагуу хуралдаанаа зохион байгуулдаг. Дэгийн хуулиа л сахиулъя. Ингээд нэрээ өгчихнө тэгээд цаг тухайд нь байхгүй, тэгээд дуртай үедээ орж ирээд үг авъя гэж хэлнэ. Энэ Элчин сайд нарын томилгоог олон нийт анхааралтай ажиглаж байна. Нээлттэй хэлэлцдэг ийм дэгтэй. Ялангуяа тухайн улсад ямар хүн манай Элчин сайдаар томилогдож байгаа вэ гэдгийг бас олон нийт дэлхий дахинд бас анхааралтай ажигладаг. Тийм учраас бид нар өнөөдөр энэ үг хэлж байгаа, асуулт асууж байгаа асуултууд улс орныхоо бас энэ аюулгүй байдалтай холбоотой чухал асуудлуудыг хөндөж байгаа учраас мэдээж гишүүд нэлээн судалгаа шинжилгээтэй асуултуудыг асууж байна.

Монгол Улсын төрийн гадаад бодлого, үзэл баримтлалынхаа хүрээнд идэвхтэй явж байгаа. Цаашдаа бас гадаад харилцаагаа өргөжүүлэх, илүү эдийн засагжуулах чиглэлээр томилогдож байгаа Элчин сайд нар анхаарч ажиллах хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд манай гадаад бодлого, үзэл баримтлалынхаа хүрээнд нэлээд идэвхтэй өрнөж байна. Тэгээд үүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн манлайлал, Монгол Улсын Засгийн газар, Гадаад харилцааны сайдын бас идэвх, оролцоо маш өндөр. Тийм ч учраас энэ удаагийн Элчин сайд нарын томилгоо бол хуулийнхаа хугацаанд бүрэн эрх нь дуусаад эгүүлэн татах Элчин сайд нарыг татаад энэ гадаад харилцааны салбарт мэргэшсэн нэр дэвшигч нарыг та бүхэнд өнөөдөр бас танилцуулж байна.

Нийгэм, олон нийтийн зүгээс ч гэсэн Элчин сайдад нэр дэвшүүлж байгаа энэ нэр дэвшигч нарт бол бас өөрсдийнхөө санал бодлыг илэрхийлж байна. Нийгмийн зүгээс ч гэсэн бас эерэг хандлагатай байгаа нь сайн хэрэг. Тийм учраас Элчин сайд нарыг Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар бас гишүүд маань дэмжиж нэлээдгүй үг хэллээ. Олон бас саналуудыг хэллээ, олон санаачилга гаргаж, бас захиаснуудыг хэллээ. Тэгээд Элчин сайдад нэр дэвшигч нар маань анхаарна биз. Тэгээд санал хураалтад ч гэсэн бас чуулганы хуралдаанд оролцоогүйгээр эсрэгээр нөгөө татгалзсан байдлаар гаргах нь бас зохимжгүй. Тийм учраас зарим гишүүдийг бас орж ирэхийг хүлээж байна. Давхар бас доор Байнгын хорооны хурал, хэлэлцүүлэг тэгээд Ерөнхий сайд дээр бас уулзалтууд давхацсан байгаа юм байна. Ардчилсан намын бүлгийн дарга, Ардчилсан намын дарга болон зарим гишүүд Ерөнхий сайд дээр уулзалттай байгаа юм байна гэж ойлголоо.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулна. Нэг ирцийн санал хураалтыг эхэлж явуулъя. Ирцийн санал хураалт.

Санал хураалт явуулна. Засгийн газрын гишүүд. Санал хураалт явуулна.

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэнг энэ чинь тус тусад нь явуулна биз дээ? Чөлөөлөхийг нь хамтад нь явах юм байна.

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэнг;

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Мижиддоржийн Цэнгэгийг;

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайханыг;

Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Лхагвасүрэнгийн Саянааг;

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жигжээгийн Сэрээжавыг;

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бирвагийн Мандахбилэгийг;

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Энхтүвшингийн Булганыг;

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Нарантунгалагийг;

9.Монгол Улсаас Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баттөмөрийн Энхсүхийг;

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржийн Баярхүүг;

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Ганхуягийг;

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өлзийсайханы Энхтүвшинг;

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Сосорбарамын Энхбаярыг;

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гомбосүрэнгийн Мөнхбаярыг;

15.Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сайннямбуугийн Баатаржавыг;

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Уламбаярын Нямхүүг;

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Дамдины Гансүхийг;

18.Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатарыг;

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбажавын Ганболдыг;

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөрийг;

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэн нарыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Гишүүдийн 73 нь дэмжиж, 74.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо Байнгын хорооны саналаар Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Одоо Байнгын хорооны саналаар Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтын бэлэн байдлыг хангуулъя.

1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэрийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 70 дэмжиж, 71.4 хувиар саналаар санал дэмжигдлээ.

Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэлд үлдээе. Зулпхар гишүүн. Зулпхар гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн нарыг дэмжсэнээр тэмдэглэлд үлдээе.

2.Монгол Улсаас Бүгд найрамдах Австрали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг томилох тухай саналыг.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

Гишүүдийн 72 нь дэмжиж, 73.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгалмааг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Гишүүдийн 73 нь дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалт.

Гишүүдийн 74 нь дэмжиж, 75.5 хувиар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хуланг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 73 нь дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатарыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 74 нь дэмжиж, 75.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчимбуугийн Бямбадоржийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 74 нь дэмжиж, 75.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булганыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 71 нь дэмжиж, 72.4 хувиар санал дэмжигдлээ.

9.Монгол Улсаас Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжинг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 67 дэмжиж, 68.4 хувиар санал дэмжигдлээ.

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

Гишүүдийн 74 нь дэмжиж, 75.5 хувиар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргалыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

72 гишүүн дэмжиж, 73.5 хувиар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

73 гишүүн дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянгыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

74 гишүүн дэмжиж, 75.5 хувиар санал дэмжигдлээ.

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэнг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

70 гишүүн дэмжиж, 71.4 хувиар санал дэмжигдлээ.

15.Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайванг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

71 гишүүн дэмжиж, 72.4 хувиар санал дэмжигдлээ.

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

72 гишүүн дэмжиж, 73.5 хувиар санал дэмжигдлээ.

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормааг томилох тухай саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. Санал хураалт.

73 гишүүн дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

18.Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар Амгалангийн Анандыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

73 гишүүн дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийтийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

70 гишүүн дэмжиж, 71.4 хувиар санал дэмжигдлээ.

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюуг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

73 гишүүн дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөрийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

73 гишүүн дэмжиж, 74.5 хувиар санал дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр олонхын санал авсан Элчин сайдад нэр дэвшигч нартаа ажлын амжилтыг хүсье. Баяр хүргэе.

Төрийн гадаад бодлогыг бас тогтвортой хэрэгжүүлж, гадаа Монгол Улсын гадаад харилцааг эдийн засгийн хамтын ажиллагаагаар өргөжүүлэн тэлж ажиллахыг хүсье.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хурлаас албан бичгээр мэдэгдэх болно. Баярлалаа.

2 санал хураалт байгаа гишүүд ээ. 2-хон санал хураалт байна.

16.58 цаг

Энэ нөгөө Евроазийн хэлэлцээртэй холбогдуулсан тогтоол дээр асуулт асууж, үг хэлж дууссан байгаа.

Одоо санал хураалт явуулна.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе гишүүд. Санал хураалтад бэлтгэе.

Байнгын хороо “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

50 гишүүн дэмжиж, 51 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд дахин санал хураалтад бэлтгэе.

50 гишүүн дэмжлээ. 51 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалтын бэлэн байдлыг хангая.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал Их Хурлын гишүүдийн олонхоор дэмжигдсэн тул Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт.

62 гишүүн дэмжиж, 63.3 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг эцэслэн баталлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье.

Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт дуусаагүй байгаа тул, энэ асуудлыг түр хороо хэлэлцэж дуусаагүй тул өнөөдөр хэлэлцэх боломжгүй.

Өнөөдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.01 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

